

Иргэн түншлэгч болох нь

БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ЯВЦАД
МЭДЭЭЛЭХ, ЗӨВЛӨЛДӨХ,
ОЛОН НИЙТИЙГ ОРОЛЦУУЛАХ

ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА,
ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА
(ЭЗХАХБ)-ын ГАРЫН АВЛАГА

Марк Грамберггер бэлтгэв

ЭЗХАХБ 

ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

1960 оны 12-р сарын 14-ний өдөр Парис хотноо гарын үсэг зурж, 1961 оны 9-р сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болсон энэ Конвенцийн нэгдүгээр бүлэгт заасны дагуу ЭЗХАХБ нь:

- Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж дэлхийн эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахын сацуу гишүүн орнуудын ажил эрхлэлт, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг тогтвортой, дээд түвшинд хүргэх,
- Эдийн засгийн хөгжлийн явцад гишүүн хийгээд гишүүн бус орнуудын эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах,
- Олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу, хэнийг ч үл ялгаварлан, олон талт дэлхийн худалдааг тэлэн өргөжүүлэхэд хувь нэмэр оруулах гэсэн чиглэлээр бодлого явуулдаг билээ.

ЭЗХАХБ-ын ууган гишүүд нь Австри, Бельги, Канад, Дани, Франц, Герман, Грек, Исланд, Ирланд, Итали, Люксембург, Нидерланд, Норвеги, Португали, Испани, Швед, Швейцарь, Турк, Английн Нэгдсэн Вант Улс, АНУ эдгээр бөгөөд хожим гишүүнээр элссэн улс орнуудыг элссэн он, сар, өдрийнх нь хамт жагсаавал: Япон/1964.4.28/, Финлянд/1969.1.28/, Австрали/1971.6.7, Шинэ Зеланд/1973.5.29/, Мехик/1994.5.18/, Бүгд Найрамдах Чех Улс /1995.12.21/, Унгар/1996.5.7/, Польш/1996.11.22/, Солонгос/1996.12.12/, Бүгд Найрамдах Словак Улс /2000.12.14/ эдгээр болно. Европын Хамтын нийгэмлэгийн Зөвлөл /ЭЗХАХБ-ын конвенцийн 13-р зүйлд заасны дагуу/ тус байгууллагын үйл ажиллагаанд оролцдог.

Энэ бүтээл DES CITOYENS PARTENAIRES

Manuel de L'OCDE sur l'information, la consultation, et la participation á la formulation des politiques publiques гэсэн нэрээр франц хэлээр хэвлэгдсэн.

© Зургийг Ласло Квитт /László Quitt/ зурав.

© ЭЗХАХБ 2001

Энэ бүтээлийг АНУ-аас бусад улс оронд арилжааны бус зорилгоор анги танхимд хэрэглэхдээ Centre francais d'exploitation du droit de copie (CFC), 20, rue des Grands-Augustins, 75006 Paris, France, tel. (33-1) 44 07 47 70, fax (33-1) 46 34 67 19 гэсэн хаягаар, АНУ-д the Copyright Clearance Center, Customer Service, (508)750-8400, 222 Rosewood Drive, Danvers, MA 01923 USA, or CCC Online: www.copyright.com гэсэн хаягаар, мөн хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, орчуулахад OECD Publications, 2, rue André-Pascal 75775 Paris Cedex 16, France гэсэн хаягаар тус тус хандаж, зохих зөвшөөрлийг авч болно.

Удиртгал

Бодлого боловсруулах явцад олон нийтийг мэдээллээр хангах, зөвлөлдөх, оролцуулах тухай ЭЗХАХБ-ын энэхүү гарын авлага нь ЭЗХАХБ-ын гишүүн болон гишүүн бус улсуудын төрийн албан хаагчдад зориулсан практик удирдамжийн шинжтэй юм. Эл гарын авлага бол бодлого боловсруулах явцад иргэдийг мэдээллээр хангах, зөвлөлдөх хийгээд тэднийг хамран оролцуулах ерөнхий хүрээг тодорхойлох практик үйл ажиллагааны тань “замыг заагч” болох ёстой бөгөөд улс орон бүрийн онцлого, төр болон иргэдийн хоорондын харилцааг бэхжүүлэх зорилт, түүний тулд авах арга хэмжээний өвөрмөц талуудыг зохих ёсоор тусгасан болно. Чингэснээрээ энэ гарын авлага ямар нэг бэлэн жор буюу тодорхой гаргасан шийдлийг өгч байгаа юм биш. Гэхдээ бодлого боловсруулах явцад тухайн улс орны иргэдийг мэдээлэл хүлээн авах, зөвлөлдөх, оролцох бололцоогоор хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдад тулгардаг үндсэн асуудлууд, гаргаж болох шийдвэрийн төрөл бүрийн хувилбаруудыг дэлгэн харуулахыг зорьсон болно.

Гарын авлагад дурдсан бодлогын заавар сургамж болон жишээнүүдийг ЭЗХАХБ-ын гишүүн улсуудын хоёр жилийн хамтын чармайлтын үр дүнд бий болсон “Иргэн түншлэгч болох нь”: Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах” хэмээх ЭЗХАХБ-ын илтгэлд тулгуурлаж хийсэн нь бодлого боловсруулах явцад иргэдэд мэдээлэх, зөвлөлдөх, оролцоог нь нэмэгдүүлэх чиглэлээр тэдгээр улс орны авсан арга хэмжээнүүдийн тухай харьцуулсан мэдээлэл маш сайн эх сурвалж болж өгсөн билээ. Илтгэлийн үндсэн дүгнэлт, бодлогын заавар сургамжийг бодлого боловсруулагчдад зориулж хураангуйлсаныг ЭЗХАХБ-ын вэб хуудаснаас мөн үзэж болно.

Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах тухай ЭЗХАХБ-ын энэ гарын авлагыг харилцааны асуудлын зөвлөгч Марк Грамбергер (marc@gramberger.com), ЭЗХАХБ-ын Нийгмийн удирдлагын албаны Жоанн Каддитай хамтран туурвисан бөгөөд зураг чимэглэлийг зураач Ласло Квит хийж, илтгэлийг ЭЗХАХБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Дарга эрхлэн хэвлүүлсэн болно.

Агуулга

Мэндчилгээ.....	7
Гарын авлагыг хэрхэн хэрэглэх вэ?	10

I БҮЛЭГ

Төр иргэдийн харилцаа яагаад хэрэгтэй вэ?

Төр, иргэдийн харилцаа гэж юу вэ?	15
Төр, иргэдийн харилцааг яагаад бэхжүүлэх шаардлагатай вэ?	18
Ямар өртөг зардал гарах вэ?	21

II БҮЛЭГ

Төр, иргэдийн харилцааг хэрхэн бэхжүүлэх вэ?

Ерөнхий хүрээг тодруулах нь	27
Мэдээллийн ямар элементийг хэрэглэдэг вэ?	28
Зөвлөгөөний ямар элементийг хэрэглэдэг вэ ?	32
Идэвхтэй оролцооны элементүүдийг хэрхэн ашиглах вэ?	36
Үнэлгээний ямар элементийг хэрэглэдэг вэ?	37
Ямар ерөнхий чадавхийг хөгжүүлэх вэ?	38
Стратегийн үүднээс төлөвлөж ажилла!	41
Ямар зорилгууд тавих вэ?	42
Хэнд хандах вэ?	43
Арга хэрэгсэл, түүнийг хэрхэн сонгох вэ ?	44
Хөрөнгө хүчний талаар	45
Үнэлгээг хэрхэн төлөвлөх вэ?	47
Арга хэрэгслүүдийг сонго, ашигла!	49
Ямар арга хэрэгслүүд байдаг вэ?	49
Мэдээлэлд ямар арга хэрэгслийг ашиглах вэ ?	52
Зөвлөгөөнд ямар арга хэрэгсэл хэрэглэх вэ ?	56
Идэвхтэй оролцоонд ямар арга хэрэгсэл ашиглах вэ ?	60
Үнэлгээнд ямар арга хэрэгсэл ашиглах вэ ?	64
Мэдээлэл холбооны шинэ технологи /МХТ/-ийг ашиглах нь	67
МХТ яагаад хэрэгтэй вэ?	67
МХТ-ийн хэрэглээг дэмжих хүрээний талаар?	69
МХТ мэдээлэлд хэрхэн туслах вэ?	71
Зөвлөлдөх болох идэвхтэй оролцоонд МХТ хэрхэн тус дөхөм үзүүлдэг вэ?	75
МХТ-ийг үнэлгээнд хэрхэн хэрэглэх вэ?	78

МХТ-ийн сул тал, тэдгээрийг даван туулах арга зам:	79
Зарчмуудыг амьдралд хэрэгжүүлэх нь	83
Нэг. Тууштай чанар	84
Хоёр. Эрх	84
Гурав.Тодорхой байдал	85
Дөрөв. Хугацаа	85
Тав. Бодит байдал	86
Зургаа. Хөрөнгө мөнгө	86
Долоо. Зохицуулалт	87
Найм. Хариуцлага	87
Ес. Үнэлгээ	88
Арав. Идэвхтэй иргэн	88

III БҮЛЭГ

Ямар зөвлөгөөг дагаж мөрдөх вэ?

Ажилд тань тустай арван зөвлөгөө	91
Нэгдүгээр зөвлөгөө - Нухацтай ханд	92
Хоёрдугаар зөвлөгөө - Иргэдийн санаа бодлоос эхэл	93
Гуравдугаар зөвлөгөө - Амласнаа биелүүл	94
Дөрөвдүгээр зөвлөгөө - Хугацааг баримтал	95
Тавдугаар зөвлөгөө - Бүтээлчээр ханд	96
Зургадугаар зөвлөгөө - Ашиг сонирхолуудыг тэнцүүл	97
Долдугаар зөвлөгөө -Шүүмжлэлд бэлэн бай	98
Наймдугаар зөвлөгөө - Ажилтнуудаа хамруул	99
Есдүгээр зөвлөгөө - Нэгдмэл бодлого явуул	100
Аравдугаар зөвлөгөө - Одоо гүйцэтгэ	101

IV БҮЛЭГ

Нэмэлт мэдээллийг хаанаас авч болох вэ?

ЭЗХАХБ-ын эх сурвалжууд	106
Ерөнхий байдал ба нийтлэг мэдээлэл	107
Эрх зүйн хүрээ	107
Бодлогын хүрээ	108
Зохион байгуулалтын хүрээ	109
Үнэлгээ	109
Мэдээллийн арга хэрэгслүүд	110
Зөвлөгөөний арга хэрэгслүүд	110
Идэвхтэй оролцооны арга хэрэгслүүд	111
Үнэлгээний арга хэрэгслүүд	111
МХТ-ийн арга хэрэгслүүд	111
Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны МХТ-ийн арга хэрэгслүүд	112

Мэндчилгээ

Бодлого боловсруулах явцад иргэдийг мэдээллээр хангах, зөвлөлдөх, идэвхтэй оролцуулахад практикийн ач холбогдолтой зааварчилгаа болсон Бодлого Боловсруулах явцад Мэдээлэх, Зөвлөлдөх, Олон нийтийг оролцуулах хэмээх ЭЗХАХБ-ын гарын авлагатай танилцана уу хэмээн эрхэм уншигч таныг урин, мэндчилж байна.



Энэ гарын авлага нь төр, иргэний харилцааг бэхжүүлэхэд төрийн албан хаагч нарт практик туслалцаа үзүүлэхэд чиглэсэн тодорхой зорилготой юм.

Төр, иргэний харилцаа бол олон нийтийн анхаарлын төвд байдаг олон асуудлын нэг билээ. Асуудал дэвшүүлэх, шаардлага тавих, бодлого боловсруулагчдад нөлөөлөх тал дээр иргэд болон иргэний нийгмийн байгууллагууд сүүлийн жилүүдэд улам бүр идэвхтэй, хүчирхэг болж байна. Нөгөөтэйгүүр, нэгэнт хэвшил болсон ардчиллын үйл явцад иргэдийн оролцох идэвх оролцоо суларч байна. Жишээ нь сонгуульд оролцох сонгогчдын хувь оролцоо буурч байна. Олон түмэн итгэл алдрахын хэрээр засгийн газрууд иргэдтэй харилцах шинэ арга замыг эрэлхийлэхэд хүрч байна. Ялангуяа өнөөгийн нарийн төвөгтэй ертөнцөд бодлого боловсруулахад иргэдийн оролцоо нь нэн их шинэ боломжуудыг нээж байгааг засгийн газрууд урьд урьдаас илүү ойлгодог болж байна.

Засгийн газрууд иргэдтэй харилцах харилцаагаа бэхжүүлэхийн төлөө ийнхүү ихэд чармайх болсон үндсэн шалтгаан, эрэлт шаардлага болон зорилгыг энэхүү гарын авлагаас тодорхой мэдэж болно.

Олон орны засгийн газар бодлого боловсруулахдаа иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоог өргөжүүлэхэд чиглэсэн санал санаачилга дэвшүүлдэг. Зарим засгийн газар энэ талаар нэлээд туршлага хуримтлуулсан байдаг. Гэвч төр болон иргэдийн харилцааг хэрхэн бэхжүүлэх талаар эргэцүүлэн үзсэн албан хаагчид, энэ ажил ихэнхдээ урсгалын байдлаар явж ирсэнийг анзаардаг. Энэ талын нөхцөл байдлыг бүрэн гүйцэд харуулсан, практик асуудлаар зөвлөгөө өгөх зохиол бүтээл ч харьцангуй цөөн байгаа юм.

Гарын авлага маань бодлого боловсруулах явц дахь иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцооны өнөөгийн нөхцөл дэх хамгийн дэвшилтэй хэлбэрүүдийг үзүүлж, эл хоосон орон зайг бөглөх болно.

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага, гишүүн орнуудынхаа төрийн албан хаагчидтай хамтран төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх асуудлаар явуулсан томоохон судалгаандаа тулгуурлаж гаргасан нөхцөл байдал, практик жишээг эл гарын авлагад дурдана. Иргэн түншлэгч болох нь: Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах хэмээх эл судалгааны тайлан/ЭЗХАХБ,2001/ нь энэ чиглэлд засгийн газруудаас явуулсан үйл ажиллагааны талаарх хамгийн сүүлийн үеийн харьцуулалт хийгээд дүн шинжилгээг харуулна. Хураангуйг бодлогын төвшинд дурдсан бөгөөд дурдсан хоёр хэвлэлийг ЭЗХАХБ-ын вэб хуудаснаас олж унших боломжтой /Холбогдох зохиол бүтээлийн талаар өгүүлсэн дөрөвдүгээр бүлгийг үзнэ үү/.

Гарын авлага нь тодорхой жишээ, үзэл баримтлал, дүн шинжилгээ, практикаас урган гарсан зөвлөгөөнүүдийг багтаасан болно.

Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх гэдэг чухам юу болох, түүний учир шалтгаан, арга зам, өртөг зардал хийгээд шаардагдах нөхцөл байдлуудыг гарын авлагад тодорхой өгүүлэх болно. Чингэхийн тулд шаардагдах хүрээг тодорхойлох, алсыг харсан байдлаар ажлаа төлөвлөх, ямар хэрэгсэл ашиглах, мэдээлэл холбооны технологи /МХТ/-ийг хэрхэн ашиглах талаар үзүүлэх болно. Тэрчлэн гарын авлага маань төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд төрийн албан хаагчдын байнга санаж явууштай үндсэн арван зарчим, болон практик ач холбогдол бүхий арван зөвлөгөөг уншигчдад өгөхөөс гадна хаанаас нэмэлт мэдээлэл авч болохыг зааж өгнө.

Гарын авлага нь харилцан адилгүй орчин нөхцөлд ажиллаж буй төрийн олон шатны албан хаагчдад мөн зориулагдсан болно.

Гарын авлага эхлэн суралцагчдад бүх талыг хамарсан зааварчилгаа болохын сацуу энэ салбарт мэргэшсэн ажилтнуудад нарийвчилсан тодорхой зөвлөгөө өгч, гүйцэтгэх засаглалын болон улс төрийн дээд удирдлагад ажиллагсдад нэгэн адил зориулагдсан болно. Энэхүү гарын авлага бүхэлдээ ЭЗХАХБ-ын гишүүн болон гишүүн бус улсуудын төрийн албан хаагчдад дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилготой юм. Мөн засаг захиргааны ажлын арга барилын хувьд харилцан адилгүй улс орны албан хаагчдад бас зориулагдаж буй учир төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд төр засгийн газруудын өөр хоорондоо ялгардаг өвөрмөц онцлогуудыг эрхбиш хүндэтгэн үзсэн хэрэг билээ.

Гарын авлагад дурдаж буй арга барил, үйл ажиллагаанууд нь ардчиллын үед бий болсон байгууллагуудад нэмэр тус болохын зэрэгцээ ардчиллыг бэхжүүлэхэд ч тус дөхөм үзүүлэх болно.

Төлөөллийн ардчиллын дадлага туршлагад тулгуурласан энэ гарын авлага бол түүний цаашдын өсөлт хөгжилтөд ч дэмжлэг болно. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх үйл ажиллагааг явуулахад төр, засгийн байгууллагууд бодлого, шийдвэр боловсруулан гаргах үндсэн эрхээ эдэлж, үүргээ хэрэгжүүлсээр байхын хамт тэдгээрийг хэрэгжүүлэх шинэ арга замыг нээн ашиглаж эхлэх ёстой болно. Бодлого боловсруулах үйл явц дахь иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоо нь хууль тогтоох байгууллагын эрх мэдлийг өчүүхэн ч бууруулахгүй. Учир нь парламент ч гэсэн сонгогчидтой тогтоосон харилцаагаа бэхжүүлэхийн тулд үүнтэй төстэй үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг билээ. Гарын авлагад дурдаж буй үйл ажиллагаанууд нь ардчиллын уламжлалт байгууллагуудыг орлох буюу халж солих гэсэн хэрэг биш юм. Эдгээр чиг хандлага, үйл ажиллагаанууд нь тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааг харин улам баяжуулж, ардчилсан үйл явцыг бэхжүүлэх болно.

Энэ гарын авлагыг хэрхэн хэрэглэх вэ?

Төр иргэдийн харилцаа хэмээх энэхүү гарын авлага дөрвөн бүлэгтэй. Тухайлбал:

- ▶ **Төр яагаад иргэдтэй харилцдаг тухай** гарах эхний бүлэгт төр, иргэдийн харилцаа гэж юу болох, уг харилцааг яагаад бэхжүүлэх шаардлага үүсдэг хийгээд тэр ажил ямар өртөг зардлаар хийгддэг талаар өгүүлнэ.
- ▶ **Төр, иргэдийн харилцааг хэрхэн бэхжүүлдэг** тухай гарах дэд бүлэгт тодорхой жишээ, арга хэрэгсэл, үндсэн зарчмуудын талаар өөрөөр хэлбэл төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх ерөнхий хүрээг тодорхойлж, энэ чиглэлээр явуулах үйл ажиллагааг алсыг харсан байдлаар төлөвлөх, хэрэгжүүлэх, мөн шаардлагатай арга хэрэгслүүдийг сонгож авах, хэрэглэх, мэдээлэл холбооны технологи/МХТ/-ийн үр шимийг хэрхэн ашиглах талаар өгүүлнэ. Түүнчлэн ЭЗХАХБ-ын боловсруулсан үндсэн арван зарчмыг танилцуулж, бодлого боловсруулах явц дахь иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоог идэвхжүүлэх ажлыг практикт хэрхэн хэрэгжүүлэхийг харуулна.
- ▶ **Дагаж мөрдөх зөвлөгөөний** тухай хэмээх гутгаар бүлэгт энэхүү гарын авлагад дурдагдаж буй үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хэрэглэсэн, практикаас урган гарсан арван зөвлөгөөг танилцуулна.
- ▶ **Хаанаас, хэрхэн нэмэлт мэдээлэл авч болох** тухай хэмээх дөтгөөр бүлэгт санамж, зөвлөгөөнүүдийг багтаасан бөгөөд төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх талаар гарын авлагад гарч байгаа янз бүрийн асуудлыг нарийвчлан судлахад шаардлагатай эх сурвалжууд, түүний дотор энэхүү гарын авлагын эх сурвалж болсон ЭЗХАХБ-ын тайлан, бодлогын хураангуйн талаар өгүүлэх болно.

Гарын авлага маань яс үндэс, мэдлэг боловсролын түвшин, мөн эрэлт хэрэгцээний хувьд ч өөр хоорондоо харилцан адилгүй албан хаагчдад зориулагдсан болохоор түүнийг олон хэлбэрээр ашиглах боломжтой. Жишээ нь:

- ▶ Гарын авлагыг чиг баримжаа болгоод, улмаар алхам алхмаар алгуурхан хэрэгжүүлэх үүднээс **эхлэн суралцагчид** уншиж болно.

- ▶ Өмнө дурдсан бүлэг хэсгүүдтэй шууд танилцахыг **туршлагатай уншигчид** хүсч болох талтай.
- ▶ Тодорхой хэсгүүдийн талаар уншихыг зорьсон **мэргэжлийн хүмүүс** дэлгэрэнгүй өгүүлсэн агуулгаас өөрсдийн хүссэнийг төвөггүй олж болно.
- ▶ Гарын авлагыг, түүний судалгааг, тодорхой жишээг, нарийвчилсан зөвлөгөөг уншиж судлахыг хүссэн **гүйцэтгэгч ажилтны** хувьд дэд болон гутгаар бүлэг илүү нийцтэй байх болно.
- ▶ Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхийн учир шалтгааныг, шаардагдах өртөг зардлыг, амжилтанд хүрэх хүчин зүйлүүдийн талаар эрэгцүүлэн бодохыг хүссэн **удирдах ажилтны тухайд гэвэл** тэргүүн болон гутгаар бүлгийг анхааралтай уншихын хамт дэд бүлгийг эсвэл эх сурвалжуудыг багтаасан дөтгөөр бүлэг дэх вэб хуудаснаас ЭЗХАХБ-ын бодлогын хураангуйг гүйлгээд харчих нь тустай байх болно.
- ▶ Эцэст нь тэмдэглэхэд оновчтой арга ажиллагааны эмхэтгэл болсон гарын авлага маань **нийт уншигчдад** ч ашиг тустай байх болно.

І БҮЛЭГ

Төр иргэдийн харилцаа яагаад хэрэгтэй вэ?

- ✓ Төр, иргэдийн харилцаа гэж юу вэ?
- ✓ Төр, иргэдийн харилцааг хэрхэн бэхжүүлдэг вэ?
- ✓ Энэ ажил ямар өртөг зардлаар хийгддэг вэ?

Төр, иргэдийн харилцаа гэж юу вэ?

Төр, иргэдийн харилцаа гэдэг бол шууд хэлэхэд ардчиллын нөхцөл дэх төр, иргэдийн хамтын ажиллагаа юм. Энэ нь чухамдаа юу гэсэн үг вэ ?

Бодлого боловсруулахаас эхлээд нийгмийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх, түгээх хүртэлх олон хүрээнд төр, иргэдийн харилцаа оршдог. Харин **бодлого боловсруулах** явц дахь төр, иргэдийн харилцааг энэхүү гарын авлагад онцлон авч үзэх болно. Орон нутгийн, бүсийн, үндэсний, олон улсын гэх мэт олон түвшинд төрийн үйл ажиллагаа явагддаг. Төр эдгээр бүх түвшинд иргэдтэйгээ харьцдаг. Энэ гарын авлагад бодлого боловсруулахад илүү дөхөмтэй **үндэсний түвшин** дэх төр, иргэдийн харилцааг түлхүү авч үзэх болно. **Хувь хүнийхээ хувьд**, эсвэл **иргэний нийгмийн байгууллагууд** /ИНБ/ хэмээх зохион байгуулалт бүхий бүлэглэлд оролцогчийн хувиар иргэд төртэй харьцдаг. Гарын авлагад эдгээр ИНБ-уудын тухай дурдах болно. Ардчилал бол иргэдийн зөвшилд тулгуурладаг. Энэхүү зөвшилд хүрэхийн тулд төлөөллийн ардчилал нь сонгууль буюу сонгуулийн өмнөх кампанит ажил гэх мэт нэгэнт тогтчихсон уламжлалт дүрэм, зарчмуудад тулгуурладаг. Төлөөллийн ардчилал нь сонгуулиудын завсар хооронд төр болон иргэдийн хооронд явагдаж байдаг харилцаанд мөн тулгуурладаг. Энэ үүднээс үзвэл гарын авлагад гол анхаарал хандуулж байгаа зүйл бол энэ **харилцаа** юм. Эл харилцааны үүднээс үзвэл гарын авлага нь **төрийн** байр суурийг хадгалж, “Төр иргэдтэй харилцаагаа хэрхэн бэхжүүлэх вэ?” гэж асуух болдог. Энэ нь практикийн үүднээс дараах утгыг агуулж байна. Үүнд:

► Мэдээлэл

Төр бодлого боловсруулахдаа мэдээллийг өөрийн санаачилгаар түгээдэг буюу иргэд эрэлт шаардлагынхаа дагуу тэрхүү мэдээллийг хүлээн авдаг.

Аль ч тохиолдолд мэдээлэл “ганц урсгалтай зам” мэт байдаг бөгөөд тодруулж хэлбэл төрөөс иргэд рүү чиглэж байдаг. Төрийн данс бүртгэл, албан ёсны хэвлэл, төрийн вэб-хуудас зэргээр жишээ татаж болно.

► Зөвлөгөөн


Төр бодлого боловсруулах асуудлаараа иргэдийн хариу үйлдлийг хүсч байдгаас гадна түүнийг хүлээн авч байдаг. Бодлого

боловсруулах явцад тэрхүү хариу үйлдлийг хүлээн авахын тулд ямар асуудлаар хэний санаа бодлыг сонсохоо төр урьдчилан тодорхойлдог. Иргэдийн хариу үйлдлыг хүлээн авахын тулд тэднийг урьдчилан мэдээллээр хангах шаардлага төрд үүснэ. Төр, иргэдийн хооронд ийм хязгаарлагдмал маягийн *хос урсгалтай харилцаанаас* зөвлөгөөн бий болдог. Хуулийн төсөлд иргэдээс санал авах, олон нийтийн дунд санал асуулга явуулах зэргийг жишээ болгон дурдаж болно.

► Идэвхтэй оролцоо

Шийдвэр гаргах болон бодлого боловсруулах явцад иргэд идэвхтэй оролцдог. Идэвхтэй оролцоо гэдэг бол бодлого боловсруулах асуудлаар санал солилцоход иргэдийн өөрсдийн нь оруулж буй хувь оролцоо юм. Харин бодлогоо томъёолох, эцсийн шийдвэр гаргах эрхийг төр өөрөө эдэлнэ. Бодлого боловсруулах явцад иргэдийг оролцуулна гэдэг бол түншлэлийн зарчимд тулгуурласан төр, иргэдийн хоорондох *хос урсгалтай харилцааны* хөгжиж гүнзгийрсэн хэлбэр юм. Ажлын хэсэг, жирийн олон түмний хурал цуглаан, харилцан ярилцлага гэх мэтээр жишээ татаж болно.

Бодлого боловсруулах явцад иргэдийн үзүүлэх нөлөөг мэдээлэл, зөвлөгөөн, улмаар идэвхтэй оролцооны замаар нэмэгдүүлж болно. Иргэдийн зүгээс үзүүлэх энэхүү нөлөө нь шударга, чөлөөт сонгууль, иргэдийн төлөөлөгчдийн хурал, гүйцэтгэх засаглалын хариуцлага, ил тод байдал, төрийн захиргааны байгууллага, улс төрөөс түдгэлзэх, олон урьгалч үзэл, хүний эрхийг хүндэтгэх гэх мэт ардчиллын нэгэнт тогтсон дүрэм журам, зарчмуудыг дагаж мөрдөх явдлыг үндсээр нь халж солино гэсэн үг биш юм. Эдгээр зарчим нь ЭЗХАХБ-ын гишүүнчлэлийн шалгуур үзүүлэлтийг зарим талаар бүрдүүлж байдаг. Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоог хөхүүлэн дэмжих нэмэлт үйл ажиллагаа ардчилсан орнуудад ямар нэг хэлбэрээр, тодорхой хэмжээнд ямагт байсаар ирсэн юм. Гэвч ардчилал гүнзгийрэхийн хэрээр иргэд илүү ил тод, нээлттэй байдлыг шаарддаг бөгөөд тулгарч буй бэрхшээл ч, нийгмийн харилцаа ч улам нарийн төвөгтэй болохын хамт төр засгийн газрууд иргэдтэй тогтоосон харилцаагаа бэхжүүлэхийг улам бүр чармайдаг байна.



Төр, иргэдийн харилцааг яагаад бэхжүүлэх шаардлагатай вэ?

Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоог нэмэгдүүлэх замаар төр, засгийн газрууд иргэдтэй харилцаагаа бэхжүүлдэг. Төр, засгийн газрууд ямар учраас иргэдтэй харилцаагаа бэхжүүлдэг юм бэ гэсэн асуултанд бие биедээ харилцан шүтэлцсэн гурван хариулт гол байгаа юм.

► Төрийн бодлого сайжирна

Төр, иргэдийн харилцаа бат бэх байхын хэрээр иргэдийг нийгмийн асуудлуудад цаг зав, хүч чармайлтаа зориулахад нь зоригжуулдаг бөгөөд төр ч гэсэн иргэдийн оролцоог нэмэлт боломж хэмээн үнэлэн үзэж, ашигладаг. Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоо нь төр, засгийн газарт **бодлогоо боловсруулах** илүү тулхтай суурь нөхцлийг бүрдүүлж өгөхөөс гадна түүнийг аливаа шинэ зүйлд суралцдаг байгууллага болгон хувиргадаг. Мөн төрийн бодлогын **хэрэгжилт үр дүн сайтай** болохоос гадна төрийн бодлогын талаар мэдээлэлтэй болсон иргэд түүнийг боловсруулах хийгээд хэрэгжүүлэхэд илүү түлхүү оролцдог.

► Төрд итгэх итгэл нэмэгдэнэ

Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоо нь төрийн бодлогын шинжтэй хөтөлбөр, төлөвлөгөөний талаар илүү мэдээлэлтэй болох, санал бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргах явцад хувь оролцоогоо нэмэрлэх боломжийг тэдэнд бүрдүүлдэг бөгөөд ийм оролцооны дүнд бий болсон бодлогын үр дагаварыг иргэд хүлээн зөвшөөрч дэмжих явдал нь ч нэмэгддэг. Төр, засгийн газар **ил тод** байх нь аливаа ардчиллын дээд эрхийг баригч сонгогч-иргэдээс тэдэнд итгэх итгэлийг дээшлүүлдэг. Төрд итгэх итгэл дээшилж, нийгмийн бодлого сайжирч, төр, иргэдийн харилцаа бэхжих нь төрийн хууль ёст байдлыг бэхжүүлдэг.

► Ардчилал улам бэхжинэ

Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоо нь төр, засгийн газрыг илүү нээлттэй, ил тод болгодог. Төр, иргэдийн харилцаа бэхжих нь иргэдээс нийгмийн амьдралд оролцох нөхцлийг бүрдүүлж, тэдний **оролцоог идэвхжүүлдэг** бөгөөд төрийн бодлогын асуудлаарх хэлэлцүүлэг, санал хураалтад оролцох, эвлэлдэн нэгдэх зэргээр иргэдийг нийгмийн харилцаанд идэвхжүүлдэг.

Энэ бүхэн нь ардчиллыг улам бүр бэхжүүлдэг. Бодлого боловсруулах явцад иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоог хангахад чиглэсэн төр, засгийн газрын хүчин чармайлт нь төлөөллийн ардчиллыг орлохгүй бөгөөд ингэхэд ч зорьдоггүй. Харин ч ардчиллыг бүхэлд нь бэхжүүлэн бататгадаг болно.

Иргэдтэй тогтоосон харилцаагаа бэхжүүлэхэд төр анхаарал хандуулах болсон нь **бодлого боловсруулах орчин нөхцөл өөрчлөгдсөнтэй** холбоотой юм. Өөр хоорондоо уялдаа холбоотой, улам бүр нарийн төвөгтэй болж буй өнөөгийн ертөнцөд харилцан зохицон амьдарч байгаа улс үндэстнүүдийн засгийн газрууд нь өргөн хүрээтэй асуудлуудад урьдаас улам бүр илүү анхаарч нарийн нягт хандахыг нийгэм болон зах зээлийн нөхцөл шаардаж байна.

Тулгарч буй бэрхшээлт зорилтуудын олонх нь аль нэг үндэсний хийгээд засаг захиргааны эрх мэдлээс хальж байна. Албан татвараас зайлсхийх, гэмт хэрэг, байгаль орчны бохирдолтой тэмцэх зорилтуудыг энд жишээ татаж болох юм. Орчин цагийн Мэдээлэл холбооны технологи /МХТ/ нь энэхүү харилцан хамаарлыг нэмэгдүүлж, хурдацыг нь улам ч нэмэгдүүлж байна. Төр, засгийн газрууд хамтран ажиллах, орон нутаг, бүс нутаг, үндэсний хийгээд дэлхий дахины хэмжээнд засаглалын бүх түвшинд санал бодлоо нэгтгэхийг дээр өгүүлсэн бэрхшээлт зорилтууд шаардаж байгаа учраас төрийн бодлого боловсруулах нь илүү нарийн төвөгтэй болж байна. Энэ бүхэн нь төрийн нээлттэй, ил тод байдал гэдгийг ойлгох, төр, засгийг тийм байлгахад иргэдэд улам хүндрэлтэй болж байна.

Бололцоо нөхцөл нэгэнт хэмжээ хязгаартай болохоор төр, засгийн газарт ч бодлого боловсруулах хийгээд хэрэгжүүлэх үйл явцыг урьдын байдлаар нь үргэлжлүүлэх аргагүй болж байна. Энэ мэт **төвөгтэй байдлын** дунд санал хураалтын үр нөлөө буурч байна хэмээн иргэд төсөөлдөг бөгөөд төрд итгэх итгэл нь ч нэгэн адил суларч байна. “Ардчиллын хомсдол”, төр, засгийн газрын эрх зүйн үндэс суларлаа гэх мэт үг яриа олонтаа сонсогддог болж байна.

Бодлогыг үр дүнтэй бөгөөд хууль ёсны байлгах шаардлагыг төр, засгийн газруудад улам бүр хүчтэй тавьж байна. Тэдгээр бодлогыг иргэддээ ойлгуулж, тэднээс дэмжлэг авахгүйгээр зохих хэмжээнд нь явуулж, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжгүйг төр, засгийн газрууд ч ойлгож байна.

Төр иргэдтэй тогтоосон харилцаагаа бэхжүүлэхийг чармайхдаа бэрхшээлтэй асуудлыг тодорхойлохоос эхлээд шийдвэр гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ, дүгнэлт өгөх хүртэлх бодлого боловсруулах үйл ажиллагааны бүхий л шат дамжлагад нь нөлөөлсөн даралт шахалт байгааг мэдэрдэг. Төр нь:

▶ **Илүү нээлттэй, ил тод байдлыг бий болгох эрэлт шаардлагын хариуд**

Олон түмний өсөн нэмэгдэж байгаа хүсэл эрмэлзэл, төрийн үйл ажиллагааг нарийвчлан хэлэлцдэг хэвлэл мэдээлэл болон иргэдийн үйл ажиллагаанд ханддаг. Шинээр хэрэгжүүлэх бодлогын шинжтэй төлөвлөгөө, бодлогын баримт бичгийн төсөл, тэдгээрийн хэрэгжилтийн байдал, алдаа онооны талаарх төрийн мэдээллээс иргэд илүү бодитой бөгөөд оновчтой, сүүлийн үеийн мэдлэгийг олж авдаг бөгөөд төрийн үйл ажиллагааг ойлгох, хяналт тавих чадвар нь ч сайжирдаг. Энэ бүхэн нь илүү идэвх сайтай иргэдийг бий болгох үндсийг бүрдүүлдэг.

▶ **Санаа бодлоо сонсгож хэлэлцүүлэх иргэдийн хүслийг биелүүлэх нь**

Иргэдийн хувь оролцоог бодлого боловсруулахдаа тусгах замаар тэдний санаа бодлоо сонсгох, хэлэлцүүлэхсэн гэсэн хүслийг төр биелүүлэхээр чармайдаг. Бодлого боловсруулах явцдаа оролцогсдын хүрээг тэлэх замаар мэдээллийн шинэ эх сурвалжуудыг төр бий болгодог. Бодлого боловсруулахад хувь нэмрээ оруулах боломжийг сонирхогч талуудад ийнхүү олгосноор өөрийнх нь шийдвэрийг сайн дураараа даган биелүүлэх боломжийг төр өргөжүүлдэг.

▶ **Олон нийтийн дэмжлэг буурахыг засч залруулах нь**

Сонгогчдын сонгуульд оролцох оролцоо болон улс төрийн намуудын гишүүдийн тоо багасах, төрийн байгууллагуудад итгэх итгэл буурах үед санал асуулгын дүнгийн мөрөөр ажиллахыг төр хичээдэг. Төр бодлого боловсруулах үйл явцыг мэдэх, ойлгох, тайлбарлах, оролцоход нь иргэдэд тулгарч буй саад бэрхшээлийг иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцооны дүнд бууруулдаг. Тэр нь иргэддээ мэдүүлэх болон үйл ажиллагаагаа явуулахад нь босгоо доошлуулж өгдөг бөгөөд иргэддээ үйлчлэх талаар төрийн хийх ёстой болон хийж байгаа зүйлсийг газар дээрээс нь шууд мэдэх бололцоо олгодог. Өөрсдийн нь бүтээлч оролцооны дүнд нааштай өөрчлөлт гардагийг ардчилсан нийгэм иргэдэд ойлгуулдаг.

Ямар өртөг зардал гарах вэ?


Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх нь нийгмийн бодлогыг боловсронгуй болгох, төрд итгэх олон түмний итгэлийг нэмэгдүүлэх, ардчиллыг бэхжүүлэх, төр, засгийн газруудад дэмжлэг үзүүлэх чухал ач холбогдолтой ажил юм. Хэдий тийм боловч саад тотгор багагүй учирдаг бөгөөд төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх явцад тань тохиолдож болох гурван **бэрхшээлийг** энд онцлон авч үзье. Чингэхдээ эдгээр бэрхшээлээс гадна удирдлагын болон тууштай чанарын ач холбогдолын талаар нарийвчилж ярилцая.

Төрийг иргэдтэй холбох гэж хичээх нь хэтэрхий их өртөгтэй ажил юм биш үү? Ингэх хэрэг байгаа юм уу?



Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоонд төрийн бусад аливаа үйл ажиллагааны нэгэн адил **хөрөнгө мөнгө, цаг хугацаа, мэдлэг туршлага болон сахүүжилт** шаардагдах нь тодорхой. Гэхдээ иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны дүнд томхон амжилт олоход зарцуулагдах хөрөнгө мөнгө нь тухайн нэг бодлогод зарцуулж буй нийт хөрөнгөтэй харьцуулбал ялимгүй бага хэмжээтэй байдаг. Эдгээр хөрөнгө зохистой зарцуулагддаг уу? гэсэн асуулт гарна. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлсэний үр дүнд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх болон түүнийг сайн дураар хүлээн авч дагаж мөрдөх үйл явц сайжирч, төрд итгэх итгэл дээшлэх гэх мэтийн ашиг тусыг нь бодолцвол уг хөрөнгө

зохистой хэрэглэгджээ гэж үзэж болно. Дутуу дулимаг боловсруулсан, ор нэр хэрэгжүүлсэн бодлогоос үүдэн гардаг бэрхшээл хүндрэлтэй харьцуулбал **төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх нь үнэхээр чухал, шаардлагатай хөрөнгө оруулалт байх болно.** Чухамдаа дурдсан ажиллагаанд бус харин богино хугацаанд авч үзвэл бодлого хэрэгжихгүй байх, урт хугацаанд авч үзвэл олон түмний итгэл, төрийн эрх зүйн үндэс суларч, бодлогын нь үр дүн буурснаас ихээхэн зардал чирэгдэл гардаг.



Төр бол засаглан захирах, бодлого боловсруулах үүрэгтэй нь ямар ч эргэлзээгүй. Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоо нь төрийн санаачлах, шийдвэр гаргах эрхийг халж өөрчлөх гэсэн хэрэг биш юм. Төр удирдан жолоодох үүрэгтэй, эцсийн эцэст тэр үүргээ биелүүлэхийг нь ард түмэн ч түүнээс хүсч хүлээдэг учраас л сонгодог шүү дээ. Тэгэхээр, асуудлын гол нь **удирдан жолоодох эсэхэд биш харин хэрхэн удирдахад** байгаа юм. Төр, засгийн газар удирдах үүргээ үндсэндээ хоёр байдлаар хэрэгжүүлж болно. Тухайлбал, иргэдийн санаа бодол, оролцоог хайхралгүй удирдаж болно. Энэ нь төрд итгэх итгэлийг сулруулж, улмаар хямралд хүргэнэ. Нөгөөтэйгүүр, төр иргэдийн санаа бодол, оролцоонд

нээлттэй байх хэлбэрээр тэднийг удирдаж болно. Энэ нь иргэдийн болон иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулан илүү сайн бодлого боловсруулах, өндөр итгэл хүлээх, эрх зүйн үндсээ батжуулах ихээхэн боломжийг олгодог бөгөөд удирдах, сонсохыг хослуулдаг мэдээлэл, хамтач ажиллагаанд тулгуурладаг удирдлагын хэлбэр юм. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх нь төр удирдах үүргээ нээлттэй, ил тодоор, үр дүнтэй хэрэгжүүлэхийг хэлнэ. Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог ашиглах тохиолдолд ямар хандлага буюу байр суурь баримтлах талаар сонголт хийх, эцэслэн шийдвэрлэхэд **төрийн удирдах үүрэг** оршдог. Ямар зорилгод хүрэхэд ямар хэрэгсэл, хөрөнгө хүчийг зориулах вэ гэдгээс гадна бодлого боловсруулахад тэдгээрийг хэрхэн ашиглахыг мөн шийдэх ёстой. Дээд удирдлагын түвшинд эдгээр шийдвэрийг гаргахад хамгийн зохистой үндсэн нөхцөлийг бүрдүүлэхэд **менежментийн үүрэг** оршдог. Менежмент нь бүх талыг хамарсан гүн гүнзгий санал санаачилга дэвшүүлэхийн зэрэгцээ үйл ажиллагааг зохион байгуулж, хөтлөн удирдаж, иргэдтэй харилцах харилцааг бүрдүүлдэг. Мөн өөрөө биечлэн оролцоогүй тохиолдолд үйл ажиллагааны үр дүнг бодлого боловсруулагчдад эргэж мэдээлдэг. Засгийн газрын бусад бүх үйл ажиллагааны нэгэн адил энэ ажил ч сонгогчидтой өөрийн шугамаар хэлхээ холбоотой ажилладаг Хууль тогтоох байгууллага буюу **парламентын** хараа хяналтын дор явагддаг.

Ингэхээр Засгийн газрын ажил удааширахгүй юу? Өөрийн ажилд хүн бүрийг хөндлөнгөөс оролцуулаад байхыг Засгийн газар үнэхээр хүсэх үү?



Төр, иргэдийн харилцааг бэхжүүлнэ гэдэг **ид шидийн ажил биш** л дээ. Иргэдийн санаа бодлыг сонсч бодолцож байгаа дүр эсгэвэл төрд болон ардчилалд итгэх итгэлийг бууруулахад хүргэнэ. Тийм учраас төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх аливаа хүчин чармайлтыг амжилтанд хүргэхэд **тууштай чанар, удирдлагын үүрэг** хамгийн чухал. Улс төрийн түвшинд, төрийн захиргааны албаны удирдлагын түвшинд засгийн газар тууштай бус байвал иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог хөхүүлэн дэмжих санаачилга мухардаж бодлого боловсруулагчдад хүрдэггүй учир ямар нэгэн нааштай үр дүн гардаггүй. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд гарцаагүй амжилт олдог **баталгаатай арга зам гэж байдаггүй**. Олон түмний мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоо нь сөрөг хүчийг бий болгож, бодлого боловсруулах үйл явцыг нэлээд хэмжээгээр сааталд оруулж болзошгүй. Засгийн газарт тодорхой хэмжээгээр өртөг зардалтай ч байж мэднэ. Гэвч эдгээр эрсдэлийг иргэдийг оролцуулахгүй байснаас үүдэн гарах **сөрөг үр дагавар, хор уршигтай** харьцуулаад үзэх хэрэгтэй.

Өнөөдөр төр, засгийн газруудад тулгарч буй асуудлын гол нь иргэдтэй харилцаагаа бэхжүүлэх эсэхэд биш харин энэ ажлыг **мэргэжлийн түвшинд хэрхэн амжилттай гүйцэтгэх вэ** гэдэгт оршиж байна. Зарим үед засгийн газар өргөн олныг хамран оролцуулахыг хүсдэг. Гэтэл аль нэг хэсэг бүлгийн түлхүү оролцоог хүсэх үүднээс хязгаарлагдмал төрлийн мэдээллийн санг бүрдүүлж бас болно. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх нь анхаарал тавьж, ихээхэн хянуур хандаж байж нааштай үр дүнд хүрэх нухацтай ажил байгаа юм. Эдгээр боломж, алдаа оноог дэлгэн харуулж, иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоог хөхүүлэн дэмжих ажлыг амжилтад хүргэх шилдэг сайн арга барилыг түгээн дэлгэрүүлэхэд энэ Гарын авлагын зорилго оршиж байгаа болно.


II БҮЛЭГ

Төр, иргэдийн харилцааг хэрхэн бэхжүүлэх вэ?

- ✓ Ерөнхий хүрээг тодруулах нь
- ✓ Хэтийн төлөвлөгөө зохиож ажиллах
- ✓ Арга хэрэгслийг сонгож, хэрэглэх
- ✓ Мэдээлэл холбооны шинэ технологи /МХТ/-ийг ашиглах нь
- ✓ Зарчмуудыг амьдралд хэрэгжүүлэх

Ерөнхий хүрээг тодруулах нь

Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх урьдчилсан нөхцөл бол ажлын ерөнхий тоймоо тогтоох явдал юм. Ажлын ерөнхий хүрээ нь дээрх харилцааг батжуулах бэхжүүлэх ажлыг оруулах орчинг бүрдүүлдэг. Үүнд бодлого боловсруулах явцад иргэдийн мэдээлэл авах, зөвлөлдөх, оролцох **хууль ёсны эрх**, мөн **төрийн бодлого** хийгээд эдгээр эрх үүргийг хэрэгжүүлэгч **байгууллагууд** хамрагдана гэсэн үг юм. Тэрчлэн үйл ажиллагааны **үнэлгээ**, түүнийг хэрэгжүүлэх ерөнхий **чадамжийг** мөн өгүүлдэг. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх үндэс болсон мэдээллийн олдоцыг олонх нь эрх зүй, улс төрийн бодлогын хүрээнд хөнддөг. Ажлын ерөнхий хүрээг тодорхойлох практик ажилд холбогдолтой сүүлийн үеийн ололтуудыг дараах бүлгүүдэд дурдах болно. Гарын авлагын бүлэг тус бүр нь бүрэлдэж бий болсон жишиг буюу стандартууд болон өөр өөр хандлагуудыг харуулах бөгөөд шинэ хүрээг бий болгох, одоо нэгэнт байгаа хүрээнүүдийг эрэгцүүлж бодох, улам боловсронгуй болгох арга ажиллагааг эзэмшүүлэх болно. Дурдсан элементүүдийг тухайн улс орны нөхцөл байдал, эрх зүйн болон зохион байгуулалтынх нь хүрээнд нийцүүлж хэрэглэх шаардлагатай нь мэдээжийн хэрэг.



Мэдээллийн ямар элементийг хэрэглэдэг вэ?

Мэдээллийн эрх зүйн элементүүд



Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхийн үндэс бол мэдээлэл юм. Иргэдийн мэдээлэл авах эрх /Мэдээллийн эрх чөлөөний **хууль** буюу МЭЧХ гэдэг/-ийг хууль тогтоомжинд тусгасан байдлаараа улс орнууд өөр хоорондоо ихээхэн ялгаатай байдаг. Швед 1766 онд хуультай болсон нь энэ талаарх хамгийн анхны хууль гэгддэг. Финлянд улс 1951 онд орчин цагийн анхны хуулийг баталсан байна. АНУ 1966 онд мэдээллийн эрх чөлөөний хуультай болсоны дараа 1980 оноос 2001 оны хооронд ийм хууль бүхий улс орнуудын тоо огцом нэмэгджээ. Эдүгээ ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын 80 хувь нь ийм хуультай болжээ. Австри, Нидерланд, Унгар, Польш улсууд иргэдийн мэдээлэл авах эрхийг **Үндсэн хуулиар** баталгаажуулсан бөгөөд мэдээлэл авах эрхийг байгаль орчны хууль, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль болон эрүүл мэндийн хуулиндаа ч бас зааж өгсөн байдаг.

Эдгээр хуулийг боловсруулах явцад иргэдийн мэдээлэл авах эрхийг хувь хүний нууцыг хамгаалахтай болон нууц задарсан тохиолдолд улс нийгэмд хохирол учруулах нууц мэдээллийг хамгаалах хэрэгцээтэй уялдуулах **хоёр төрлийн бэрхшээл** нийтлэг тулгардаг. Тийм учраас мэдээллийн хүртээмж, тодорхой хууль, зохион байгуулалтын цэгцтэй механизм хийгээд хууль сахиулах үүрэг бүхий бие даасан шүүхийн тогтолцоо нь дээр өгүүлсэн ерөнхий хүрээнд зайлшгүй багтдаг. Иргэдийн мэдээлэл авах эрхийн тухай хуулийг боловсруулах, тэдгээр хуультай танилцах явцад дараах зүйлийг санах хэрэгтэй. Үүнд:

Иргэдийн хүртэж болох мэдээллийг тодорхойлох:

- ▶ **Ямар үндсэн шаардлага байх вэ?** Иргэний мэдээлэл авах эрх хуулиар олгогддог. Нууцаас бусад мэдээлэл авах энэ эрхийг ил тодоор хуульчилж болно./ жишээ нь Норвеги, Шинэ Зеланд, Финлянд/
- ▶ **Ямар хязгаарлалтууд байх вэ?** Иргэдийн мэдээлэл авах эрхийг үндэсний аюулгүй байдал, хувийн компанийн талаарх мэдээлэл, хувь хүний нууц, шүүх байгууллагын үйл ажиллагаа зэрэг хүрээнд ихэвчлэн хууль тогтоомжоор хязгаарласан байдаг. Энэ хязгаарлалтыг зарим оронд Засгийн газрын танхимын хуралдааны тэмдэглэл /жишээ нь Исландад/, жил жилийн төсвийн холбогдолтой дотоод ажлын баримт бичгүүд /жишээ нь Норвегид/-ийг хамруулсан байхад зарим оронд нууцын зэрэглэлд хамруулах мэдээллүүдийг тодорхой заагаад /жишээ нь Финляндад/ иргэний хүсэлтээ гаргах эрхийг баталгаажуулж өгдөг.
- ▶ **Хэний мэдээлэл байх вэ?** Хууль тогтоомж нь төрд болон түүний

харьяа улсын болон бүс, орон нутгийн байгууллагуудад /жишээ нь Английн Нэгдсэн Вант Улсад/ мөн сайдаас эхлээд улсын эмнэлгийн дарга хүртэлх /жишээ нь Шинэ Зеландад/ төрийн удирдах болон гүйцэтгэх тушаалын албан хаагчдад, төрийн эрхийг хэрэгжүүлдэг бүх байгууллага, хувь хүмүүст /жишээ нь Финляндад/ үйлчилдэг байна.

- ▶ **Ямар хэлбэртэй байх вэ?** Мэдээллийг хэвлэмэл, дуут, дүрс бичлэг болон цахим бичвэр зэрэг хэлбэрээр нийлүүлж болно. Цахим мэдээллийг хамруулахын тулд зарим улсын хууль тогтоомжийг шинэчлэх шаардлага гарч байв. /Жишээ нь АНУ-д 1996 онд тийнхүү шинэчилсэн/
- ▶ **Хувийн болон мэдээллийн нууцыг хэрхэн хамгаалах вэ ?** Хувь хүний нууцыг хамгаалах талаар тодорхой хуулиуд байдаг бөгөөд тэдгээрийн зарим нь ЭЗХАХБ-аас энэ талаар гаргасан зааварчилгаанд үндэслэдэг. Европын Холбооны чиглэл /Мэдээллийг хамгаалах тухай Европын Холбооны чиглэл 95/46/ЕС/-ийг түүний гишүүн орнууд болон гишүүн болохоор завдаж буй Төв Европын орнууд /жишээ нь Бүгд Найрамдах Чех Улс, Польш Улс/ дагаж мөрддөг. Энэ хамгаалалтанд цахим мэдээллийг хамруулах талаар Канад Улсын 2000 онд баталсан “Хувь хүний холбогдолтой мэдээллийг хамгаалах хийгээд электрон мэдээллийн тухай” хуулийн нэгэн адил зарим хууль тогтоомжийг мөн л шинэчлэх шаардлага гарч болзошгүй.

Мэдээллийн олдоц, хүлээн авах арга замыг тодорхойлох нь

- ▶ **Мэдээлэл авах боломжийг шаардах:** Мэдээлэл авахыг хүссэн иргэнийг өөрийнхөө талаар болон тэрхүү мэдээллийг хүссэн учир шалтгаанаа хэлэхийг төр шаардах ёсгүй гэдгийг хуульчилж болно. Иргэд мэдээлэл хүсэхдээ өөрийнхөө талаар танилцуулах болон уг мэдээллийг хүсэх болсон хууль ёсны шалтгаанаа мэдэгдэхийг зарим оронд шаарддаг нь тэдний эрэлт хүсэлтэд хориг саад учруулдаг юм билээ.
- ▶ **Хэрхэн хүсэлт тавьж, хоригийг давж заалдах вэ ?** Эрх баригчид мэдээлэл өгөхөөс татгалзсан шалтгаанаа бичгээр тайлбарлахыг хуульчилж /жишээ нь Австри, Финлянд, Польш/ болно. Тийнхүү татгалзсаныг давж заалдах арга ажиллагааг хуульд зааж бас болно.
- ▶ **Юуг идэвхтэй хэвлэх вэ?** Иргэд онцлон шаардаагүй байсан ч гол мэдээллүүдийг хэвлэн нийтэлж байх үүргийг төрд хуулиар хариуцуулж болно. Тэр мэдээлэл нь Испан, Шинэ Зеландын нэгэн адил хууль, дүрэм журам, иргэдэд үзүүлж буй үйлчилгээнүүд болон холбогдох байгууллагуудын талаар байж болно.
- ▶ **Ямар хэл дээр байх вэ?** Албан ёсны хэд хэдэн хэлтэй улс орнуудад мэдээллийг албан ёсны аль нэг хэлээр хүлээн авах иргэдийн эрхийг Канад, Финлянд, Люксембург, Швейцарийн жишээгээр хуульчлан баталгаажуулж болно.

- ▶ Хариуг ямар хугацаанд багтааж өгдөг байх вэ ? Мэдээллийн тухай хуулиудад уг мэдээллийг ямар хугацаанд багтааж хүргэхийг ихэвчлэн заасан байдаг. Мэдээлэл хүссэн иргэдэд засаг захиргааны байгууллага хариу өгөх хугацааг хуульд ихэвчлэн 15 хоног /жишээ нь Солонгост/-оос 8 долоо хоног /Австри/-т багтаана хэмээн заадаг.

Мэдээллийн бодлогын элементүүд



Мэдээллийн олдоцын талаарх бодлого нь иргэний хууль ёсны эрхэнд гол үүрэг гүйцэтгэдэг. Иргэд хүссэн мэдээллээ авахыг уг бодлогоор тодорхойлдог. Мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх асуудлыг ч бодлогод тусгаж болно.

Мэдээлэл шуурхай түгээх буюу мэдээлэл, тодруулга хүсэх асуудлаарх бодлого:

- ▶ **Ямар хугацаанд хариу өгөх боломжтой вэ?** Хуульд зааснаас богино хугацаанд хариу өгч байхыг засаг захиргааны байгууллагуудад бодлогоор даалгаж болно. Тэрчлэн хэвлэлийн байгууллагын хүсэлтэд /жишээ нь Польшид 24 цаг байдаг/ эсвэл цахим шуудангаар тавьсан хүсэлтэд /жишээ нь Солонгост 16 цаг байдаг гэх зэргээр хариу өгөх хугацааг нөхцөл байдлаар нь ялгавартай тогтоож болно.
- ▶ **Төлбөр тогтоох уу? Тогтоовол яаж тогтоох вэ?** Мэдээллийг аль ч нөхцөлд /жишээ нь Австрид/ эсвэл нийтийн зорилготой буюу ардчиллын үндсэн эрхээ хэрэгжүүлэхэд чиглэсэн мэдээллийг тодорхой нөхцөлд үнэ төлбөргүй өгч болно. Мэдээллийг хүртэх иргэний эрх нь түүний үнэ өртөгөөр хаагдан боогддоггүй байлгах бодлогыг зарим орон ил тод баримталдаг.
- ▶ **Албан бус хүсэлтэд хэрхэн хандах вэ?** Засгийн газар мэдээлэл авах гэсэн албан бус хүсэлтийг олон тоогоор хүлээн авдаг бөгөөд тэр болгонд өгөөмөр хандаж болно. Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хүрээнд албан ёсны дүрэмд хамруулалгүйгээр, ажил төрлийн холбогдолтой дотоодын ямар бичиг баримтуудыг иргэдэд өгч байхыг тодорхой заасан дотоод журмын үндсэн дээр энэ эрэлт хэрэгцээг хангаж болно. Ажиллагаа ихтэй албан ёсны журмуудыг бодвол энэ хандлага нь дотоод нөөц бололцоог илүү дайчлах сайн талтай /жишээ нь Исланд/.
- ▶ **Мэдээлэлтэй хэрхэн харьцах вэ?** Мэдээллийн хүрэлцээний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь мэдээллийн менежмент буюу түүнтэй хэрхэн харьцахаас ихэд шалтгаалдаг. Мэдээллийн чанар, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах чадавхийг нэмэгдүүлж байх нь байгууллагын дотоодод хийгдэх зохистой хөрөнгө оруулалт мөн.
- ▶ **Мэдээллийг хэрхэн шуурхай түгээх вэ?** Мэдээллийг шуурхай

хэвлэн нийтлэх нь мэдээллийн бодлогын чухал хэсэг юм. Мэдээлэл түгээх нь нийгмийн эрүүл мэндийн гэх мэт кампанит ажлаас эхлээд хэвлэмэл материалыг тогтмол бэлтгэж гаргах /албан ёсны сэтгүүл, жил тутмын тайлан, товхимол, гарын авлага/ болон өргөн нэвтрүүлэг /радио, телевизийн/ гэх зэрэг хэлбэртэй байж болно.

- ▶ **Мэдээллийг хэрхэн танилцуулах вэ?** Мэдээлэл хүлээн авах хийгээд түгээх ажиллагааг зохих үр дүнтэй явуулахын тулд төр, засгийн газрын мэдээллийн эрэлт хэрэгцээг иргэдэд сайтар ойлгуулах шаардлагатай. Чингэхийн тулд тэдгээрийг товч тодорхой, бүрэн гүйцэд байлгах шаардлага тавигддаг нь бүх засгийн газарт ямагт томхон бэрхшээл учруулдаг. Олон нийтэд хандсан материал боловсруулж энэ чиглэлээр ажилладаг засаг захиргааны албан хаагчдад тус дөхөм үзүүлэх зорилгын үүднээс зарим оронд бэлтгэх, баримтлах заавар, үндсэн чиглэл гаргадаг /жишээ нь Итали, Испани/.
- ▶ **Иргэдтэй хэрхэн ерөнхий холбоотой байх вэ?** Иргэдтэй мэргэжлийн болоод нэр төртэй харилцаа тогтооход жишиг буюу стандарт, үндсэн чиглэл төрийн албан хаагчдад тус болдог. Английн төв засгийн жишигт зааснаар төр, засгийн газрын албан хаагч нь иргэдтэй найрсаг, тусархуу, цаг баримталж харьцахын сацуу санал гомдлоо гаргах журмыг тодорхой тайлбарлан таниулах ёстой байдаг.

Мэдээллийн зохион байгуулалтын элементүүд

Мэдээллийн байгууллагууд нь тавигдсан зорилгыг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх нөхцөлийг хангадаг. Тэдгээр байгууллага нь мэдээллийн холбогдолтой хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхийн сацуу хэрэгжилтэд нь хяналт тавьж, хууль сахиулах үүргийг давхар гүйцэтгэдэг.



Мэдээллийн байгууллагуудыг байгуулах, үйл ажиллагааг нь дүгнэхэд дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- ▶ **Хэн гүйцэтгэх вэ?** Төр, засгийн газар, олон нийтийн болон засаг захиргааны бүх шатны байгууллагын хэвлэл мэдээллийн албадад Италийн жишээгээр мэдээллийн үүргийг хариуцуулж болно. Ингэснээр мэдээллийг шуурхай авахад тустайгаас гадна дурдсан албад удирдлагатайгаа байнга шууд харьцдаг тул тэдний дэмжлэг туслалцааг авч, үүргээ биелүүлэх боломж бүрддэг.
- ▶ **Хэн зохицуулах вэ?** Иргэдийн мэдээллийн чиглэлээр хэд хэдэн байгууллага ажиллаж байвал зохицуулагч шаардлагатай болдог. Зохицуулах үйлчилгээ нь тодорхой төрлийн мэдээллийн үйл ажиллагааг нэгтгэн түүвэрлэх, зөвлөгөө өгөх, тухайн ажиллагаа төлөвлөсөн ёсоор явагдаж буй эсэхийг хянах үүрэг гүйцэтгэдэг.

Удирдлагын зүгээс тууштай дэмжих явдал чухал байдаг. Энэхүү зохицуулалтын үүргийг Ерөнхий сайдын алба буюу Сайд нарын зөвлөл /жишээ нь Канад, Нидерланд, Финлянд, Норвеги, Английн Нэгдсэн Вант Улсад / гүйцэтгэдэг.

- ▶ **Хэн удирдаж, хянаж, шаардах вэ?** Мэдээлэл авахдаа, мэдээллийн болон хувь хүний нууцыг хамгаалах тухай хуулиудыг дагаж мөрдөж буй эсэхэд хяналт тавих биеэ даасан байгууллагууд чухал үүрэгтэй. Тэдгээр нь иргэдийн санал хүсэлтийг хүлээн авдаг бөгөөд түүний үндсэн дээр болон өөрсдийн санаачилгаар шалгалт явуулдаг. Олон оронд эдгээр үйл ажиллагааг омбудсмэн /төрийн байгууллагын талаар гомдол гаргасан хувь хүмүүсийн гомдлыг авч хэлэлцэх эрхтэй засгийн газрын томилсон хүн/ буюу комиссараар толгойлуулж мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн байгууллага эрхлэн явуулдаг. Тус байгууллагын тэргүүнийг томилох, үйл ажиллаганых нь тайланг сонсох үүргийг парламент хүлээдэг. Английн Нэгдсэн Вант Улсад мэдээллийн хүртээмж болон хүний хувийн нууцыг хамгаалах асуудлаар нэг комиссар ажилладаг.

Зөвлөгөөний ямар элементийг хэрэглэдэг вэ ?

Зөвлөлдөх хүрээ нь өртөгийн хувьд мэдээллийнхээс хямд боловч бодлого боловсруулах явц дахь түүний ач холбогдолыг олон орон саянаас анзаарч эхэлсэн байна. Финлянд, Исланд, Норвеги, Швед зэрэг оронд ихэвчлэн албан бус байдлаар нийгмийн зөвшилдөөн, иргэдийн хариу мэдээлэл авах явдал нэлээд эртнээс хэвшсэн байна. Чухал, томхон төсөл болон олон улсын гэрээний асуудлаар нийгмийн хүрээнд зөвшилдөх боломжийг Швейцарийн үндсэн хууль бүрдүүлдэг. Тэрчлэн тус орны улс төрийн байгууллагад бүх нийтийн санал асуулгыг иргэдийн шийдвэр гаргах нэгэн хэлбэр болгож баталгаажуулсан байдаг. Энэхүү гарын авлага маань төр, засгийн газрын шийдвэр гаргах эрх мэдлийг хөндөөгүй бөгөөд зөвхөн арга хэрэгслүүдийн талаар өгүүлж буй учраас тэдгээрийг дэлгэрүүлж дурдалгүй орхив. Бодлого боловсруулахад ихээхэн үүрэг бүхий нөөц боломж болох иргэдийн санал гомдлыг хүлээн авах хэлбэрээр зөвлөгөөн бас явуулдаг.

Зөвлөгөөний эрх зүйн элементүүд

Зөвлөгөөний эрх зүйн хүрээг тодорхойлоход дараах зүйлийг анхаарвал зохино:



- ▶ **Санал асуулгын асуултыг хэрхэн үзэх вэ?** Санал хураалтанд сонгуулийн насанд хүрсэн нийт иргэн оролцох эрхтэй бөгөөд бодлогын шинжтэй аливаа асуудлаар албан ёсоор саналын хуудас бөглөж өгдөг.

Санал хураалт нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаар мөн тэрчлэн засгийн газрын хүсэлтээр

эсвэл хэсэг иргэдийн санаачилгаар / жишээ нь Швейцарьт/ явагддаг. Санал хураалт, зөвлөгөөнд /Финлянд, Нидерланд, Шинэ Зеланд, Люксембургийн жишээгээр/, хангалттай тооны иргэд оролцсон тохиолдолд /Польшийн жишээгээр/ заавал мөрдөгдөх чанартай байж болно. Зөвлөлдөх шинжтэй санал хураалт ёс суртахууны хувьд ихээхэн жинтэй бөгөөд төр, засгийн шийдвэрт нөлөөтэй байдаг. Заавал дагаж мөрдөх шинжтэй санал хураалт явуулах нь шийдвэр гаргах эрхийг иргэдэд өгч байгаа хэрэг юм.

Энэ нь улс төрийн удирдлагад ихээхэн нөлөөтэй байдлаар төрийн тогтолцоог гүнзгий өөрчилдөг бөгөөд энэ гарын авлагын хүрээнд багтаагүй өргөн хүрээтэй бусад асуудлыг ч дэвшүүлэн тавьдаг.

- ▶ **“Өргөх бичиг” барих эрх.** Төр, засгийн газарт “өргөх бичиг” барих эрх иргэдэд байж болно. Тэрхүү эрхийг Үндсэн хууль /Испани, Польш, Швейцарь/ болон бусад хуулинд /жишээ нь Бүгд Найрамдах Чех Улс/ тусгаж болно.
- ▶ **Захиргааны арга ажиллагааны хуулиудыг хэрхэн төлөвлөх вэ?** Бодлогын чанартай шийдвэрээр нөлөөлж байх тохиолдолд тэдгээр хууль иргэний эрхийг бэхжүүлдэг /жишээ нь Исланд, Солонгос, Люксембург, Польш, Норвеги/. Тэрчлэн иргэд асуулт тавьж, эрх ашгаа хамгаалах боломжтой урьдчилсан мэдэгдэл болон олон нийтийн хэлэлцүүлэг явуулах талаар хуулинд зааж болно. Эдгээр нь сонирхогч нийт иргэдийн /жишээ нь Финлянд/ эсвэл тухайн шууд холбогдогчийн /жишээ нь Итали/ эрхийг хөндсөн байж болно. Түүнчлэн нэгэнт гарсан шийдвэрийг хэрэгжүүлж эхлэхээс нь өмнө эсэргүүцэх, давж заалдах эрхийг олгож болох юм. /жишээ нь Нидерланд/
- ▶ **Нөлөөллийн үнэлгээний хуулиуд зөвлөгөөнийг хэрхэн сайжруулах вэ?** Эдгээр хууль нь хууль болон бодлогоос гарах үр дүн зарим тохиолдолд хөтөлбөрийг батлагдахаас урьд тэдгээрээс урган гарах нөлөөллийг үнэлж үзэхийг эрх баригчдаас шаарддаг. Дурдсан хуулиуд нь ерөнхий журмын зэрэгцээ байгаль орчин, барилга, газрын ашиглалт гэх зэрэг тодорхой салбарын харилцааг зохицуулсан байж болдог. Эрх ашиг нь хөндөгдсөн иргэдэд хэлэлцэж буй асуудлаар урьдчилсан мэдээлэл авах, санал бодлоо илэрхийлэх боломжийг эдгээр хуулийн заалтууд олгодог /жишээ нь Европын Холбооны гишүүн 15 улс болон Канад, Япон/.
- ▶ **Өвөрмөц сонирхолын бүлэгт хэрхэн хандах вэ?** Хууль буюу бодлогын шийдвэр эрх ашгийг нь хөндсөн тохиолдолд тэдгээр өвөрмөц сонирхолын бүлгүүдтэй зөвлөлдөж байхыг төр, засгийн газар, эрх баригчдаас шаардах хууль байх шаардлагатай /жишээ нь Австрийн мэргэжлийн болон Канадын уугуул иргэдийн холбоод/.

Зөвлөгөөний бодлогын элементүүд



Олон нийтийн үр дүн сайтай зөвлөгөөн болон иргэдийн хариу мэдээлэл /буцах холбоо/-ийг хууль тогтоомж батлалгүйгээр **бодлого** боловсруулахад тусгаж болно. Зарим орон бодлогын шийдвэр гаргахдаа албан ёсны дүрмүүд болон албан бус практик /жишээ нь Финлянд, Исланд/-т түшиглэдэг. Хууль байсан ч гэсэн хуулийг дэмжих бодлого нь тэдгээрийн хэрэгжилтэд цаашдын чиглэл болж өгдөг.

Зөвлөгөөний талаарх бодлогыг төлөвлөх болон дүгнэхэд

- ▶ **Бодлогын шийдвэрт юуг тусгах вэ?** Төр, хийгээд засгийн газрыг иргэд болон сонирхогч талуудтай зөвлөлдөж байхыг төр, засгийн албан ёсны бодлогод тусгах замаар шаардаж болно /жишээ нь Канад/. Дүрэм журам, хөтөлбөр боловсруулах, өөрчлөхийг ч үүнд хамруулж болно. Зөвлөгөөн цаг үеэ олсон, гүн гүнзгий, алив асуудлыг нарийвчлан хэлэлцэхүйц байх шаардлагатайг тэнд мөн дурдаж болно. Бие биенээ давталгүй, “зөвлөгөөний ядаргаанд” автахгүй, төр, засгийн албаны хүмүүс, иргэдийн хүчин чармайлтыг дээд зэргээр ашиглахын тулд хэд хэдэн салбарт хийсэн зөвлөгөөнийг уялдуулан зохицуулахыг бас шаардаж болно.
- ▶ **Дүрмийг хэрхэн боловсруулах вэ?** Дүрэм журам, засгийн газрын шийдвэр, төслийн баримт бичгийн талаар хийх нийтийг хамарсан зөвлөгөөний тухай заасан дүрэм / жишээ нь Норвегид / байж болно. Түүндээ олон нийтийн мэдэгдэл, захидал, факс, цахим шуудан, олон нийтийн хэлэлцүүлэг гэх мэт иргэд санал бодлоо хэрхэн танилцуулж байх /Японд байдаг шиг/ хэлбэрийг зааж өгч болно. Хуулийн төсөл болгонд түүнийг боловсруулах үйл явцын талаар мөн, хүрэх үр дүнгийн талаар болон оролцогч талуудын зөвлөгөөний үр дүнг хураангуйлж үзүүлсэн байхыг шаардаж болно /жишээ нь Канад/.
- ▶ **Үндсэн чиглэл хэрхэн туслах вэ?** Олон нийттэй харилцаа тогтооход бэлтгэх болон уг харилцааг хөгжүүлэхэд нь төрийн албан хаагчдад үндсэн чиглэл тусалдаг. Уугуул иргэд гэх мэт онцлог бүлгийнхэнтэй хэрхэн үр ашигтай зөвлөлдөх баримжааг тэдгээр үндсэн чиглэл олгодог /жишээ нь Канад болон Шинэ Зеланд/
- ▶ **Ямар жишиг баримтлах вэ?** Жишиг тогтоох нь иргэдийн хариу мэдээлэл болон зөвлөгөөнд нөлөөгөө үзүүлдэг. Жишээ нь санал гомдлыг шийдвэрлэдэг Австралийн жишиг гэвэл иргэдийн хариу мэдээлэлтэй харьцах тогтолцоондоо нүдэнд харагдахуйц, хүртээмжтэй, хариуцлагатай байх гэх мэтийн үндсэн гурван шалгуур тавьдаг.

Зөвлөгөөний зохион байгуулалтын элементүүд

Ямар ч сайн хууль, бодлого байгаад тэдгээрийг хэрэгжүүлэх олон нийтийн байгууллага үгүй тохиолдолд үйлчилдэггүй байна. Тэдгээр байгууллага нь иргэдээс төр, засгийн газартаа өөрсдийн санал гомдлыг илэрхийлэх замаар харилцдаг эхний дамжлага байдаг.



Зохион байгуулалтын элементүүдийг авч үзэхэд:

- ▶ **Зөвлөлдөх зөвлөл хэрхэн туслах вэ?** Тодорхой салбарын бодлогын асуудлаар иргэд, иргэний нийгмийн байгууллагууд /ИНБ/-аас илэн далангүй мэдээлэл хүлээн авахад төр, засгийн газарт зөвлөлдөх зөвлөл, комиссууд тус дөхөм үзүүлдэг. Төр, засгийн газар байнгын үйл ажиллагаатай болон түр зуурын байгууллагуудыг үүсгэн байгуулж болно. Зарим улс орон засгийн газар, бизнесийн бүлэг, ажилчдын төлөөллөөс бүрдсэн гурван талт чуулганыг үүсгэн ажиллуулж нэлээд туршлага хуримтлуулсан /жишээ нь Исланд, Люсимбург, Польш/ байна. Бусад хүн ч гэсэн ёс зүйн харилцаа, тахир дутуугийн болон засаг захиргааны шинэчлэлийн гэх зэрэг олон нийтийн төлөөллийн байгууллагуудын үйл ажиллагаанд мөн оролцдог.
- ▶ **Санал гомдлын асуудлаар байгууллага хооронд ямар харилцаа байдаг вэ?** Санал гомдол бүхий иргэд хэнд ханддаг вэ? Зөвхөн энэ зорилгоор дагнасан бүтэц олон оронд байдаг. Иргэд санал гомдлоо засгийн газрын байгууллагууд, тэдгээрийн салбар нэгжүүд, захиргааны асуудлаар зөвлөгөө өгөх төвүүд болон харилцах утсаар /жишээ нь Япон/ уламжилж болно. Эдгээр боломжийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилго бүхий мэдээллийн кампанит ажлыг телевиз, радио, хэвлэлээр өрнүүлж болно.
- ▶ **Парламентын хороод ямар үүрэг гүйцэтгэж болох вэ?** Парламентын хороод зөвлөлдөх боломжийг мөн олгодог. Тэдгээр хороод үйл ажиллагааныхаа хүрээнд хэвлэл мэдээллээр зар сурталчилгаа явуулах замаар олон нийтийг болон тэдний хариу үйлдлийг хөхүүлэн дэмждэг. Тэрчлэн зөвлөлдөх эрх болон бодлогын талаар, олон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар засаг захиргаанаас хийсэн ажил, гаргасан шийдвэрийн хууль зүйн үндсийн талаар ч байж болно. Тэдгээр хороод өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд нийтийн идэвх оролцоо, хариу үйлдлийг уриалж, хэвлэлийн зар сурталчилгаагаар олон түмний мэдлэгийг дээшлүүлж болно /жишээ нь Шинэ Зеландад/.
- ▶ **Ямар байгууллагууд хяналт тавих вэ?** Дээр дурдсан омбудсмэн буюу комиссарын гүйцэтгэх үүрэг нь мэдээллийн салбараас цааш үргэлжилж зөвлөлдөх эрх хийгээд бодлого, засаг захиргааны байгууллагын явуулсан үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийн эрх зүйн талыг хамарч болно. Чингэхдээ өөрсдийн санаачилга, иргэдийн санал гомдлын үндсэн дээр ажиллана. Зарим оронд хуулийн шинэ төслийг хэлэлцэхийн өмнө засгийн газраас олон нийттэй хийсэн зөвлөгөөний үр дүнг парламент нь хянадаг /жишээ нь Дани, Норвеги, Швед/.

Идэвхтэй оролцооны элементүүдийг хэрхэн ашиглах вэ?

Идэвхтэй оролцооны зарчим нь бодлого боловсруулах явцад иргэд идэвхтэй бөгөөд бодит хувь нэмрээ оруулж чадна гэдэг ойлголтод үндэслэдэг. Энэ нь өнөөгийн нийгмийн өмнө тулгараад буй засаглалын олон төрлийн сорилт, бэрхшээлийг даван туулахад нийгмийн өргөн боломжийг бүрэн дайчилдаг бөгөөд засгийн газрыг микро түвшний менежер бус харин хүрээг чадварлаг тодорхойлогч гэж үздэг. Эдгээр хүрээнд зах зээл, иргэний нийгэм, хувь иргэд, бүлгүүд өөрсдийн үйл ажиллагааг болон харилцааг зохион байгуулдаг. Бодлого боловсруулах явцад төр, иргэдийн харилцаа нь чухамхүү энд л түншлэл болдог. Бодлого боловсруулахад иргэдийг оролцуулах нь хэд хэдэн **нөхцөлд** үндэслэдэг. Юуны өмнө бодлогын асуудлыг хэлэлцэх, шинэ хувилбаруудыг санал болгох **иргэдийн бие даасан чадварыг** засгийн газар хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг ч тэдэнтэй хамтран зохиох шаардлагатай. Нөгөөтэйгүүр, эцсийн шийдвэр гаргахдаа тэдний хамтран бүтээсэн бодлогын санал санаачилгуудыг харгалзан үзэх үүрэг авахыг засгийн газраас шаарддаг. Иргэд бодлого боловсруулах явцад өөрсдийнхөө өсөн нэмэгдэж буй идэвх оролцоонд дүйхүйц өндөр **хариуцлагыг** ухамсарлах хэрэгтэй болно.

Идэвхтэй оролцоо бол засгийн газар, иргэдийн харилцааны **шинэхэн талбар** бөгөөд энэхүү шинэхэн талбарыг одоогоор тун цөөн улс орон судалж эхлээд байна. Канадад иргэдийн оролцоог тэргүүлэх ач холбогдолтой бодлогын асуудал хэмээн үздэг. Хамтран ажилладаг засгийн газар бол шийдвэрийг бэлтгэх явцад иргэдийг оролцуулахаар уриалдаг. Энэ талаар Нидерландын засгийн газар өвөрмөц хандлагатай. Тэнд иргэд болон эрх баригчдын хамтын ажиллагаа, зөвшлийн үр дүнд шийдвэр гардаг. Энэ талаар хуримтлагдсан туршлага төдийлөн их бус боловч ихэвчлэн орон нутгийн түвшинд үүсдэг. Иргэдийн уламжлалт эрхээс гадна эрх зүйн, бодлогын, байгууллагын сүлжээний зарим элемент байдаг.

Иргэдийн идэвхтэй оролцооны хүрээг дэмжих элементүүд:



- ▶ **Иргэдийн санаачилсан хууль тогтоомж, санал асуулга үйлчлэх тохиолдолд** иргэдэд Үндсэн хууль болон бусад хуулиар хууль санаачлах /жишээ нь Австри, Польш, Испанид/ буюу заавал дагаж мөрдөх албагүй санал асуулгыг санаачлах /жишээ нь Шинэ Зеланд/ эрхийг олгож болно. Заавал дагаж мөрдөх учиртай санал асуулгыг санаачлах эрх /Швейцарь/-ийг олгохдоо энэ нь төлөөллийн ардчилалд тулгуурладаг засгийн газрын тогтолцоонд нөлөө бүхий шууд ардчиллын элементийг хүчтэй болгодгийг анхаарвал зохино. Эдгээр асуулт энэ гарын авлагаар хязгаарлагдахааргүй өргөн агуулгатай билээ.

- ▶ **Идэвхтэй оролцооны талаарх бодлого өөрсдийн хувилбартай бол яах вэ?:** Иргэний идэвхтэй оролцоог бий болгох, түүний боломж нөхцөлийг сайжруулах зорилтыг засгийн газрын тогтоолоор тодорхойлж болно /жишээ нь Финляндад/. Иргэдэд хамаатай бодлогыг боловсруулахад засгийн газрууд нөхцөлдүүлэгч үүрэгтэй харагддаг боловч энд иргэд өөрсдөө болон иргэдийн байгууллагууд томхон үүрэгтэй оролцох учиртай. Хариуцлагыг орон нутгийн эрх баригчдад, иргэдэд, иргэдийн байгууллагуудад шилжүүлснээр засгийн газрын бодлого энэ зорилгодоо хүрч болно /жишээ нь Нидерландад/. Иргэдийн илүү өргөн оролцоог хөхүүлэн дэмжих заавар чиглэл, энэ талаарх үнэлгээнүүд нь иргэдийн идэвхтэй оролцоонд тус дөхөм үзүүлэх болно/ жишээ нь Канад/.



- ▶ **Идэвхтэй оролцооны хувьслыг засгийн газар хэрхэн дэмжих вэ?** ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад иргэдийн идэвхтэй оролцооны үед байгууллагын зүгээс хүлээдэг тодорхой хариуцлага одоогийн байдлаар байхгүй байна. Сайн практик ажиллагааг нэгтгэн эмхэтгэх, энэ талын мэдэгдэхүүнийг дээшлүүлэх, иргэдтэй ажиллах талаар зааварчилга боловсруулахад чиглэсэн олон төрлийн үйл ажиллагаа явуулах замаар засгийн газар иргэдийн идэвхтэй оролцоог сайжруулахад дэмжлэг үзүүлж чадна.



Үнэлгээний ямар элементийг хэрэглэдэг вэ?

Явуулсан үйл ажиллагаа нь амжилттай болсон эсэхийг мэдэх боломжийг засгийн газарт үнэлгээ олгодог. Төлөвлөх, мэдээлэх, зөвлөлдөх, идэвхтэй оролцох үйл ажиллагааны үндсэн хэсэг нь үнэлгээ юм. Үнэлгээг дэмжихэд чиглэсэн эрх зүй, бодлогын хүрээг зарим орон тодруулсан байдаг.

Үнэлгээний хүрээний элементүүдийг авч үзэхэд:

- ▶ **Үнэлгээнд хэрэв эрх зүйн шаардлага зохимжтой байвал яах вэ?:** Таван жил өнгөрсөний хойно бие даасан үнэлэгчдээр аяндаа үнэлгээ хийлгэж байхаар хуулинд зааж болно /жишээ нь Нидерландын захиргааны тухай хууль/.
- ▶ **Жил тутмын үнэлгээний тайланг албан журмынх болговол яах вэ?:** Иргэдээс хүлээн авсан санал гомдлын талаарх жил тутмын тайлангаа нийтлэх үүргийг яамдад хуулиар хүлээлгэж болно /жишээ нь Испани/.



- ▶ **Үнэлгээний тайланг албан журмаар нийтэлбэл яах вэ?** Уг хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийлгэж, үнэлгээний дүнгээр жил тутмын тайлан хэвлүүлэхийг Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хүрээнд Засгийн газраас шаардаж болно /жишээ нь Норвеги/.
- ▶ **Заавар хэрхэн туслах вэ?** Засгийн газар ажилтнууддаа тус дөхөм үзүүлэх үүднээс үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх талаар дотооддоо мөрдөх заавар журам гаргаж болно. Үнэлгээний чанар нь олдож буй мэдээллийн чансаанаас ихэвчлэн шалтгаалдаг. Үнэлгээнд ямар төрлийн өгөгдөхүүн шаардлагатайг тодорхойлох, тэдгээрийг хэрхэн цуглуулах тал дээр төлөвлөх шатнаас эхлэн анхаарах хэрэгтэй.
- ▶ **Иргэдийг хэрхэн хамрах вэ?** Үнэлгээний явцад иргэд шууд/ Хэлэлцүүлгийн зөвлөлд оролцох замаар/ болон шууд бус /судалгаагаар дамжин/-аар хамрагдаж болно.

Ямар ерөнхий чадавхийг хөгжүүлэх вэ?



Иргэдтэй тогтоосон харилцаагаа бэхжүүлэх зорилгоор тодорхой үйл ажиллагаа явуулахын тулд засгийн газар бодлого боловсруулах явцдаа иргэдийг мэдээллээр хангахаас гадна зөвлөх, идэвхтэй оролцох ерөнхий чадавхийг нь дээшлүүлэх шаардлагатай. Энэхүү ерөнхий чадавхийг наад захын хэмжээнд байлгах нь үйл ажиллагааг эхлүүлэх төдийгүй үр дүнтэй явуулах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлдэг. Эл ерөнхий чадавхийг бий болгох нь төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх үйл ажиллагааны мэргэжлийн шинж, амжилтад хүрэх боломжийг нэмэгдүүлдэг. Ерөнхий чадавхийн доод түвшнээс эхлээд дээд түвшинд хүртэлх нийтлэг шинжүүдийг дараах жагсаалтаас өргөн хүрээтэй харж болно.

Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх ерөнхий чадавхийг бий болгож хөгжүүлэхдээ доорхи зүйлд анхаарна . Үүнд:

- ▶ **Зохистой бүтэц:** Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх асуудлыг засгийн газрын бүтцийн хүрээнд аль нэг байгууллагад тодорхой байдлаар хариуцуулах хэрэгтэй. Олон орны засгийн газрууд энэ талаарх тодорхой ажлуудыг буюу уялдуулан зохицуулах, удирдан чиглүүлэх үүрэгтэй нэгжийг тохоон томилдог /Тодорхой мэдээллийг “Мэдээллийн зохион байгуулалтын элементүүд”, “Зохион байгуулалтын ямар элементүүдийг хэрэглэх вэ ?” бүлгээс үзнэ үү/.
- ▶ **Удирдлагын ерөнхий үүрэг ба шийдвэр гаргахад хүрэх гарц:** Бодлого боловсруулах явцад иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоог нэмэгдүүлэх талаар албан хаагчдын тавьж буй хүчин чармайлт нь дээд удирдлагаар дэмжүүлсэн тохиолдолд үр дүнд хүрдэг. Тийм учраас улс төрийн болон захиргааны удирдлагын тууштай дэмжлэг нэн чухал.

Энэ байдал нь эдгээр үйл ажиллагааг удирдлагаас тодорхой байдлаар сонирхох, мэдэгдэхүйц хэлбэрээр дэмжихийг шаарддаг. Тэрчлэн, иргэдээс оруулсан хувь нэмрийг чухамдаа шийдвэр гаргах явцад авч үзэх бололцоог бүрдүүлэх талаар удирдлага болон энэ ажлыг гүйцэтгэж буй ажилтнууд анхаарч байх учиртай.

- ▶ **Ерөнхий нөхцөл бололцооны суурь:** Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоог засгийн газар санхүүгийн болон хүн хүчний талаас нь дэмжих ёстой. Санхүү, хүн хүчний наад захын ийм дэмжлэггүйгээр ямар нэгэн үйл ажиллагаа явагддаггүй бөгөөд иргэдтэй ч харилцаагаа бэхжүүлэх боломжгүй болно.
- ▶ **Дотоод чадавхийг дээшлүүлэх нь:** Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд тодорхой хэмжээний чадвар шаардагддаг. Тэдгээр чадварын олонхийг засгийн газрын хүрээнд бий болгож, хөгжүүлэх боломжтой байдаг бөгөөд дурдсан үйл ажиллагааг төлөвлөх, хөтлөн явуулах дадлага чадварыг ажилтан албан хаагчдад сургалтаар эзэмшүүлж болно. Мэргэжлийн туршлага, зохих чадвартай ажилтнуудыг элсүүлж авах нь тухайн байгууллагыг дотроос нь чадваржуулах, тэрхүү байгууллагын дотоод чадавхийг дээшлүүлэхэд тус дөхөм үзүүлдэг. Сэтгүүл зүй, олон нийттэй харилцах хийгээд хэвлэл, зар сурталчилгааны ажилтны нэгэн адил техникийн шийдэл гаргах зорилготой хүмүүст холбоо харилцааны техникийн талаарх мэдлэг, туршлага онцгой шаардлагатай байдаг. Гэтэл төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд түүнээс хамаагүй өргөн хүрээний мэдлэг чадвар тухайлбал, стратегийн, улс төрийн болон тодорхой асуудлуудаар ажиллах чадвар, үйл ажиллагааг төлөвлөх, өөрчлөх, хэрэгжүүлэхээс эхлээд холбоо харилцааны болон удирдлагын гэх мэт олон төрлийн дадлага чадвар шаардагддаг.
- ▶ **Гадны зөвлөгөө, хөрөнгө хүчний дэмжлэг:** Иргэдтэй харилцаагаа бэхжүүлэхдээ засгийн газрууд энэ ажлыг харьцангуй сүүлд эхэлж буй эсвэл нэлээд туршлагажсан гэдгээс үл хамааран гадны туршлагыг авч хэрэглэдэг. Гадны туршлага гэдэг нь дээд түвшний стратегийн зөвлөгөө /эрх зүй, зохион байгуулалтын хүрээг тодорхойлох буюу арга хэмжээг төлөвлөх/, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх техникийн зөвлөгөө /вэб хуудас зохиох гэх мэт/ янз бүрийн хэлбэртэй байж болно. Гадны туршлагыг авч хэрэглэх нь засгийн газарт бусдаас суралцах бололцоо олгодог. Гадны хөрөнгө хүч ашиглах нь үйл ажиллагааны ачааллыг бууруулахад тустай. Гэхдээ өөрийн хөрөнгө оруулалт хийх дотоод чадвахаа нэмэгдүүлэхээс зайлсхийх зорилгоор гадны туршлага, хөрөнгө хүчийг ашиглаж болохгүй. Гадны тусламжийг засгийн газрын зааварт нийцүүлээ ч гэсэн шийдвэр гаргах явцад шууд холбогддогийн хувьд дотоодын туршлага, дадлага зайлшгүй шаардлагатай.


- ▶ **Дотоодын мэдээлэл, нээлттэй харилцааны соёл:** Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог тодорхой байдлаар хариуцсан нэгж, ажилтнуудыг засгийн газрын бүтцэд томилж ажиллуулах нь ашигтай. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх зорилтыг засгийн газар болон засаг захиргааны байгууллагын бүх түвшинд ижилхэн дэмжиж байх нь түүнийг амжилтад хүргэх үндсэн нөхцөл юм. Тэрчлэн Засгийн газар, иргэдтэй харилцаагаа бэхжүүлэхэд эрх зүйн үүднээс хүлээх үүрэг, ашиглах боломж хийгээд тодорхой арга замуудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх замаар энэ зорилгод хүрч болно. Засгийн газар тэрчлэн, үйл ажиллагааны шилдэг хэлбэр, урамшил, олон нийтийн сонирхол, үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих бодлогын элементүүдийг ашиглаж болно. Энэ мэтээр ил тод, нээлттэй байдал, иргэдтэй харилцах харилцааны ерөнхий соёлыг бүрдүүлэхэд засгийн газар зорилгоо болгон ажиллаж болно.

Стратегийн үүднээс төлөвлөж ажилла!

Ерөнхий хүрээг тодорхойлсоны үндсэн дээр төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх тодорхой үйл ажиллагааг засгийн газар явуулах боломжтой. Хамгийн гол нь үйл ажиллагааг шууд эхлэхдээ биш харин хэсэгхэн зуур ч болов эрэгцүүлж бодох нь чухал. Ямар үр дүнд хүрэх вэ? Амжилтанд хүрсэн эсэхээ хэрхэн мэдэх вэ? Эдгээр асуултыг урьдаас сайтар бодоогүйгээс төр, иргэдийн харилцаа бэхжүүлэх ажилд бэрхшээл учрах нь бий.

Бодлого боловсруулах явцад иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог дээшлүүлэх ажлыг амжилтанд хүргэхийн тулд **стратегийн үүднээс бодож төлөвлөх, ажиллах** явдал нэн чухал. Үзэл баримтлал бий болгох, төлөвлөх, хэрэгжилтийн болон үнэлгээний **үе шатуудыг** өөр хооронд нь сайн ялгаж зааглах хэрэгтэй. Үзэл баримтлал бий болгох буюу төлөвлөх шатанд хийгдсэн хөрөнгө оруулалт дараа дараагийн бүх шатанд үр шимээ өгдөг. Хүрэх зорилт, чухам хэнд хандах, ямар хөрөнгө хүч хэрэглэхээ тодорхойлох хэрэгтэй. Ингэснээр ямар арга хэрэгслийг сонгох, үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох бололцоо бүрдэнэ.

Анхнаасаа үнэлгээ хэрхэн хийгдэхийг төлөвлөх нь хийж гүйцэтгэсэн ажил тань амжилт олох эсэх, хэрэв амжилт олсон бол хэдий хэр амжилт олсон, ирээдүйд төлөвлөлт, үйл ажиллагаагаа яаж боловсронгуй болгохыг мэдэх боломж олгодог.



Үзэл баримтлал бий болгож төлөвлөх нь энэ бүлэгт заасны дагуу **алхам алхамаар** хийгдэх ажиллагаа юм. Гэсэн хэдий боловч элементүүдийн уялдаа холбоог харгалзах үүднээс **урагш харайх, гэдрэг ухрах** шаардлагатай мэтээр засгийн газрын албан хаагчдад ойлгогдож магадгүй. Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог төлөвлөхөд дүн шинжилгээний нэгэн адил бүтээлч хандлага тун чухал. Бүтээлчээр хандахын тулд маневр хийх боломжтой байх ёстой. Зорилго болон олон нийт бол хамгийн чухал элемент гэдгийг бодохын сацуу эцсийн бүлэгт зорилгодоо нийцсэн үйл ажиллагаа явуулахаас биш эсрэгээр байж таарахгүйг санах хэрэгтэй.

Ямар зорилгууд тавих вэ?

Юунд хүрэх вэ? гэдгийг зорилго маань тодорхойлдог. Өөрөөр хэлбэл зорилго бол бидний хүрэхээр зорьсон **үр дүн** буюу үйл ажиллагаанаас урган гарах үр дагавар юм. Төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх явцад үндсэн асуудлыг анхааралдаа байлгахад маань зорилго тус болох бөгөөд үйл ажиллагааг зөвтгөх буюу нотлох үндэслэл болж үйлдлүүдийг өргөн хүрээнд харах бололцоо олгодог.

Гарын авлагын эхний бүлэгт төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх хэд хэдэн зорилтыг тодорхойлсны дотор хамгийн чухал нь төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх явдал орно. Тэрчлэн гарын авлагад төр, иргэдийн харилцааг бэхжүүлсэнээр ардчилал боловсронгуй болно, бодлого илүү оновчтой болно, хэрэгжилт дээшилнэ, сайн дурын үндсэн дээр дагаж мөрдөх явдал нэмэгдэнэ гэх мэтээр өргөн хүрээтэй хэд хэдэн үр дагаварыг дурдсан. Мөн эдгээр үр дагаварт хүргэх механизмыг тухайлбал, иргэдийг мэдээллээр хангах, тэдний оролцоог эрэлхийлэх, ашиглах улмаар бодлого боловсруулахад тусгах хэмээн тодорхойлсон. Дурдсан элементүүд нь хамтдаа төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх үйл ажиллагааны тухайн **нөхцөл байдал, үр дагавар, механизмыг** бодлогын хүрээнд үзүүлж байна. Элементүүд өөр хоорондоо холбоотой төдийгүй төрөл бүрийн түвшний зорилтуудад тохирдог. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх ажлыг төлөвлөхөд наад зах нь **гурван түвшний зорилго** тавигддаг.

- ▶ **Засгийн газрын өргөн хүрээний зорилгод ямар хувь нэмэр оруулах вэ?** Ерөнхий болон тухайн салбарын бодлогын зорилтод тэд хэрхэн нийцэх вэ?
- ▶ **Үйл ажиллагааны дүнд ямар үр дагавар бий болох вэ?** Төлөвлөсөн үйл ажиллагаанаас ямар шууд үр дүн гарах вэ?
- ▶ **Эдгээр үр дүнд хүрэхийн тулд хэрхэх вэ?** Ямар механизм хэрэглэх вэ? Хэрхэн амжилтанд хүрэх вэ?

Зорилгоо тодорхойлох үедээ:

- ▶ **Бүх түвшинд тавигдах цогц зорилтуудтай уялдуудах:** Энэ нь үйл ажиллагааг тухайн нөхцөл байдалтай холбож, засгийн газрын өргөн хүрээний зорилтуудтай уялдуулж өгдөг.

- ▶ **Бодитой байх:** Ихийг санаархахад муу зүйл байхгүй боловч төлөвлөлтийн шатанд бодит байдлаас давсан хэт өндөр зорилт тавиад үл биелэхээр сэтгэл алдрах, урам хугарахад хүргэж болно.
- ▶ **Зорилгыг олон нийт, хөрөнгө хүч, үйл ажиллагаанд тохируулах**
- ▶ **Зорилгоо цаасан дээр буулгаж бичих** нь зорилгыг тодруулж, дүгнэхэд хялбар болгоно.
- ▶ **Санал бодлоо хуваалцах нь:** Зорилгоо тодорхойлохдоо ажилтнуудтай хамтран томъёолж, үгүйдээ тэдэнтэй санал бодлоо хуваалцах нь зүйтэй. Тэгсэнээр ажилтнууд юуны төлөө ажиллаж буйгаа ойлгож мэдрэх болно. Хэрэв боломжтой бол хамтран оролцогчид, олон нийттэй нэгэн адил санал бодлоо хуваалцах хэрэгтэй.

Хэнд хандах вэ?

Ямар иргэн мэдээлэл хүлээн авах, зөвлөлдөх, идэвхтэй оролцох хэрэгтэй вэ? Ихэнхдээ, хамгийн гол нь танай улсын нийт иргэд, гэхдээ зарим тохиолдолд гагцхүү тухайн нутаг дэвсгэрт оршин суудаг иргэдийг хамрах хэрэгтэй. Түүнчлэн бусад орны иргэдэд хандах, тэдэнтэй харьцахыг та бүхэн хүсч бас болно. Тэдгээр иргэдийг олон нийт гэж нэрлэдэг. Зарим тохиолдолд тэднийг сонгосон бүлэг гэж нэрлэдэг. Олон нийт гэдэг бол төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх замаар таны хүрэх, ажиллахыг зорьсон бүлэг иргэн юм шүү. Дараах учир шалтгааны улмаас олон нийтийг бүлэг иргэн хэмээн ялгаж үзэхийг зайлшгүй хийх шаардлагатай эхний алхам гэж тооцож болно. Тухайлбал,

- ▶ **Тухайн бодлогын хүрээнд:** Жишээ нь нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ г.м
- ▶ **Газар зүйн бодлого:** жишээ нь хөдөөгийн буюу алслагдсан нутгийн хүн амын тухайд орон нутгийн хэсэг бүлэг иргэн оролцоно.
- ▶ **Бодлогын өөр өөр үе шат:** Бодлогын өөр өөр үе шатаас хамааран та бүхэн өөр өөр тооны, өөр өөр хэсэг бүлгийн хүмүүст хандаж болно
- ▶ **Ялгаатай шинж чанарууд:** Хэл, угсаа гарал болон бусад талаарх цөөнх буюу нас, хүйс, ажил мэргэжлийн ялгаатай бүлгүүд гэх мэт,
- ▶ **Хэвлэл мэдээллийг ашигладаг байдал:** Интернет ашигладаг, сонин хэвлэл ашигладаг иргэд.

Иргэд хэрэгжүүлж буй асуудалд шууд холбогдсон тохиолдолд тэдгээрийг **сонирхогч талууд** гэнэ. Эрх ашиг нь шууд хөндөгдөж байгаа учраас тэд бодлого боловсруулах явцад зайлшгүй хандах ёстой чухал **олон нийт** юм. Засгийн газар тэдний болон олон нийт эсвэл холбогдох бүх **иргэдийн** хооронд тэнцвэртэй хандах шаардлагатай болно. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхээр чармайхдаа засгийн газар хувь иргэдээс бүрддэг олон нийтэд хандах нь олонтаа. Мөн ажилчдын, бизнесийн, мэргэжлийн байгууллагууд, бусад сонирхолын бүлгүүд буюу иргэний нийгмийн байгууллагуудад хандаж болно. Дээрх

байгууллагууд болон тэдгээрийн ажилтнууд тодорхой асуудлуудаар иргэдийн үзэл бодлыг илэрхийлдэг бөгөөд тэдэнтэй харьцдаг иргэдтэй холбогчийн үүрэг гүйцэтгэдэг. Тийм учраас тэдгээр байгууллага нь бас л зайлшгүй хандвал зохих олон нийт болдог. Тэдгээр байгууллага нь эгнээндээ багтаасан иргэдийнхээс ондоо өөрийн өвөрмөц сонирхолтой байх нь бий. Хэдийгээр чухал боловч тэдгээр байгууллагыг хувь иргэдтэй хольж андуурахгүй байх нь чухал.

Олон нийтийг тодорхойлохдоо :

- ▶ **Хариулт өг:** Тухайн асуудлаар хэнд хандах нь чухал вэ? гэдгийг өмнө өгүүлсэн шалгуур үзүүлэлтээр хариулах хэрэгтэй.
- ▶ **Тодорхой бай:** Мэдээлэл, зөвлөгөөн, оролцоонд хэнийг хамруулахаа сонгохдоо тодорхой байх хэрэгтэй. Тодорхой бус байснаас хөрөнгө мөнгө үрэгддэг.
- ▶ **Олон нийтийн шинж байдлыг ажигла:** Зохистой хандлага, тохиромжтой үйл ажиллагааг сонгоход хэвлэл мэдээллийг ашигладаг байдал, байрлал, үндсэн сонирхол гэх мэт туслана.
- ▶ **Зорилго, хөрөнгө хүч, болон үйл ажиллагаатай олон нийтийг уялдуул.**
- ▶ **Өргөн хамруул:** Нээлттэй, эрх тэгш хүртээмжтэй байдал бол төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх чухал гарц болдог.

Арга хэрэгсэл, түүнийг хэрхэн сонгох вэ ?



Олон нийтэд хүрч, тавьсан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тохирох арга хэрэгслийг хэрхэн сонгох вэ? Арга хэрэгслийг сонгох нь иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог төлөвлөхөд чухал үүрэгтэй. Арга хэрэгслийг шилж сонгох нь бүхэлдээ засгийн газрын өмнө тулгарсан нөхцөл байдлаас ихэд хамаардаг.

- ▶ **Зорилго:** Олон нийтийн ойлголт, мэдэгдэхүүнийг дээшлүүлэх, үр дүнд хүрнэ гэж зоривол түүнд нийцсэн мэдээллийн хэрэгслийг шаардана. Хэрэв олон нийтээс хариу мэдээлэл авах зорилт тавигдвал зөвлөлдөх арга хэрэгслийг сонговол зохино. Бодлогын шинэ хувилбар боловсруулахдаа олон нийтийг хамарч оролцуулахыг зоривол тэднийг идэвхтэй оролцуулах арга хэрэгслийг ашиглах болно.
- ▶ **Олон нийт:** Төртэй харилцаа тогтоолгохоор зорьж буй тухайн олон нийтэд тохирсон арга хэрэгслийг сонгож авахын сацуу хэрэглэх шаардлагатай. Жишээ нь улс орны нийт иргэдэд хандах зорилт тавигдсан гэж үзвэл мэдээллийг бүх нийтэд нэн ойлгомжтой байдлаар хүргэх арга хэрэгслийг сонгож авах нь тодорхой.
- ▶ **Хөрөнгө хүч:** Хангалттай хөрөнгө хүчгүйгээр арга хэрэгслийг хэрэглэх боломжгүй. Сонгож авсан арга хэрэгсэл нь байгаа ажилтнууд болон

техник хэрэгсэлтэй, засгийн газраас зарцуулах боломжтой хөрөнгө хүчний хэмжээнд нийцсэн байх шаардлагатай.

Тавьсан зорилго, олон нийт болон хөрөнгө хүчинд тохирсон арга хэрэгсэл сонгосон атал засгийн газрын албан хаагчид шаардлагатай түвшинд хүртэл олон нийттэй холбоо тогтоож, өмнөө тавьсан зорилгод хүрэхэд ганцхан арга хэрэгсэл хангалтгүй гэж үзэж болно. Ер нь бол хэд хэдэн төрлийн **арга хэрэгслийг хослуулан** хэрэглэдэг. Арга хэрэгслүүдийг ийнхүү хослуулан хэрэглэх нь олон нийтэд хүрэх, тавьсан зорилгоо сайтар шийдвэрлэхийн тулд хэд хэдэн байдлаар оролдох боломжийг засгийн газарт олгодог. Мэдээлэл, холбооны шинэ технологи /МХТ/-ийн өнөө үеийн арга хэрэгслүүдийг хослуулан хэрэглэх явдал улам бүр ач холбогдолтой болж байна. **Уламжлалт болон МХТ-ийг хослуулах нь** МХТ-д тулгарсан саад бэрхшээлийг гэтлэн давахын сацуу үр дүнг ихээхэн дээшлүүлдэг.

“Арга хэрэгслийг сонгох, хэрэглэх” хэмээх дараагийн бүлэг нь арга хэрэгслүүдийн олон төрөл хийгээд бүтэц, ерөнхий дүр зургийг үзүүлэх болно. Тэдгээрийн хэрэглээний үндсэн чиглэлийн дагуу мэдээллийн, зөвлөгөөний, идэвхтэй оролцооны, үнэлгээний арга хэрэгсэл гэж ангилдаг. МХТ-д суурилсан шинэ арга хэрэгслүүдэд дараа дараагийн бүлгүүд түлхүү анхаарал хандуулах болно. Гарын авлагад дурдсан дүр зураг, бүтэц, жишээнүүд нь засгийн газарт тулгарсан өвөрмөц нөхцөл байдал, сорилтуудад тохирохуйц арга хэрэгслүүдийг зөв зүйтэй хослуулан сонгоход таныг зоригжуулж, бүтээлчээр сэтгэхэд тань туслах болно.

Арга хэрэгсэл, үйл ажиллагааны хослолыг тодорхойлоход

- ▶ **Бэлэн байгаа арга хэрэгслүүдтэй танилцах нь:** Бусад орны засгийн газар болон орон нутгийн засаг захиргаадын туршлагаас хэрэгтэй жишээгээ олж авах болно.
- ▶ **Зорилго, олон нийт болон хөрөнгө хүчинд тохирсон арга хэрэгслийн хослолыг бий болгох нь:** Тодорхойлсон зорилт, олон нийт, хөрөнгө хүчинд тулгуурлан арга хэрэгслийг сонгохоос бус эсрэгээр байж таарахгүй. Арга хэрэгслүүдийн хослолыг бий болгох нь хэдий сонирхолтой боловч тэдгээрийг гагцхүү нөхцөл байдалд тохируулж сонгох хэрэгтэй.
- ▶ **Боломжтой нөхцөлд уламжлалт арга хэрэгслүүдийг шинэ МХТ-той хэрхэн хослуулах талаар бодох хэрэгтэй.**
- ▶ **Арга хэрэгслүүдийг хэрхэн хэрэглэх талаар тодорхой бодох хэрэгтэй.** Арга хэрэгслүүдийг цаашдаа хэрхэн хэрэглэх талаар төлөвлөх нь /хэдийд, хаана, ямар зорилгоор, юу хийж бүтээх гэх мэт/ үйл ажиллагааг үр дүнтэй болгодог.

Хөрөнгө хүчний талаар

Олон нийтэд хандахад яах вэ? Тавьсан зорилгодоо хүрэхэд танд ямар хөрөнгө хүч байгаа билээ? Энэ бол чухамдаа хэн, ямар зорилгоор юу хийх билээ гэсэн үг. Ямар материал, үйлчилгээ шаардлагатай вэ? Тэр нь ямар үнэ өртөгтэй билээ? Хэрэгтэй мөнгө болон хүмүүсийг хаанаас олох вэ?

Хөрөнгө хүч, хүний чадавхи хоёр төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх ажлыг практик дээр эхлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

- ▶ **Хөрөнгө хүч** гэдэг бол хэрэгтэй материал шаардлагатай үйлчилгээнд зарцуулах боломжтой нөөц юм. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх зорилготой уялдан засаг захиргааны зардлын нэг хэсэг болгон тооцоолсон байдаг. Хэдий тийм боловч үйл ажиллагаанд зарцуулах нөөцийг засаг захиргааны ерөнхий төсөв, тусгай бодлогын төсөв зэргээс гаргах боломжтой байдаг.
- ▶ **Хүний чадавхи** гэдэг нь үйл ажиллагаанд зарцуулж чадах хувь хүний цаг завын тухай ойлголт юм. Үйл ажиллагаатай холбогдсон зорилгыг хэрэгжүүлэхэд хэдэн хүн хэрэгтэй вэ, түүнд зориулах ажлын хугацаа нь хэд байх юм бэ? Хүний чадавх гэдэг нь мөн тэрчлэн хүний бололцоот чадамжийн хэмжээний тухай ойлголт юм. Төлөвлөх, хэрэгжүүлэх, хувиргах бодлогыг хэрэгжүүлэхэд боловсрол нь ямар вэ, дадлага туршлага нь ямар вэ гэх мэтийн асуулт гардаг. Ямар зохицуулалт шаардагдах вэ? Улс төрийн удирдагч, дээд удирдлага, мэргэжилтнүүдээс үүрэг хариуцлага байна уу? Хүрэлцээтэй хөрөнгө хүчтэй байх нь амин чухал.

Үүнгүйгээр төр иргэдийн хоорондын харилцааг бэхжүүлэх ажил цааш явахгүй. Хөрөнгө хүчний тоо, хэлбэр нь ямар төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж болох вэ гэдэг боломжийг олгодог. Тэдгээр нь ямар ч тохиолдолд агуу их үр нөлөөтэй буюу олон түмэн хэр их амжилт олох ямар зорилгоор хүрэхэд нөлөөтэй. Эдгээр нь төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх практик хүрээний хамгийн чухал зүйл нь юм.

Тийм учраас **хөрөнгө хүчийг тавьсан зорилго болон үйл ажиллагаа** буюу арга хэрэгсэлтэй нийцүүлэх нь чухал байгаа юм. Тодорхой үйл ажиллагаа явуулахад ямар хөрөнгө хүч шаардлагатай вэ? Олдож буй хөрөнгө хүч маань эл ажилд хүрэлцэх үү? Үгүй юу? Хөрөнгө хүч үйл ажиллагаанд нийцэж байвал нэн сайн. Хэрэв үгүй бол яах хэрэгтэй вэ?

- ▶ **Байгаа хөрөнгө хүчинд бүтээлчээр ханд:** Арга хэрэгслийг хямд зардлаар, богино хугацаанд хэрэглэх боломж бий юу гэдгийг бодож үзэх хэрэгтэй. Ижил үр дүнтэй атал илүү хямд арга хэрэгсэл байж ч мэднэ шүү.
- ▶ **Нэг хөрөнгө хүчээр бусдыг орлуул:** Хангалттай хүч хөрөнгөтэй боловч хүн цөөн байх үед тавигдсан зорилтуудын зарим хэсгийг засгийн газрын бодлогын тэргүүлэх зорилго чиглэлд харшлахгүй нөхцөлд гэрээний үндсэн дээр засаг захиргааны байгууллагын биш гадны хүмүүсээр гүйцэтгүүлж болно. Нөгөөтэйгүүр, хөрөнгө багатай, хүн хангалттай үед гадны гэрээлэгчээр гүйцэтгүүлчихмээр ажлыг дотоодын хүчээр хийх талаар ч бодож болно. Энэ шийдвэр хэр зэрэг бодитой болохыг өөрсдийнхөө дотоодын боломж бололцооны хэрээр нягталж үзэх хэрэгтэй.

- ▶ **Хөрөнгө хүчний суурийг нэмэгдүүл:** Удирдлагын шат дамжлагын дээд хэсгээс хөрөнгө хүчний дэмжлэг эрж болно. Удирдлагын тууштай байдал энд мөн л чухал. Таны хийж буй ажил төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх талаар төр, засгийн бусад нэгжийн өмнө тавигдсан зорилтуудтай давхцаж байх тохиолдолд захиргааны бусад нэгж болон хөтөлбөрөөс санхүүгийн дэмжлэг, хүн хүчний туслалцаа авахаар оролдож болно.
- ▶ **Тэргүүлэх зорилтуудыг тодорхойл:** Таны мэдэлд ямар хэмжээний хөрөнгө хүч байлаа ч гэсэн бүх зүйлийг нэгэн зэрэг хийж амжуулах боломжгүй учраас тэргүүлэх зорилтуудаа тогтоох хэрэгтэй. Хэчнээн хичээсэн ч хөрөнгө хүч тань хангалтгүй байвал тодорхой үйл ажиллагаа, олон нийт, зорилгодоо тэргүүлэх ач холбогдол өгөх хэрэгтэй.
- ▶ **Хэмжээ хязгаарыг мэдэр:** Засгийн газрын бусад аливаа ажлын нэгэн адил төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх ажилд хөрөнгө хүч хэмжээ хязгаартай. Зорьсон ажилд тань хөрөнгө хүч хангалтгүй байвал ил тод хүлээн зөвшөөрч үйл ажиллагааны хэмжээ хязгаар, хүрч ажиллах учиртай олон нийтийн тоонд тавигдах хэмжээ хязгаар, хүрэхээр тэмүүлсэн зорилгод тавигдах хэмжээ хязгаар гэх мэт үүдэн гарах үр дагаваруудыг тодорхойлохын хэрээр тэдгээрийг удирдлага тань мэддэг болгох хэрэгтэй.

Хөрөнгө хүчний асуудлыг авч үзэхдээ:

- ▶ Улс төрийн болон захиргааны удирдлага, хамт ажиллагсдаар нь **үүрэг авахуулах** хэрэгтэй. Энэ бол төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд амжилт олох урьдчилсан нөхцөл юм.
- ▶ Өөрт байгаа боломжоо хөрөнгө, хүн хүчний чадавх талаас нь **эрэгцүүлж үз**.
- ▶ **Хөрөнгө хүчээ зорилт, олон нийт, үйл ажиллагаандаа тохируул**
- ▶ Хүний болон хөрөнгийн **эрэлт хэрэгцээг** анхаар.
- ▶ Хөрөнгө хүч хангалттай биш үед **дээр дурдсан зүйлийг мөрд**.

Үнэлгээг хэрхэн төлөвлөх вэ?

Зорилгоо дэвшүүлж, олон нийтээ тодорхойлсон, хөрөнгө хүчээ хуваарилсан, арга хэрэгслээ шилж сонгосон тохиолдолд төлөвлөлөлтийн нэн чухал бөгөөд эцсийн шат нь үнэлгээ байх болно. Үнэлгээг төлөвлөж, хэрэгжүүлэх нь засгийн газрын албан хаагчдад дараах байдлаар тус дөхөм үзүүлдэг. Үүнд:

- ▶ **Арга хэрэгсэл үр дүнтэй байна уу?** Төлөвлөсөн ёсоор олон нийттэй холбоо тогтоосон уу? Хөрөнгө хүч хангалттай юу? Зорилго тань биелсэн эсэх? гэх мэтээр үйл ажиллагаа тань амжилттай явагдаж буй эсэхийг мэднэ.

- ▶ **Төлөвлөлт болон үйл ажиллагааг нотлох нь чухал учир** үйл ажиллагаа тань амжилттай явагдаж буйг бусдад харуулна.
- ▶ **Үр дүнг үнэлж, бусадтай хуваалцах замаар засгийн газар туршлагаасаа суралцдаг.** Ингэснээр засгийн газар үйл ажиллагаануудыг өөр хооронд нь жишиж сайныг олж тодорхойлох хэмжүүр үзүүлэлт бий болгодог. Энэ нь төлөвлөлт, практик ажиллагааг сайжруулах, төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх талаарх тухайн байгууллага доторх мэдлэгийг дээшлүүлэх урамшлыг бий болгоно.
- ▶ **Үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад болон дараа нь энэ бүгдийг хийж гүйцэтгэ.** Үнэлгээ өгөх ажлыг төлөвлөх нь амжилт ололтыг харж ажиглах, хэрэгжсэний нь дараа төдийгүй, явцад нь өөрчлөх бололцоог олгодог.
- ▶ **Үнэлгээ бол зохистой төлөвлөлтийн нэгэн хэсэг байх ёстой.** Хэрэв засгийн газар үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа эсвэл дараа нь үнэлгээний тухай бодох аваас авах арга хэмжээ тодорхойлогдохгүй, шаардлагатай өгөгдөхүүнүүд цугларахгүй, үнэлгээний эх баримтууд олдохгүй болох учир боломж алдагдаж зайлшгүй бэрхшээлтэй тулгарна.

Үнэлгээний ерөнхий байдал, загвар, тэдгээрийг практикт хэрхэн хэрэгжүүлэх талаар дараагийн хоёр бүлэгт дурдах болно. Үнэлгээг төлөвлөхөд арга хэрэгслүүдийг сонгох хийгээд хэрэглээнд бэлтгэх ажиллагаа мөн багтдаг.


Үнэлгээ хийх, өөрчлөн төлөвлөх явцад дараах зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- ▶ **Үнэлгээний арга хэрэгслүүд болон тэдгээрийн хэрэглээг төлөвлөлтөд тусгасан байх шаардлагатай.**
- ▶ **Үнэлгээний арга хэрэгслүүд нь зорилго, олон нийт, хөрөнгө хүчтэй болон мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны арг хэрэгслүүдтэй тохирч байх ёстой.**
- ▶ **Үйл ажиллагааны дараа үнэлгээ хийх төдийгүй боломжтой тохиолдолд явцад нь үнэлгээ хийх хэрэгтэй.**
- ▶ **Үнэлгээний чадавхийг дүүрэн ашиглах хэрэгтэй:** Амжилтыг хэмжих, илэрхийлэх туршлагаас суралцах, байгууллагын дотоодод мэдэгдэхүүн түгээх, тухайн үеийн болон хожмын хэрэгжилтийг дээшлүүлэхэд түүнийг ашигла.

Арга хэрэгслүүдийг сонго, ашигла!

Ямар арга хэрэгслүүд байдаг вэ?

Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд ямар арга хэрэгслүүд ашигладаг вэ? Арга хэрэгсэл цөөдөж, хомсдохгүй нь тодорхой. Бараг л хязгааргүй олон арга хэрэгсэл байдаг бөгөөд тэдгээрийг **хослуулан хэрэглэх хувилбар бүр ч олон байдаг нь** практик ажилтнуудад таатай нөхцөл бүрдүүлдэг. Байдлыг сайтар ойлгох үүднээс тэдгээрийг энгийн хялбараас нь эхэлж авч үзэх хэрэгтэй юм.



Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоо нь төр, иргэдийн хооронд хэлхээ холбоо, харилцаатай байхыг шаарддаг. Энэ нь тэдний хооронд байнгын **мэдээлэл солилцоо** явагдана гэсэн үг. Мэдээлэл нь агуулгатай байх хэрэгтэй. Тэгэхээр тэдгээр мэдээлэл юуг өгүүлж илэрхийлэх вэ? Мэдээллийг хүлээн авагч юу сонсч, юу ойлгодог вэ? Мэдээллүүд нь мэдээллийн төвийн ажиллах цагийн хуваарь гэх мэт энгийн зүйлээс эхлээд бодлогын шинжтэй шинэ төслийн агуулгыг тайлбарлаж таниулах хүртэл нарийн төвөгтэй байж болно. Тэдгээр мэдээллийг хэрхэн солилцох, мэдээлэлд санаагаа хэрхэн илэрхийлэх, илгээх, хүлээн авах аргууд бас чухал байдаг. Тоо тоймгүй олон арга байх бөгөөд тэдгээр нь өөр өөрийн онцлого шинж чанартай байна.

- ▶ **Хэлбэр:** Хүний нэг буюу хэд хэдэн мэдрэхүйд хандсан хэлбэр нь дуут хэлбэрээр /жишээ нь үг хэлэх, харилцан ярилцах, дүрс буюу үзэгдэх хэлбэрээр/ жишээлбэл текст буюу бичвэр, зураг, слайд/ болон тэдгээрийн холимог **дуу, дүрсний** хослол /дүрс бичлэгийн кино, тайлбар бүхий слайд гэх мэт/ байж болно.
- ▶ **Дэмжлэг:** Засгийн газар ямар нэгэн **дэмжлэг үзүүлэлгүй** жишээ нь үзэгч, сонсогчидтой ярихгүй, сонсолгүй харьцаж болно. Ийм тохиолдолд иргэдтэй харилцахдаа биет болон бүтээгдэхүүн, жишээлбэл эх хувь, баримт бичиг, ном, эсвэл тэдгээрийн цахим хувилбаруудыг ашиглаж болно.
- ▶ **Хүргэх арга:** Засгийн газар мэдээлэл хүргэхдээ харилцааны олон аргаас аль нэгийг сонгож болно. Энэ арга нь **биет зүйл** болон товхимол, шуудан зэргээр эсвэл **цахим хэлбэр** болох харилцуур утас, радио, телевиз, Э-шуудан байж болно. Засгийн газар **хувь хүн, байгууллага** /жишээ нь Иргэний нийгмийн байгууллагууд гэх мэт/-тай хамтран ажиллаж, өөрийн харилцаанд тэднийг зуучлагч байдлаар ашиглаж болно.

Засгийн газар иргэдтэй харилцаагаа бэхжүүлэхдээ төрөл бүрийн **арга барилыг** ашиглаж тухайлбал дараах сонголт хийж болно.

- ▶ **Ярих хийгээд илгээх эсвэл сонсох хийгээд хүлээн авах буюу хоёуланг нь:** Засгийн газар ярьж эсвэл мэдээлэл илгээж /олон нийтийн өмнө үг хэлэх гэх мэт, сонсох буюу мэдээлэл хүлээн авах /асуулт тавьж санал бодлыг нь сонсох үед тохиолддог шиг/ буюу харилцан ярианы үеийнх шиг хоёуланг хэрэглэж болно.
- ▶ **Идэвхтэй ба идэвхгүй:** Засгийн газар өөрийн санаачилгаар нээлттэй харилцан яриа, бага хурал зохиох зэргээр иргэдтэй идэвхтэй харьцаж болно. Эсвэл иргэдийн хүсэлтэд жишээлбэл засгийн газрын баримт бичгүүдтэй танилцах хүсэлтийг нь зөвшөөрөх хэлбэрээр/ идэвхгүй хариу үйлдэл хийж болно.
- ▶ **Хяналттай буюу хяналтгүй:** Засгийн газар өөрийн хяналтад байдаг /засгийн газрын хэвлэдэг товхимол, мэдээллийн эмхэтгэл/ болон хяналтад

нь хамаарагддаггүй /Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид мэдээлэл өгч, тэдний хэвлэлд нийтлүүлэх/ сувгуудыг сонгож болно.

- ▶ **Түр буюу байнгын:** Засгийн газар иргэдтэй түр /эрүүл мэндийн асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг гэх мэт/ болон байнгын /жишээ нь байнгын ажиллагаатай дугуй ширээний ярилцлагаар дамжуулан эрүүл мэндийн асуудлаар санал солилцох / үндсэн дээр холбоо тогтоож болно.
- ▶ **Нийтлэг буюу явцуу:** Засгийн газар нийтлэг /телевизийн зар сурталчилгаагаар дамжуулан олон нийтэд хүрэх/ буюу явцуу байдлаар /тусгайлан товлосон цөөн тооны иргэдтэй/ харьцахаар сонгож болно.
- ▶ **Хязгаарлагдмал буюу дорвитой хамтын ажиллагаа:** Засгийн газар иргэдтэй хязгаарлагдмал түвшинд/ санал авах зорилгоор вэб хуудсанд баримт бичгийг байрлуулах/ буюу дорвитой/ олон нийтийн газруудад халз ярилцлага зохиох г.м/ байдлаар хамтран ажиллахыг зорьж болно.

Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх арга хэрэгсэл нь ихэвчлэн хэд хэдэн шинж чанар, хандлагыг **хослуулсан** байдаг. Гарын авлагын дараагийн хэсгүүдэд мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх арга хэрэгслийн **бүтэц, загварыг** дурдах болно. Эдгээр нь төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх шилдэг сайн ажиллагааны өргөн хэрэглэгддэг, шинэлэг арга хэрэгслийн үлгэр загвар юм. Үйл ажиллагааг урамшуулахад дурдсан арга хэрэгслүүдийг сонгож авсан боловч үйл ажиллагааг хөтлөн явуулах жор хараахан биш билээ. Эдгээр арга хэрэгслийг амжилттай хэрэглэх үндэс нь янз бүрийн нөхцөл байдал болон улс орнуудын харилцан адилгүй зорилго, олон нийт, хөрөнгө хүчинд **нийцүүлж хэрэглэхэд** оршино. Үйл ажиллагааг амжилттай явуулах үндэс нь тулгарсан сорилт бэрхшээлүүдийг шийдвэрлэхийн тулд тохирохуйц шинэчилсэн буюу шинэ арга хэрэгслийг сонгон авч **сэтгэн бодох, дүн шинжилгээ хийхийг** шаарддагт оршино. Дараах жишээнүүдийг харж, захидлуудын дагуу бодож үзэхэд тус дөхөм үзүүлж болохоор арга зам, шинж чанар, хандлагууд иймэрхүү байх боломжтой юм.

Үйл ажиллагаанд боломжтой арга хэрэгсэл бий болгохдоо

- ▶ Хэлбэр, дэмжлэг, хүргэх арга замын хувьд **өөр өөр шинж чанартай** арга хэрэгслүүдийг сонгон авч үзэх,
- ▶ Илгээх буюу хүлээн авах, идэвхтэй буюу идэвхгүй, хяналттай буюу хяналтгүй, байнгын буюу байнгын бус, өргөн буюу явцуу, хязгаарлагдмал буюу дорвитой гэх мэт байдлаар хамтран ажиллаж **өөр өөр арга хэрэгслийг** сонгон хэрэглэх засгийн газрын ондоо хандлагууд,
- ▶ Шаардлагатай арга хэрэгслийг тодорхойлох, сонгох, хэрэглэх, зохион бүтээх, өөр хооронд нь **хослуулан дүн шинжилгээ хийх болон бүтээлч байдлаар хэрэглэх.**

Мэдээлэлд ямар арга хэрэгслийг ашиглах вэ ?



Иргэдэд мэдээлэх явцад засгийн газар болон иргэдийн хооронд ганц урсгалтай харилцаа үүсдэг. Өөрөөр хэлбэл, засгийн газар мэдээлэл илгээж, иргэд түүнийг хүлээн авна. Гэхдээ мэдээлэл бол төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх үндэс юм. Чухамхүү мэдээлэл нь зөвлөлдөх, идэвхтэй оролцох цаашдын үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлдэг. Засгийн газар идэвхтэй бус хэлбэрээр мэдээллийг иргэдэд ашиглуулж эсвэл өөрийн санаачилгад тулгуурлан идэвхтэй байдлаар иргэдийг мэдээллээр хангаж болно. Тэрчлэн мэдээллийн бүтээгдэхүүнийг хэрэглэх, мэдээллийг түгээх хяналттай болон чөлөөт сувгуудыг жолоодох буюу ашиглаж болно.

Засгийн газар **идэвхгүй** хэлбэрээр иргэдийн хүсэлтэд үндэслэн жишээ нь мэдээллийн эрх чөлөөний хуулийн дагуу тэднийг албан бичиг баримтуудтай танилцуулж болно. **Мэдээллийн хүртээмжийн тухай** заалтыг хэрэгжүүлэхэд дараах зүйлс чухал. Тухайлбал,

- ▶ **Иргэдэд хүртээмжтэй болгох:** Иргэдийг албан бичиг баримттай танилцуулахын тулд засгийн газар тэдэнд тэдгээр баримт бичгийг үзүүлэх шаардлагатай. Үүний тул ердийн болон цахим шуудангаар тухайн баримт бичгийн хуулбарыг иргэдэд илгээх явдал юм. Өөр нэг арга нь засгийн газрын байгууллагад хувилагч машин зэргийг суурилуулж тусгайд нь төхөөрөмжилсөн байр гаргаж хэрэглүүлэх явдал юм.
- ▶ **Дотоод мэдээлэл:** Засгийн газар иргэдийн эрж хайж буй баримт бичгүүдийг таньж мэддэг, хаана байгааг олдог байх ёстой. Энэ ажлыг байнгын үндсэн дээр баримт бичгийг ангилж, архивлах замаар Финляндын жишээгээр мэдээллийн сан байгуулах хэлбэрээр гүйцэтгэж болно. Чингэхийн тулд нэгдсэн нэг журам боловсруулж нийт засаг захиргаадад мөрддөг байх нь чухал.
- ▶ **Каталог, регистр, индекс:** Иргэд болон албан хаагчдад мэдээллийг хайж олох нь хүндрэлтэй байж болно. Мэдээллийг хялбархан хайж олохын тулд каталог, регистр, индекс гэх зэрэг арга хэрэгслийг хэрэглэж болно. Тэдгээр нь өгөгдөхүүнийг жагсааж бичээд ангилал хийж, олж авахад төвөг багатай байдлаар байрлуулдаг. Үүнийг байгаль орчны гэх мэт бодлогынх нь чиглэлээр зохион байгуулж болно. АНУ-д хор ялгаруулагч бодисын бүртгэлээс иргэд ямар химийн бодисыг хаана хадгалсан тухай мэдээллийг олж мэддэг. Бельгид каталогийн тусламжтайгаар албан баримт, дүрс бичлэг гэх мэт аливаа хэлбэрийн ном хэвлэлийг хялбар олдог /Фландерс/.
- ▶ **Асуулт, хариулт:** Засгийн газрын албан хаагчид иргэдээс хүлээн авсан асуултуудад хариулт өгдөг. Энэ нь иргэдийн хүсэлтэд илүү “хамтач” байдлаар хандах хэлбэр юм. Мөн энэ бүлэгт дурдагдах өөр олон төрлийн арга хэрэгслийг үүнд хамааруулж болно. Иргэдийн оролцоог

гагцхүү мэдээлэл авахыг хүсч байна хэмээн үзээд тэдний тавьсан асуултад хариу өгөх нь ганц урсгалтай харилцаа болно. Засгийн газар хэрэв иргэдийн тавьсан асуултуудын хэлбэрт дүн шинжилгээ хийгээд тэдний хэлж ярьж байгаа зүйлийн агуулгад анхаарал хандуулбал шаардсан хүсэлтүүд нь хариу мэдээллийн эх сурвалж болно.

Засгийн газар санаачилгаараа төрөл бүрийн **мэдээллийн бүтээгдэхүүн, хэвлэлийг** ашиглан бодлого боловсруулах асуудлыг иргэдэд **идэвхтэй** мэдээлж болно.

- ▶ **Албан баримт бичиг:** Засгийн газар мэдээлэл хүссэн иргэдэд мэдээллийн эрх чөлөөний хуулийн хүрээнд хариулт өгөхийн зэрэгцээ өөрийн санаачилгаар албан баримт бичгүүдийг хэвлэн нийтэлж болно. Тодорхой баримт бичгүүдийг тухайн үед ном товхимол болгож эмхэтгэх байдлаар буюу тогтмол сэтгүүлд нийтлэн хэвлэх ажлыг журамласан заалтууд олон орны хуульд байдаг / “Хүрээг тодорхойлох нь” гэсэн бүлгийг үзнэ үү/. Албан баримт бичиг нь хууль, журам, засгийн газрын хуралдаанд хэлэлцэх хэргийн төлөвлөгөө, тэмдэглэл, шийдвэрийг хэрэгжүүлэх эцсийн хугацаа, хэрэгжүүлэх эзнийг нь тодорхой заасан төлөвлөгөө, үнэлгээний тайлан, зөвлөлдөх ажилд оролцох боломжийн тухай зарлал гэх мэт байж болно.
- ▶ **Бодлого, эрх зүйн баримтууд:** Төлөвлөсөн бодлого, хуулийн санал санаачилгуудыг иргэдэд мэдээлэхийн тулд засгийн газар өөрийн бодол төсөөлөл, тухайн асуудлаарх төлөвлөгөөг тодорхой тусгасан төслийн баримт бичиг боловсруулаад нийтэлж болно. Энэ нь ихэвчлэн олон нийтэд бодлогын баримт бичиг, хуулийн төслийг танилцуулсан шинжтэй байдаг. Зарим үед засгийн газар тухайн баримт бичгийн статус, бодлогын хүрээнд эзэлж буй байр суурийг нь тодруулах үүднээс нэр гарчигийг тодотгож өгдөг. Ногоон ном гэвэл боловсруулалтын эхний шатанд байгаа буюу тодорхой асуудлаарх засгийн газрын анхны хандлагыг илэрхийлдэг. Цагаан ном нь боловсруулалтын нэлээд хожуу үед ороод байгаа бодлогын төсөл гэдгийг харуулдаг. Засгийн газар шийдвэр гаргахаас өмнө хуулийн төслийг нийтэлж болно. Ногоон, цагаан ном болон хуулийн төслүүдийг хэвлэн нийтлэх нь зөвлөгөөний нэгэн хэсэг/ зөвлөгөөний арга хэрэгслүүдийн талаарх дараагийн бүлгийг үзнэ үү/ юм.
- ▶ **Тайлан:** Бодлогын хэрэгжилтийн болон үнэлгээний шатанд засгийн газар сэдэвчилсэн тайлан гаргах замаар түүний үр дүнг мэдээлж болно. Эл тайлан бодлогыг бүхэлд нь эсвэл түүнийг аль нэг буюу зарим хэсгийг хамарсан байж болно. Тэрчлэн тухайн жилийн тайлангаар засгийн газрын үйл ажиллагааг бүхэлд танилцуулж болно. Хэрэгжиж буй бодлогоос гадна шинээр хэрэгжих бодлогыг жил тутмын эл тайлангаар танилцуулдаг. Английн Нэгдсэн Вант Улсад засгийн газар жил тутмын тайландаа тодорхой зорилт дэвшүүлж, түүнийг хэмжих үзүүлэлтүүдийг хамтад нь тусгадаг. Иргэд тэдгээрийн үндсэн дээр засгийн газар, өгсөн амлалтаа хэрэгжүүлж байгаа эсхийг нь хянадаг байна.

- ▶ **Гарын авлага, заавар, товхимол, товч танилцуулга, зурагт хуудас:** Албан баримт бичиг, илтгэл тайланг уншиж ойлгоход тэр бүр хялбар байдаггүй. Нөхцөл байдалтай ерөнхийд нь танилцах, хэрэгтэй мэдээллээ олж авахыг хүссэн иргэдийн хувьд тэдгээрийг ашиглахад төвөгтэй, хүч чармайлт шаардсан ажил болдог. Тиймээс засгийн газар иргэдэд хөнгөн хялбар, сонирхол татахуйц болгох үүднээс тэдгээр мэдээллийг дахин боловсруулж, шинээр багцалж болно. Чингэвээс засгийн газар хэлэлцүүлж буй бодлогын асуудлаараа олон нийтийн ойлголтыг дээшлүүлнэ. Үүнийг хэрэгжүүлэх арга нь гарын авлага, заавар, товхимол, товч танилцуулга, зурагт хуудас бөгөөд тайлангийн ерөнхий тойм болон хураангуйг энгийн үг хэллэгтэй график, гар зураг, сонирхолтой зохион байгуулалт хэрэглэн илүү энгийн, ойлгомжтой болгодог. Олон засгийн газар үйл ажиллагаа, бодлого боловсруулах үйл явцыг танилцуулахдаа эдгээр аргыг өргөн хэрэглэдэг. Жишээ нь иргэний эрхийн асуудлаар гарын авлага, зааварчилгааны цуврал товхимол гаргах зэргээр иймэрхүү зүйлийг хэвлэн гаргаж болно / жишээ нь Грект иргэдийн гарын авлага, Европын Холбоонд нэгдсэн мөнгөн тэмдэгтийн тухай танилцуулга гаргасан байдаг.
- ▶ **Дуу бичлэгийн хуурцаг, кино, тоглоом:** Засгийн газар мэдээллийг шинэлэг байдлаар багцалж бэлтгэхийн сацуу бусад аргыг ашиглан өвөрмөц хэлбэрээр танилцуулж болно. Тэрхүү бусад аргад дуу болон дүрс бичлэгийн хуурцаг, слайд орно. Асуулт хариултын тэмцээн, бусад тоглоомоор залуучууд өсвөр үеийнхэн гэх мэт онцлог сонсогч, үзэгчдэд мэдээллийг илүү хөгжөөн наргиантай байдлаар хүргэдэг.

Мэдээллийн бүтээгдэхүүн нь иргэдэд хүрсэн тохиолдолд л мэдээлэх үүргээ биелүүлнэ. Тэгэхээр мэдээллийг иргэдэд хүргэхийн тулд засгийн газар түүнийг түгээх олон сувгыг ашиглаж болно. Юуны өмнө **өөрийн хяналтад байдаг дараах сувгаар мэдээллийг түгээнэ.** Тухайлбал;

- ▶ **Мэдэгдэл, үг хэлэх:** Засгийн газрын албан хаагчид бодлогын асуудлаар үг хэлэх буюу тухайн нөхцөл байдлыг биечлэн ярьж танилцуулдаг. Энэ бол мэдээллийн хамгийн нийтлэг аргын нэг бөгөөд ихэвчлэн бусад аргыг хамтруулж хэрэглэдэг. Үг хэлэхдээ дуу, дүрс бичлэг, слайд, график, дагалдах материал, богино хэмжээний кино үзүүлэх зэргээр баяжуулж болно.
- ▶ **Шууд илгээх арга:** Мэдээллийг айл айлын үүдэнд хүргэх нь иргэдэд мэдээлэх хамгийн өргөн хэрэглэгддэг, харьцангуй өртөг өндөртэй арга. Нидерландын засгийн газар 2000 оны компьютерийн хямрал /2ҮК гэгч/-ыг сэргийлэх талаар авсан арга хэмжээний тухай иргэддээ танилцуулахын тулд нэг хуудас танилцуулгыг өрх бүрд хүргэсэн билээ.
- ▶ **Харилцах утасны үйлчилгээ:** Засгийн газар тодорхой асуулт буюу асуудлаар мэдээлэл авахын тулд шууд харилцах утсаар ярих боломжийг иргэдэд олгодог. Харилцах утасны үйлчилгээ нь Канадын засгийн газрын лавлагааны төвийн адил ихэвчлэн үнэ төлбөргүй байдаг. Лавлагааны

төвийн залгагч мэдээллийг тухайн иргэнд хүргэдэг. Харилцах утасны үйлчилгээг нийтэд нь эсвэл зарим талаар соронзон бичлэгт тулгуурлан иргэдэд хэрэгтэй мэдээллээ харилцуурын зохих товчлуурыг дарж авахаар гүйцэтгэж болно.

- ▶ **Мэдээллийн төв, мэдээллийн самбар:** Мэдээллийн төв бол иргэдэд хүртээмжтэй мэдээллийн суурин орчин бөгөөд засгийн газрын мэдээллүүдээс гадна, эрж хайсан мэдээллээ олж авахад нь иргэдэд туслах ажилтнуудтай байдаг. Грект дүүрэг бүрт мэдээллийн төв байдаг. Тэрчлэн дэлхийн байгаль орчны мэдээллийн Японы төв гэх мэт тодорхой асуудлаар төрөлжсөн мэдээллийн төвүүд байдаг. Засгийн газар мэдээллийн самбар, хөдөлгөөнт болон түр хугацааны мэдээллийн сан эсвэл өөрийн байранд байнгын ажиллагаа бүхий мэдээллийн төв/ орон нутгийн байгууллагын төв байр, номын санд/ ажиллуулах эсвэл бусад байгууллагын зохиосон баяр болон тэмдэглэлт үйл явдлуудыг ашиглаж болно.
- ▶ **Үйл явдал, үзэсгэлэн:** Бага хурал, үзэсгэлэн гэх зэрэг өвөрмөц онцлог үйл явдлыг зохион байгуулах нь иргэдэд мэдээллийг дээр өгүүлсэн дан арга хэрэгслээр буюу хослуулсан олон хэлбэр, хэмжээгээр хүргэх бололцоо олгодог. Жишээ нь Польш өргөн олон нийтэд засгийн газрын шинэчлэлийг тайлбарлан таниулахын тулд халз асуулт, уралдаан тэмцээнүүд зохиодог байна.
- ▶ **Зар сурталчилгаа:** Зар сурталчилгаа хийх, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд зай талбай худалдан авах буюу ашиглах нь засгийн газрын хувьд мэдээллээ иргэдэд хүргэх, түүний хяналтын дор байдаг өөр нэгэн арга юм. Тийнхүү ашиглах зай талбай нь зарлалын самбар, сонин, радио, телевиз, интернэт гэх мэт хэвлэл мэдээллийн аль ч хэрэгсэлд байж болно. Ирландад засгийн газар мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хэрэгжүүлж эхэлсэн тухайгаа утасны лавлахаар дамжуулан иргэдэд мэдээлсэн байна.

Засгийн газар иргэдэд мэдээллийг хүргэхдээ өөрийн хянадаг сувгуудаас гадна дараахи **бие даасан, шууд бус** сувгыг ашиглаж болно.

- ▶ **Хэвлэлийн мэдээ, хэвлэлийн бага хурал, хэвлэлийн ярилцлага зэрэг:** Сэтгүүлчид, олон нийтийн хэвлэл мэдээлэлд хандаж зуучлуулах замаар засгийн газар өөрийн бодлого, санал санаачилгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж болно. Энэ мэдээллийн эцсийн хэлбэрийг засгийн газар хянахгүй боловч иргэдийг мэдээлэх зорилгодоо нийцүүлэн ашигладаг.
- ▶ **Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах нь:** Засгийн газар иргэдэд мэдээлэл хүргэхдээ иргэдийн болон бизнесын нийгэмлэг холбоод, эсвэл үйлдвэрчний эвлэл зэрэг

иргэний нийгмийн байгууллагууд /ИНБ/-тай хамтарч ажилладаг. Энэхүү хамтын ажиллагаа нь ИНБ-ын гишүүдэд мэдээллийг түгээх үүрэг бүхий тухайн байгууллагын төлөөлөгчид мэдээлэх явцуу хэлбэрээс эхлээд тэдэнтэй хамтран иргэдэд мэдээлэх хүртэл олон хэлбэрээр явагддаг. Жишээ нь АНУ-д байгаль орчныг хамгаалах агентлаг нь байгаль орчны талаарх мэдээлэл түгээхдээ ТББ /төрийн бус байгууллага/-уудтай хамтран ажиллаж, тэдэнд санхүүжилт олгодог байна.

Мэдээллийн хэрэгслийн хувьд дараахи зүйлд анхаарна.Үүнд:

- ▶ **Зорилгодоо тохирсон хэрэгслийг сонгож хэрэглэх:** Мэдээллийн хэрэгсэл тохирох, тохирохгүй янз бүр байх бөгөөд дэвшүүлсэн зорилгодоо нийцүүлэн тэдгээрийг сонгох шаардлагатай. Жишээ нь бодлогын асуудлаарх мэдэгдэхүүн бий болгох хийгээд гүнзгий ойлголт төрүүлэхэд харилцан адилгүй хандлага, хэрэгсэл шаардагддаг.
- ▶ **Өвөрмөц олон нийтэд тохирсон хэрэгсэл сонгох нь:** Өөр өөр олон нийт нь хоорондоо харилцан адилгүй байдаг учраас жишээ нь асуудал танилцуулах хийгээд энгийн хүүрнэх ярианд хэрэглэх үг хэллэг, хэлбэр талаас нь ч хэрэгслүүдээ сонгож хэрэглэх шаардлагатай.
- ▶ **Мэдээлэл тань нийтэд хүрч буй эсэхийг хяна:** Хэрэгслийг хэдийгээр зөв сонгож авсан боловч мэдээлэл тань нийтэд хүрэхгүй бол амжилт олохгүй. Тэгэхээр мэдээллийг хэрхэн хүргэх талаар анхаарах нь чухал.
- ▶ **Мэдээллээ сонирхолтой болго:** Олон нийт засгийн газраас ойлгомжтой, хэрэглэхэд хялбар мэдээлэл хүлээн авбал түүнийг ашиглах магадлал нь улам л их болно. Товч бөгөөд тодорхой байдлаар эх бэлтгэх ажлыг олонх тохиолдолд их хөрөнгө заралгүйгээр хийж болно. Хялбарчлах гээд утга санааг алдагдуулж хэрхэвч үл болно.
- ▶ **Чөлөөт сувгын бие даасан байдлыг хүндэтгэ:** Чөлөөт сувгуудын мөн чанар нь тэдгээрийн бие даасан байдалд оршдог. Тэдгээр сувгыг ашиглахдаа засгийн газрын бэлтгэсэн мэдээллийг сонгох, хэрэглэх бие даасан байдлыг нь засгийн газар ойлгож, хүлээн зөвшөөрөх ёстой. Хэвлэл мэдээлэл болон иргэд аль болох бүрэн гүйцэд мэдээлэл авах нь засгийн газрын сонирхол байх болно.

Зөвлөгөөнд ямар арга хэрэгсэл хэрэглэх вэ ?



Зөвлөгөөн бол засгийн газар, иргэдийн хоорондох хос урсгалтай харилцаа юм. Засгийн газар иргэдийн оролцоог идэвхгүй байдлаар хүлээн авахаас гадна тэднийг хамтран ажиллахад урих замаар идэвхтэй авч бас болно.

Иргэдийн хариу мэдээлэл нь засгийн газарт үнэтэй мэдээллийг агуулж болно. Жишээ нь мэдээлэл авах хүсэлт нь мэдээллийн үйл ажиллагааг

өөрчлөх шаардлага, шинээр зохион байгуулах хэрэгцээг харуулж болно. Иргэдийн тавьсан санал нь бодлого боловсруулагчдад хэрэгтэй санааг төрүүлж болно. Гомдол ч гэсэн нийгмийн бодлогод өөрчлөлт оруулах шаардлагатай болсныг илтгэж болно.

Ийм төрлийн хариу мэдээллийг авахдаа дараах арга хэрэгслүүдийг хэрэглэнэ. Үүнд:

- ▶ **Захидлын хайрцаг** нь санал гомдлыг хүлээн авах цэг болохын хувьд засгийн газрын хүрээнд өгөгдөхүүнийг цуглуулах, дамжуулах, түүний мөрөөр ажил зохиох боломж олгодог бөгөөд тэдгээрийг хүлээн авсанаа нотолж, хариу өгдөг байх хэрэгтэй.
- ▶ **Мэдээлэлтэй ажиллах программ хангамж** нь иргэдийн хариу мэдээллийг нэгтгэн цуглуулах, түүнд тооны болон агуулгын талаас нь дүн шинжилгээ хийх боломж олгодог.
- ▶ **Дүн шинжилгээний тайлан** нь иргэдээс хариу мэдээлэл авах бололцоог засгийн газарт олгоно. Тайланг хэвлэж болох бөгөөд чингэвэл засгийн газар ил тод, нээлттэй байдлыг бэхжүүлэхэд хэр тууштай байгааг харуулж өгдөг.

Засгийн газар тодорхой асуудлаар иргэдийг мэдээллээр хангаж, санаа бодлыг нь сонсох үед тэднээс **хариу мэдээллийг** авч болдог. **Ийм байдлаар иргэдийн хариу мэдээллийг хүлээн авахдаа дараах арга хэрэгслийг хэрэглэдэг.** Үүнд:

- ▶ **Асуух, сонсох, илтгэх:** Асуултгүй хариу мэдээлэл байдаггүй. Иргэдэд асуулт тавьж, тэднийг сонсч, өгсөн хариултыг нь нээлттэй хүлээн авах явдал нэн чухал. Зарчмын хувьд үзвэл асуух хийгээд сонсох нь иргэдтэй тогтоох харилцааны нэг хэсэг байдаг. Засгийн газрын хувьд иргэдээс хүлээн авсан оролцоог ашиглахын тулд авдаг бөгөөд тэдгээр асуудлыг эрхэлсэн хүнд ч бас нэгэн адил чухал байдаг.
- ▶ **Санал хэлэх хугацаа ба үйлдэл:** Энэ арга хэрэгслийг хэрэглэснээр засгийн газар бодлогын төсөл болон төлөвлөсөн арга хэмжээнээс байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл гэх мэт тодорхой асуудлаар иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах хугацааг гаргана. Тэрчлэн шуудангаар тодорхой хаяг /захидлын хайрцаг/ руу илгээх, төлбөргүй утсаар шууд ярих гэх мэтээр саналаа хэрхэн өгөх журмыг сонгож, уг үйл ажиллагаа, асуудал, эцсийн хугацааг болон санал гомдлоо илэрхийлэх арга замыг иргэдэд хэрхэн мэдээлэхийг шийднэ. Британийн засгийн газар боловсролын шинэчлэл, мэдээллийн эрх чөлөөний хуулийн төсөл зэрэг асуудлаар санал гомдол хүлээн авах хугацаа гаргаж, тэр тухайгаа иргэддээ зарласан мэдээллийн товхимлыг зах гэх мэт олон нийтийн газруудаар түгээж, хэвлэлд нийтэлсэн байна.
- ▶ **Тусгайлан сонгосон бүлэг:** Энэ аргаар иргэдийн тодорхой хэсэг бүлгийг аль нэг газарт нэг хоног буюу түүнээс бага хугацаагаар цуглуулж болно.

Цугларсан хүмүүсийг хүн амын эсвэл олон нийтийг төлөөлөхүйц бүрэлдэхүүнтэй сонгосон байвал зохино. Тусгайлан сонгосон бүлгийг мэдээллээр хангаж нэг бүрчлэн ярилцах буюу нэгдсэн хуралдаан хийх замаар санаа бодлыг нь сонсч болно. Засгийн газар энэ аргыг хэрэглэвэл гүн гүнзгий хариу мэдээлэл авах боломжтой.

- ▶ **Судалгаа:** Судалгаа явуулах замаар засгийн газар иргэдэд олон тооны асуулт тавьж хариултыг цуглуулж аваад дүн шинжилгээ хийдэг. Судалгааны дүнг хүчинтэй байлгахын тулд хүн амын төлөөллийг тусгах байдлаар хүмүүсийг сонгож түүнд хамруулдаг. Зохих ёсоор зохиомжлон байршуулсан асуулгын хуудсаар асуулт тавьдаг. Зарим асуултанд иргэд урьдаас төлөвлөсөн хэд хэдэн төрлийн хариулт дотроос зохих хувилбарыг сонгож тавьдаг. Нээлттэй асуултын хувьд иргэд өөрийнхөөр үзэмжээр чөлөөтэй хариулдаг. Судалгааны хуудсыг иргэд өөрсдөө эсвэл тэдэнтэй ярилцаж буй судлаач бөглөж болно. Канадын засгийн газар иргэдэд үзүүлж буй үйлчилгээнийхээ талаар хоёр жил тутам судалгаа явуулж 3 мянга орчим хариултыг шуудангаар авдаг бөгөөд тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхдээ тэдгээрийг ашигладаг.
- ▶ **Олон нийтийн санал асуулга:** Тодорхой асуудлаарх олон нийтийн санаа бодлыг тухайн цаг мөчид тодруулдаг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арга бол олон нийтийн дунд явуулах санал асуулга юм. Статистикийн хувьд хүчин төгөлдөр үр дүнд хүргэхийн тулд олон нийтийн санал асуулгыг зохих аргачлалыг баримталж явуулдаг. Үүнд түүвэр судалгаа хийх, ярилцлага хийгчдийг сургах, урьдчилан туршсан асуулгын хуудсыг бэлтгэх зэрэг ажиллагаа орно. Жишээ нь Дани улсад улсын хэвшилд иргэд хэр итгэж байгааг тодруулах судалгаа явуулсан бөгөөд тус улсын засгийн газар бодлогын тэргүүлэх салбарын талаар дүгнэлт хийж, засгийн газарт итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авсан байна.

Иргэдийн хариу мэдээллийг авахаас ялгарах онцлого нь зөвлөлдөх явцад засгийн газар иргэдтэй улам илүү хамтран ажилладаг. Цаг үеийн шинжтэй асуудлаар зөвлөлдөх нь ихэвчлэн тодорхой асуудал, зорилгыг хамарсан байх бөгөөд богино хугацааг хамардаг. Ийм байдлаар зөвлөлдөхөд засгийн газар дараах арга хэрэгслийг ашигладаг. Үүнд:

- ▶ **Хувь иргэдийг зөвлөлдөх зөвлөлд оруулах:** Засгийн газар иргэний нийгмийн байгууллагын мэргэжилтэн эсвэл төлөөлөгч гэх мэт хувь иргэдийг засгийн газрын бодлого, хөтөлбөрт үнэлгээ өгөх Зөвлөлийн бүрэлдэхүүнд урьж оролцуулах нь Финляндад олонтаа тохиолддог. Чингэснээр засгийн газар, иргэдийн хооронд ойр дотно хамтын ажиллагаа үүсдэг. Тэрчлэн тэрхүү хамтын ажиллагаа нь сонгож авсан нэг юмуу цөөн хэдэн хүний хүрээнд явагддаг бөгөөд тэдгээр хүмүүс өргөн хэмжээнд тухайлбал, өөрсдийн байгууллага болон хэсэг бүлгүүдийг мэдээллээр хангах, оролцуулах талаар хэрхэн ажиллаж байгаагаас шалтгаалдаг.
- ▶ **Сургалт, семинар, бага хурал:** Эдгээр арга хэмжээ нь засгийн газрыг иргэдийн зарим хэсэг, ашиг сонирхолын тодорхой бүлгүүдтэй шууд

яриа хэлэлцээнд оруулдаг. Сургалт, семинар, бага хурлын явцад оролцогчдод мэдээлэл хийж, тэднээс хариулт авах замаар нээлттэй харилцан ярилцлага өрнүүлдэг. Ирландын засгийн газар хөдөөгийн хөгжлийн асуудлаарх цагаан номоо танилцуулахын тулд орон даяар ийм цуврал арга хэмжээ зохиосон байна. Солонгосын засгийн газар төрийн байгууллагын шинэчлэлийн талаар хэд хэдэн сургалт, зөвлөгөөн зохион байгуулсан бөгөөд иргэний нийгмийн байгууллагуудаас тодорхой асуудлаар зохион явуулсан семинар, бага хуралд засгийн газрын албан хаагчид оролцож тэдний хариу мэдээллийг хэрхэн ашигласан тухай мэдээлэл хийсэн байна.

- ▶ **Олон нийтийн хэлэлцүүлэг:** Шийдвэр гаргах зарим төрлийн үйл ажиллагаа /байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх юмуу эсвэл нэгэнт тогтсон бодлого боловсруулах практикт/-нд олон нийтийн хэлэлцүүлэг явуулах шаардлага гардаг. Хэлэлцүүлэг нь тусгайлан уригдсан мэргэжилтнүүдэд болон ажиллагсадд төдийгүй оролцохыг хүссэн нийт иргэдэд нээлттэй байдаг. Засгийн газрын албан хаагчийн тэргүүлсэн комисс уг үйл ажиллагааг удирдаж явуулдаг. Комиссын гишүүд нь засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, парламентаас томилогдож болно. Жишээ нь Европын Холбооны Байгаль орчны тодорхой бодлогын асуудлаарх зөвлөгөөнд Европын Комиссар гэх мэт өндөр түвшний бодлого боловсруулагчид оролцдог. Хэлэлцүүлгийн дүнд асуудлыг өргөн хүрээтэй авч үзэх бөгөөд бодлогын тодорхой хувилбар дээр тогтож ярилцдаг.
- ▶ **Заавал дагаж мөрдөх албагүй санал асуулга:** Хэд хэдэн хариулттай хувилбар бүхий тодорхой асуудлаар нийт хүн амыг хамруулан зөвлөлдөхөд энэхүү заавал дагаж мөрдөх албагүй санал асуулгыг хэрэглэдэг. Заавал дагаж мөрдөх санал асуулга нь шийдвэр гаргах эрхийг иргэдэд шууд өгдөг. Эдгээрийн тухай энэхүү гарын авлагад дэлгэрэнгүй өгүүлэхгүй болно./ “Хүрээг тодорхойлох нь” бүлгийг үзнэ үү/

Засгийн газар иргэдтэй **байнга, тууштай зөвлөлдөхийг** хүсвэл зөвлөгөөний дараах арга хэрэгслийг ашиглаж болно. Үүнд:


- ▶ **Нээлттэй цаг:** Энэ арга нь шийдвэр гаргагчидтай байнга уулзаж ярилцах боломжийг иргэдэд олгодог. Исландад засгийн газрын гишүүн, сайд нар иргэдийг хүлээн авахдаа долоо хоног тутам тодорхой газарт, зохих хугацааг гаргадаг. Нээлттэй цаг нь шууд зөвлөлдөх боломжийг цөөн боловч хүнд олгодог.
- ▶ **Иргэдийн зөвлөл:** Хүн амын төлөөллийг тусгах үндсэн дээр сонгогдсон иргэдээс бүрддэг зөвлөлүүдтэй засгийн газар бодлогын асуудлуудаарх санал санаачилгуудтай холбогдсон санаа бодлыг нь сонсохын тулд шуудангаар болон харилцуур утсаар судалгаа хийж, ярилцлага, семинар зохиох зэргээр байнга зөвлөлддөг. Английн Нэгдсэн Вант Улсад ардуудын зөвлөл нь нас, хүйс, нутаг дэвсгэрийн бүс бүрийг төлөөлөхүйц 5 мянган хүнээс бүрддэг.

- ▶ **Зөвлөх хороод:** Нийтийн эрх ашгийг төлөөлөхөөр засгийн газрын байгууллагуудаас томилогдсон эдгээр хороо нь аль болох өргөн төлөөлөл бий болгох, зөвлөгөөний механизм бүрдүүлэхэд чиглэдэг. Жишээ нь Польшид Үндэсний зөвлөлдөх зөвлөл нь тахир татуу иргэдийн талаарх бодлого хийгээд холбогдох асуудлаар засгийн газарт зөвлөдөг. Дани Улс Европын Холбооны бодлогын тодорхой чиглэлүүдээр ашиг сонирхолын бүлгүүдийн төлөөлөл бүхий 31 хороо байгуулсан байна.

Бодлого боловсруулах явцад иргэдээс хариу мэдээлэл авч, тэдэнтэй зөвлөлдөх арга хэрэгслийг сонгохдоо дараах зүйлд анхаарвал зохино.

- ▶ **Зөвлөгөөнийг зарлах:** Зөвлөгөөнд санаа бодлоо илэрхийлэхийн тулд иргэд түүний тухай урьдчилан мэдэх шаардлагатай. Тийм учраас засгийн газар хэдийд, хаана, юуны талаар зөвлөлдөхийг өмнө нь зарлах ёстой.
- ▶ **Сонгох арга ажиллагаанд анхаарах:** Зөвлөгөөнд чухам хэнийг сонгож оролцуулах нь тэднээс авах хариултын чанарт төдийгүй, уг арга хэмжээг үр дүнтэй зохион явуулахад чухал. Зөвлөгөөнд оролцогчдыг хүн амын төлөөлөл байхгүйгээр засгийн газарт эсвэл түүний албан хаагчдад ойр дотно ханддаг, эсвэл байдаг гэх зэргээр сонговол зөвлөгөөний үр дүн алдаа мадагтай болохоос гадна эл ажиллагаа нь засгийн газарт итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх бус харин сулруулахад хүргэх болно. Тодорхой дүрэм зохиож, түүнийгээ нийтэлж сонголтыг ил тод явуулах нь асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлнэ.
- ▶ **Оролцоог ашиглах:** Иргэдийн оролцоог засгийн газар ашиглахгүй, анхнаасаа үүнд зорьж ажиллаагүй тохиолдолд уг ажиллагаа нь төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд ямар нэг ач холбогдолгүй болно.
- ▶ **Саатлыг харгалзан үзэх:** Зөвлөлдөх үйл явц цаг хугацаа шаардахаас гадна эсэргүүцэлтэй тулгарч шийдвэр гаргах ажиллагааг саатуулж болзошгүй. Иймд тодорхой зорилго, зөвлөгөөний баримтлах ёстой хил хязгаар, оновтой төлөвлөгөө зэрэг нь саад бэрхшээлийг гэтлэн давахад тус дөхөм үзүүлнэ.

Идэвхтэй оролцоонд ямар арга хэрэгсэл ашиглах вэ ?



Бодлого боловсруулах явцад иргэдийг идэвхтэй оролцуулахаар ажиллах нь төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх хамгийн дэвшилтэт хэлбэр юм. Энэ нь тухайн засгийн газар уг харилцаанд иргэн хүний үүрэг, бие даасан байр суурийг хүндэтгэн үзэж дэмжиж байгаагийн илрэл

болдог. Иргэд, засгийн газартай хийх яриа хэлэлцээнд хэлэлцэх хэргийн бодлого, хэлэлцээний дүр төрхийг тодорхойлоход өөрсдөө оролцоно. Тэд бодлогын хувилбар боловсруулж санал болгож мөн болно. Түншийнхээ оролцоог хөхүүлэн дэмжихийн хэрээр засгийн газар харилцааны энэ суваг болон түүний агуулгыг дангаар хянадаг байдлаа орхино. Иргэдийн идэвхтэй оролцоо гэдэг нь шийдвэр гаргах шатанд иргэд нэлээд хэмжээгээр нөлөө үзүүлэх боловч шийдвэр гаргах эцсийн эрх засгийн газарт байна гэсэн үг. Түншлэл, идэвхтэй оролцоо ч гэсэн мэдээлэл, зөвлөгөөн ч гэсэн бодлогын асуудлаар шийдвэр гаргах засгийн газрын эрхийг хязгаарлахгүй гэдэг утгаар энэ бол чухал зүйл юм. Засгийн газар гаргаж буй шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээхээс гадна ардчиллын нөхцөлд дээд эрхийг баригч ард түмэн болон сонгуулийн байгууллага болох парламентын өмнө ажлаа тайлагнана.

Нидерландад хамтран бодлого боловсруулах гэж нэрлэгддэг орон нутгийн үүсгэл санаачилгаас гадна үндэсний хэмжээнд иргэдийн идэвхтэй оролцоог бий болгох арга хэрэгслийг засгийн газар бий болгон туршиж байна. Эдгээр арга хэрэгслийн зарим нь **тодорхой чиглэлээр бодлогын хэлэлцэх асуудлыг тодорхойлж байдаг**. Үүнд тодорхой асуудлууд хийгээд тухайн асуудлын онцлог талуудыг дэвшүүлэн тавьж, олон түмэнд уламжлагаас гадна **зөвлөмж** гаргадаг. Эдгээр арга хэрэгсэл нь уг асуудлаар мэргэшээгүй цөөн тооны бүлэг иргэдийг хамардаг.

Олон нийтийн анхаарал татсан асуудлыг тодорхойлоход иргэдийг оролцуулах арга хэрэгсэлүүд:

- ▶ **Зөвшлийн бага хурал:** 10-15 иргэн цугларч тодорхой асуудлаар мэргэшсэн мэргэжилтэнд асуулт тавьдаг. Асуултын дараа тэд асуудлыг өөр хоорондоо хэлэлцээд эцэст нь зөвшөлцлийн дүнд санал нэгдсэн хамтын дүгнэлтээ нийтэд танилцуулдаг. Оролцогчдыг түүвэр байдлаар сонгодог. Тэд тухайн асуудлаар бүгд л жирийн иргэд /мэргэжилтэнүүд биш/ юм. Ийм арга хэрэгслийг генетикийн шинэ аргаар бий болгосон хүнсний бүтээгдэхүүн гэх мэт шинэ технологийн олон асуудлаар зөвшлийн бага хурлыг Дани, Норвегид өргөн хийдэг.
- ▶ **Иргэний шүүх:** Сүүлд гарсан арга бол зөвшлийн бага хуралтай ерөнхийдөө төстэй боловч үндсэн хоёр онцлоготой. Асуулга шүүхийн танхимд өргөн олны өмнө нээлттэй явагдана. Асуулт, хариултын цаг богино, шийдвэр нь нийтийн зөвшлийг илэрхийлэх албагүй. Засгийн газар өмнө нь шүүх бүрэлдэхүүнийг сонгох арга ажиллагаа зэрэг санаачилгыг зар сурталчилгаагаар дамжуулан нийтэд зарлан мэдээлнэ. Энэ ажиллагаа мэргэжлийн бус хүмүүст ч нээлттэй. Францад иргэний шүүх нь эрүүл мэндийн салбарын ерөнхий дүр төрхийг ярилцахад оролцдог.

Хязгаарлагдмал тооны, **мэргэшсэн олон нийтийг** түлхүү оролцуулдаг өөр нэгэн бүлэг хэрэгсэл бий. Тэдгээр нь ихэвчлэн иргэний нийгмийн байгууллагууд зэрэг ашиг сонирхолын бүлгийн төлөөлөгчдийг ихэвчлэн хамардаг бөгөөд **тодорхой бодлогын санаачилга гаргах буюу бодлого боловсруулах,**

хэрэгжүүлэхэд хамтран ажиллахад хүргэдэг. Хязгаарлагдмал шинжтэй учраас иргэдийн хамрах тал нь мөн тун хязгаарлагдмал байдаг. Мэргэшсэн олон нийтийг хамрах хэрэгсэлүүд нь:

- ▶ **Сонирхогч талуудын үнэлгээ:** Засгийн газрын бодлогод үнэлгээ өгөх ажлыг мэргэжилтэнүүд, сонирхолын бүлгийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлдэг. Засгийн газар шаардлагатай тоо баримтыг гаргаж өгөх, үнэлгээний үр дүнг хэвлэн нийтлэх үүрэг хүлээнэ. Үр дүн нь тухайн үеийн бодлогын дүн шинжилгээ хийгээд бодлогод оруулах өөрчлөлтийн талаарх зөвлөмжийг тусгадаг. Италийн засгийн газар иргэдтэй тогтоосон харилцаагаа бэхжүүлэхийн тулд өөрийн үйл ажиллагаанд хэрэглэгчдийн нийгэмлэгээр үнэлгээ гаргуулдаг байна.
- ▶ **Уламжлалт гурван талын комисс болон хамтарсан ажлын хэсэг:** Эдгээр арга хэрэгсэл нь байгууллагуудын цөөн тооны мэргэжилтэнүүдийг засгийн газрын төлөөлөгчтэй хамтарсан ажлын хэсэгт оруулдаг. Уг хэсэг бодлого боловсруулах асуудлаар тодорхой санал санаачилга гаргадаг. Хамтарсан ажлын хэсэг өөрийн эрхээр ажилладаг бөгөөд үр дүнг эцэслэн гаргах хүртэл тодорхой хэмжээнд нууцыг хадгалдаг. Энэ байдлаас үүдэн олон нийтийг өргөнөөр оролцуулах боломжийг хязгаарладаг нь дурдсан арга хэрэгслийн үр өгөөжийг бууруулдаг. Дүгнэлт нь тухайн бодлогын асуудлаар эсвэл түүний бусад хувилбарын талаар санал нэгдсэн байдлаар гаргадаг учир төр, хувийн хэвшлийн хамтарсан оролцооны байдлаар хэрэгждэг. Энэ чиглэлийн уламжлалт арга хэрэгсэл бол Австри, Германд байдаг засгийн газар, ажил олгогчид, хөдөлмөрчдийн гурван талын комисс юм.

Олон мэргэжилтнийг оролцуулахыг хичээснээр засгийн газар **өргөн олон нийтийг хамрахад** чиглэсэн олон төрлийн арга хэрэгслийг ашиглах боломжтой болно. Тэдгээр нь зөвлөмж, бодлогын болон бодлого **боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах санал гаргадаг**. Олон нийтийг өргөн оролцуулдаг арга хэрэгслүүд:

- ▶ **Нээлттэй ажлын хэсэг:** Гурван талын комисс, хамтарсан ажлын хэсэгтэй адил бүтэцтэй, үр дүн нь ижил. Ялгарах онцлого нь нээлттэй ажлын хэсэг олон түмэнд ил тод байдлаар ажилладаг бөгөөд хүн амыг аль болох өргөн хамарч оролцуулах боломжийг эрэлхийлдэг. Бельгийн засгийн газар ядуурал, нийгмийн ялгарлын эсрэг тэмцэх зорилгоор ядуучуудад тусалдаг болон тэднийг нэгтгэдэг байгууллагуудын төлөөллийг оруулсан хамтарсан ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн хуралдаан нь ядуучууд, тэдний гэр бүлийг хамарсан үйлчилгээ орон нутгийн түвшинд ямар байдалтай байгааг үзүүлсэн байна.
- ▶ **Иргэдийн оролцоог бүрдүүлж, хэтийн дүр зургийг тодорхойлох:** Тодорхой нөхцөл байдалд засгийн газрын албан хаагчид, мэргэжилтнүүд болон иргэдийн бүлэг ирээдүйн хөгжлийн талаар нийтлэг

нэг эсвэл өөр хоорондоо ялгаатай дүр зургийг тодорхойлох явдал гардаг. Ирээдүйд ямар байхыг тодорхой асуудал, салбарын бодлогоор эсвэл хот, улс зэрэг нутаг дэвсгэрийн нэгжээр дүрслэн харуулж болно. Үүнийг нийтэд харуулах дүрс, нөхцөл байдал зэргийг өгүүлэх, дүрс бичлэг, үзэсгэлэн гэх мэт мэдээллийн хэрэгслээр хүргэнэ. Иргэдийн зөвлөгөөн, оролцооны хэрэгслийн хамт дүрс зураг, нөхцөл байдлын дүр төрхийг бий болгож өгөх нь иргэдийг бодлогын олон хувилбарын талаарх идэвхтэй хэлэлцүүлэгт татан оруулж тэр хэрээр бодлого боловсруулагчдад хариу мэдээлэл бүрдүүлэх ач холбогдолтой. Орон нутгийн бодлого боловсруулах үйл явцад иргэдийг өргөн оролцуулах зорилгоор Нидерландын зарим хотод эл аргыг хэрэглэсэн байна.

► **Иргэдийн хэлэлцүүлэг:** Иргэдийн хэлэлцүүлэгт тодорхой салбарын бодлого буюу тодорхой асуудлаар нийгмийн өргөн давхаргыг төлөөлөх олон нийтийг татан оролцуулдаг. Энэ нь асуудлыг танилцуулах, хамтран ажиллах, бодлогын санал санаачилга дэвшүүлэх, олон тооны иргэдийг оролцуулах хүрээ болж өгдөг. Иргэдийн хэлэлцүүлгийн үр дүн нь засгийн газрын бодлогод шууд тусдаг бөгөөд улам олон тооны иргэдэд хүрдэг. Иргэдийн хэлэлцүүлгийг иргэний нийгмийн байгууллагуудаас эрхлэн явуулахуйц байнгын ажиллагаатай болгож болно. Норвегид ардчиллын төлөөх залуучуудын чуулга нь ихэвчлэн залуучуудын байгууллагуудыг төлөөлсөн 15-26 насны залуучуудыг хамарсан, тэднийг улс төрд ороход учирч буй саад бэрхшээлийг авч хэлэлцэн шинэ бодлого явуулах, тодорхой арга хэмжээ авахыг санал болгодог. Гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн сайд нь эдгээр саналыг шууд хүлээн авдаг байна.

► **Харилцан ярилцлага:** Харилцан ярилцлага нь иргэдийн өргөн давхаргыг бодлого боловсруулах ажиллагаанд шууд оролцуулдаг. Ингэж харилцан ярилцахад хэд хэдэн төрлийн арга хэрэгсэл ашигладаг. Жишээ нь Эрүүл мэндийн асуудлаарх Канадын үндэсний чуулганы хүрээн дэх харилцан ярилцлага буюу Канадын орон нутгийн харилцан ярилцлагын нэгэн адил улс орон даяар иргэдийн идэвхтэй оролцоо бүхий, нээлттэй семинар зохион явуулж харилцан ярилцлага хийж иргэдийг оролцуулж болох юм. Бодлогын санал боловсруулах асуудлаар мэргэжилтэнүүд, сонирхолын бүлгүүд, засгийн газрын төлөөлөгчдийг оролцуулсан бага хуралд энэ аргыг ашигладаг. Бодлогын саналыг эцэслэхийн өмнө иргэдээр хэлэлцүүлж нягталж болно. Харилцан ярилцлагад хэрэглэдэг бүтцийг байнгын идэвхтэй оролцоог бий болгоход ашиглах боломжтой.

Идэвхтэй оролцооны арга хэрэгслүүдийг хэрэглэхдээ дараах зүйлд анхаарах шаардлагатай:

► **Боломжийн цаг хугацаа, хөрөнгө мөнгө олгох:** Иргэдийг идэвхтэй оролцоонд татаж оролцуулах нь тэднийг мэдээллээр ханган, зөвлөлдөхөөс илүү цаг хугацаа, хөрөнгө хүч шаарддаг. Нэлээд

мэдээлэлтэй хүмүүсийн түвшний харилцан ярианд иргэдийг оролцуулахын тулд тэдний ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх шаардлага гарна. Тэд мөн төлөвлөх, үнэлгээ өгөх гэх мэт бодлогын орчлын хэд хэдэн үе шатанд ихэвчлэн оролцдог. Ингэснээр засгийн газар иргэдийн идэвхтэй оролцоонд зориулах цаг хугацаа, хөрөнгө мөнгөө нэмэгдүүлэхэд хүрдэг.

- ▶ **Тэнцвэртэй, шударга байх:** Шийдвэр гаргагчдад хүчтэй нөлөө үзүүлэх боломжтой учраас иргэдийн оролцоонд тэнцвэртэй, шударга ажиллагаа чухал ач холбогдолтой хэрэгсэл юм. Түүнд харш үр дагавар бүхий зохиомол өөрчлөлт оруулах сонирхол их гарах болно. Шийдвэр гаргах шатанд тэдгээр арга хэрэгслийг хэрэглэхийн үр дагаварыг урьдчилан авч үзэхийг засгийн газар хүсч болох юм.
- ▶ **Ашиг сонирхолуудтай харьцах:** Иргэдийн олон бүлэг, хэсэг оролцох тохиолдолд шийдлийн төрөл бүрийн хувилбар гарах магадлалтай. Энэхүү гарын авлагын 3 дугаар бүлгийг үзнэ үү (Амжилтад хүрэх арван зөвлөгөө).
- ▶ **Хууль тогтоогчийн эрх, үүргийг хүндэтгэх:** Иргэдийн ашиг сонирхолыг төлөөлөн илэрхийлэх гол газар нь парламент. Өөрийн нь эрх үүрэгт халдах аливаа ажиллагаанд парламент эмзэг хандаж болзошгүй. Тиймээс засгийн газар хууль тогтоогчдын эрх, үүргийг хязгаарлах байдлаар иргэдийн идэвхтэй оролцооны хэрэгсэлийг ашиглаж үл болно. Зарим салбарт хууль тогтоогчийг идэвхтэй оролцуулах, эдгээр ажлынхаа дүнг парламентад тайлагнах нь зөв байж болох юм.
- ▶ **Идэвхтэй оролцоонд хэрэглэгдэж буй зөвлөлдөх арга хэрэгслүүдийн мөн чанарыг эрэгцүүлэх:** Сохих ёсоор зарлан мэдэгдэх, төлөөллийг сонгох, оролцоог дүүрэн ашиглах, шийдвэр гаргах явцыг удаашруулах талыг тооцох зэрэгт иргэдийн идэвхтэй оролцооны зарим арга хэрэгсэл багтдаг. Засгийн газар идэвхтэй оролцоог төлөвлөх, хэрэгжүүлэх явцдаа энэ талыг харгалзахыг хүсч болох юм.

Үнэлгээнд ямар арга хэрэгсэл ашиглах вэ ?



Засгийн газар төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцооны үйл ажиллагаа ямар амжилтанд хүрч байгааг тодорхойлох зорилгоор үнэлгээ хийдэг. Эдгээр үйл ажиллагаа нь дэвшүүлсэн зорилттой харьцуулахад хэр эрчимтэй, үр дүнтэй, хангалттай болохыг хянадаг. Дурдсан арга хэрэгслийг хэрэглэснээр засгийн газар үнэлгээнд /жишээ нь нийтийн санал асуулга зэрэг/ ямар өгөгдөхүүн хэрэглэсэн, амжилтыг ямар шалгуураар илэрхийлэх /иргэдийн оролцоо, бага хуралд сэтгэл хэр ханамжтай байсан гэх мэт/-ийг тодруулж авдаг. **Үнэлгээний арга хэрэгслүүд:**

- ▶ **Албан бус үзэл бодол:** Иргэний нийгмийн байгууллагууд болон

иргэдтэй албан бус байдлаар харьцах замаар засгийн газар, түүний албан хаагчдын талаарх тэдний санал бодлыг сонсох, явуулсан үйл ажиллагааг олон нийт хэрхэн хүлээж авсаныг мэдэх боломжтой. Туршлагатай менежерууд засгийн газрын ажилтнуудтай илэн далангүй ярилцах замаар үйл ажиллагааг нь дотооддоо хэрхэн үнэлж байгааг мэдэх боломжтой. Тэдний санаа бодлыг сургалт семинарийн хэлбэрээр баталгаажуулан өргөжүүлж болно. Эс тэгвээс тэдний албан бус сэтгэгдэл нь мэдээллийг системтэй тараадаггүй энгийн хэрэгсэл хэвээр үлдэх боловч ажлын амжилтыг зарим талаар илэрхийлэх үзүүлэлт болно.

- ▶ **Тоон өгөгдөхүүнийг цуглуулж дүн шинжилгээ хийх:** Баримт материал, мэдээллийн бүтээгдэхүүн шаардсан хүсэлтийн тоо, санал гомдолд хэчнээн асуудал дурдагдсан, хүлээн авсан саналын тоо, арга хэмжээнд хэдэн хүн хамрагдсан гэх зэргээр засгийн газар олон чиглэлээр тоон өгөгдөхүүнийг өргөн хүрээтэй цуглуулж болно. Тэдгээр тоон өгөгдөхүүнийг яамд, тусгай газрууд дундын байдлаар цуглуулж, харьцуулалт хийхийн тулд засгийн газар арга ажиллагааны болон хэмжүүрийн жишиг тогтоох шаардлагатай. Мэдээллийн эрх чөлөөний хуулийн хүрээнд Норвеги улсын нийт яамд болон Ерөнхий сайдын алба /ЗГХЭГ/-нд хадгалагдаж үлдсэн баримт бичиг авахыг хүссэн өргөдөл, татгалзсан хариу, татгалзах болсон шалтгаан зэргийн талаар тоон өгөгдөхүүн цуглуулдаг.
- ▶ **Оролцогсдын тандалт, нийтийн санал асуулга:** Арга хэмжээнд оролцогчид болон засгийн газрын хэвлэлийг уншигчдын тоо нь тэдгээрийг ашиглагчдын тоо, засгийн газартай тогтоосон харилцааны талаарх санаа бодлыг илэрхийлсэн мэдээлэл өгөх боломжтой. Засгийн газрын явуулсан үйл ажиллагааны үр дүнгийн талаарх санал сэтгэгдлийг судлахад хүн амын өргөн хүрээнд нийтийн санал асуулга явуулах нь тустай байжээ. Итали улс мэдээллийн үйл ажиллагааныхаа үр нөлөөг тогтооход тандах аргыг хэрэглэдэг. Швейцарийн засгийн газар бүх нийтийн санал хураалт явуулсан тохиолдол бүртээ иргэдийн санал өгөлтийн шалтгаан, тэд мэдээллийн ямар эх сурвалжийг ашигладаг болохыг илүү нарийн мэдэхийн тулд нийтийн санал асуулга явуулдаг.
- ▶ **Тоймлон танилцах нь** үйл ажиллагаанд системтэй, эрчимтэй үнэлгээ өгөх арга юм. Өргөн хүрээнд төрөл бүрийн өгөгдөхүүн цуглуулж, гүн гүнзгий дүн шинжилгээ хийх явдал түүнд багтдаг. Энэ аргыг ихээхэн учир холбогдол бүхий, хөрөнгө мөнгө шаардсан, туршилтын эсвэл нэлээд нарийн төвөгтэй ажиллагаанд ашиглахад тохиромжтой. Канад, Англи улсад өргөн хүрээтэй зөвлөлдөх талаар үнэлгээ явуулсанаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ хийгээд төрийн удирдах ажилтнуудын хоорондын уялдааг улам дээшлүүлэх гэх мэт цаашид засч сайжруулбал зохих нэлээд олон зүйлийг олж илрүүлсэн байна.
- ▶ **Хэн үнэлдэг вэ? Засгийн газар уу?** Мэдээжийн хэрэг үнэлгээг өөрөө

хийдэг. Энэ бол төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой. Засгийн газар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаандаа илүү төвийг сахисан байр сууринаас хандахыг хүсвэл **бие даасан шинжээчдээр** үнэлгээ хийлгэж болно. Франц улс иргэний шүүгчийг хэрхэн хэрэглэдэг байдлаа шинжээчдийн хороогоор үзүүлсэн байдаг. Уг хороо сургалтыг чанаржуулах, илүү өргөн төлөөлөлтэй болгох, зорилгыг тодорхой дэвшүүлэх зэрэг олон зөвлөмж гаргасан аж. Англи зэрэг зарим оронд төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд **парламентын хороод** үнэлгээ өгдөг. Тэдгээр үнэлгээг өөрсдийг нь төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлэх боломж хэмээн үзэх үндсэн дээр өөрийн үйл ажиллагаандаа үнэлгээ өгөхийг засгийн газар **иргэд буюу иргэний нийгмийн төлөөллөөс** хүсч болно/ “Идэвхтэй оролцоонд ямар арга хэрэгсэл ашиглах вэ? “ хэмээх хэсгийг үзнэ үү/. Засгийн газрын хүчин чармайлт тодорхой хэсэг бүлгийн хүрээнд хэрхэн ойлгогдож байдгийг энэ арга тодорхой бөгөөд гүн гүнзгий байдлаар харуулдаг.

Үнэлгээг хийлгэхээр тавьсан хүч чармайлтыг үр ашигтай болгох нэг нөхцөл бол засгийн газар түүний **үр дүнг өөрийн ажилд хэрэглэх** шаардлагатай нь мэдээжийн хэрэг. Нэгэнт хийгдсэн судалгааг засгийн газрын байгууллагуудад дэлгэрүүлэх шаардлагатай. Үүнийг **тайлан илтгэл, танилцуулга** хэлбэрээр тарааж болно. Тэрчлэн ил тод, нээлттэй байдлыг сайжруулахын тулд үнэлгээний тайланг хэвлэлд нийтэлж болно. Нидерланд, Испанийн нэгэн адил тэдгээр үнэлгээ болон тайлангуудыг **хэвлэлд нийтлэх** явдлыг эрх зүйн болон бодлогын зохицуулалтаар журамлаж болно /“Үнэлгээний ямар арга хэрэгсэлийг хэрэглэх вэ?” хэсгийг үзнэ үү/ Эцэст нь засгийн газар үнэлгээнээс суралцаж, бодлого, үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулж болно. Норвегийн засгийн газар зөвлөлдөх үйл ажиллагаандаа үнэлгээ хийлгэсний дараа зориуд арга хэмжээ авч, тусгай зохицуулагчдыг томилоод цаашид улам илүү амжилттай ажиллахын тулд зориуд сургалт зохиосон байна.

Үнэлгээний арга хэрэгслийг хэрэглэхдээ санах зүйлүүд:

- ▶ **Шаардагдах өгөгдхүүнийг урьдчилан тодорхойлох:** Үнэлгээ хийж эхлэхээс өмнө арга хэрэгсэл болон суурийг тодруулах өөрөөр хэлбэл үнэлгээ ямар төрлийн тоо баримтад тулгуурлах, хэн, ямар аргаар тэдгээрийг цуглуулах, хэн үнэлгээ хийх, дараа юу болохыг сайтар тогтоох шаардлагатай.
- ▶ **Үнэлгээнд хөрөнгө оруулж, түүний ажиллагааг боловсронгуй болгох:** Зааварчилга, хэмжүүр үзүүлэлт боловсруулах, сургалт зохиох нь тус дөхөм үзүүлнэ /Үнэлгээний ямар элементүүдийг хэрэглэх вэ?” хэсгийг үзнэ үү/

Мэдээлэл холбооны шинэ технологи /МХТ/-ийг ашиглах нь

МХТ яагаад хэрэгтэй вэ?

Иргэдтэй харилцаагаа бэхжүүлэхийг эрмэлзсэн засгийн газрууд мэдээлэл холбооны шинэ технологид гол анхаарлаа хандуулж, олонх нь ихээхэн итгэл найдвар тавьж байна. МХТ гэдэг бол **цахим тооцоолуур, мониторинг суурилсан холболтууд, мэдээллийн сан, программ хангамжууд, тэдгээрийг өөр хооронд нь холбогч сүлжээнээс** бүрддэг. МХТ чухамдаа бол төр, засгийн харилцааг бэхжүүлэх чухал хэрэгсэл юм. Хэдий тийм боловч МХТ зөвхөн арга хэрэгсэл төдий болохоос эцсийн зорилго биш юм. Тэр тусмаа “Арга хэрэгслүүдээс шилж сонго, хэрэглэ” хэсэгт дурдсан





бусад арга хэрэгслийн зөвхөн ганц нь билээ. Харьцангуй шинэхэн зүйл болохын хувьд МХТ өөрийн давуу болон сул талуудтай учраас энэхүү гарын авлагад тусгайлан бүлэг болгон дурдаж байгаа билээ. МХТ өвөрмөц шинж чанартай учир түүнийг анзаарч, байнга анхаарал хандуулж байх нь зүйтэй.

- ▶ **Илүү, түргэн, гүнзгий:** МХТ мэдээллийг цахим өгөгдөхүүнд эрэмбэлж, тооцоолохоос гадна тэдгээрийг асар хурдтай боловсруулж олон тооны хүлээн авагчдад хоромхон зуурт дамжуулдаг. МХТ нь арга ажиллагааг автоматжуулж үр дүнг олон хүнд түүний дотор э-шуудан, интернэт ашиглан алс зайд хүргэдэг учраас илүү их ажлыг, түргэн хугацаанд, гүн гүнзгий хийх боломж олгодог. Тийм болохоор мэдээллийг бий болгох, түгээх, хүлээн авахад олон төрлийн шинэ шинэ боломжийг нээж байгаа юм.
- ▶ **Шинэ хэрэглэгчдэд чиглэсэн байдлаар мэдээллийг зохион байгуулж, хүргэх:** Мэдээллийг нэгэн дор олон төрлөөр зохион байгуулах боломжийг МХТ олгодог. МХТ газрын зураг зэрэг иерерхи /шатлал/, индекс туслах бүтцүүдийн хоорондын уялдаа холбоог мөн бататгадаг. Энэ нь томоохон текст юмуу жагсаалт дотор анзаарагдалгүй үлдчихмээр ялимгүй бага мэдээллийг ч ийнхүү боловсруулах боломжтой учраас мэдээллийг шинэ хэрэглэгчдэд зориулан зохион байгуулж, бэлтгэхэд засгийн газарт тус дөхөм үзүүлдэг.
- ▶ **Олон талт хэрэгсэл ба хамтын ажиллагаа:** МХТ ашиглан мэдээллийг текст, график зураг, дуу, дүрс хамтатгасан олон хэлбэрээр бэлтгэж болно. Хэрэглэгчдэд илүү хамтран ажиллах боломж, хүлээн авах, хариу үйлдэл хийх зэргээр илүү сонголт олгох байдлаар мэдээллийг бэлтгэх боломжийг МХТ олгодог. Түүний хамтран ажиллах хийгээд олон төрлийн чадавх нь мэдээллийг илүү сонирхолтой байдлаар бэлтгэх арга замыг бүрдүүлж буйгаас гадна иргэд мэдээллийг илүү бие даасан, урьдчилан тааварлахааргүй байдлаар хэрэглэх, тэдний хооронд шинэ мэдлэгийг бий болгох, хамтран ашиглахад мөн тус дөхөм үзүүлдэг.

Эдгээр чанар нь олон учир шалтгааны улмаас МХТ-ийг өөр өөр **зорилго чиглэлд** тэсрэлт маягаар хөгжүүлж байгаа билээ. Засгийн газар нийгмийн мэдээллийг бататгах, эдийн засгийнхаа өрсөлдөх чадавхийг дээшлүүлэхийн тулд мэдээлэл холбооны технологийн хэрэглээг улс орондоо хөхүүлэн дэмждэг. Чингэхдээ ихэвчлэн онлайн үйлчилгээ нэвтрүүлэх, борлуулах МХТ-ийг сурталчлан хэрэглэх, цаг агаарын мэдээнээс эхлээд статистикийн мэдээллийг хүртэлх өөрийн өгөгдөхүүний эх сурвалжуудыг худалдах замаар энэ ажлыг хийж гүйцэтгэдэг.

Олон орны засгийн газрын хувьд иргэдтэй харилцаагаа бэхжүүлэхийн тулд мэдээлэл холбооны шинэ технологид үндсэн анхаарлаа хандуулж, ихээхэн итгэл тавьж байна. Онлайн орон зайд нэвтрэх, нүдэнд харагдахуйц үйл ажиллагаа явуулах, илүү их мэдээллийг үр дүнтэй, шуурхай түгээх зорилгоор ЭЗХАХБ-ын гишүүн улсууд МХТ-д ихээхэн анхаарал хандуулдаг. Зарим нь бодлого боловсруулахад иргэдийн зөвлөгөөн, оролцоог хөхүүлэн дэмжих зорилгоор МХТ –ийг ашиглаж эхлээд байна.

МХТ ашиглалтын **үр дүнг** нэгтгэн дүгнэсэн байдлаас харвал жишээ нь Япон, Испани, Европын Холбооны зэрэг засгийн газрын илтгэлд иргэдийн хариу мэдээллийг ашиглах түвшин үлэмж дээшилсэн тухай дурдсан байна. Тэрчлэн, иргэдтэй тогтоосон харилцаа нь илүү шуурхай, энгийн болсон гэж Норвеги, Швейцарийн засгийн газар үзсэн байна. Энэ хэсэгт бид төр, иргэний харилцааг бэхжүүлэхэд МХТ-ийг хэрхэн ашигласан тухай тодорхой жишээнүүдийг болон МХТ-ийн дутагдалтай тал, тэдгээрийг даван туулах арга замын талаар өгүүлэх болно.

МХТ-ийг ашиглахдаа анхаарах зүйлс:

- ▶ **МХТ-ийн хүрээ, хэрэгслийг хэрхэн хэрэглэх шаардлагатай вэ?** МХТ бол ихээхэн хүчирхэг салбар. Түүнийг хэрэглэж буй өнөөгийн техникийн нөхцөл байнга сайжирч, өргөжиж байгаа учир төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд МХТ-ийн өнөөгийн хүрээ, хэрэгслийг тэр дагуу хэрэглэх шаардлагатай.
- ▶ **Техникийн ямар нээлтүүд ойрын үед гарах вэ?** Теле-гүүр, өндөр хурдтай үүрэн телефон утасны сүлжээ зэргээс үүдэн техникийн шинэ өргөн боломж нээгдэхийг хялбархан төсөөлж болно. Тэдгээр техник технологи нь интернэтийг өргөжүүлэх замаар төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд шинэ шинэ өргөн боломжийг нээх болно.

МХТ-ийн хэрэглээг дэмжих хүрээний талаар

Зарим орны засгийн газар МХТ-ийн хэрэглээг дэмжих зорилгоор эрх зүй, бодлогын болон зохион байгуулалтын өнөөгийн хүрээг өргөтгөж эхлээд байна. МХТ-ийн өргөн хүрээтэй хэрэглээ нь харьцангуй шинэ зүйл учраас тэдгээр хүрээ **эхлэлийн шатанд** байгаа билээ. Ихэнх тохиолдолд тэдгээр нь МХТ-ийг **ерөнхийд нь хамаарахаас** бус төр, иргэний харилцааг бэхжүүлэх талыг онцлодоггүй. Эрх зүйн хүрээнд энэ байдал илүү тодорхой харагддаг. Жишээ нь засгийн газар МХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэх, хувь хүний нууцыг сахин хамгаалах, өгөгдөхүүнийг хамгаалах, онлайн мөнгөний шилжүүлэг хийх боломж бүрдүүлэх зэрэг шалтгааны улмаас МХТ-ийн олон чиглэлийн холбогдолтой **хууль тогтоомжийг** шинээр гаргах буюу өөрчлөн сайжруулдаг.





Бодлогын хүрээ нь МХТ-ийн хэрэглээний ерөнхий асуудлыг хамардаг. Энэ асуудлыг зарим нь э-засаглал/ жишээ нь Норвеги, Солонгос/-ын эсвэл төрийн үйлчилгээг шинэчлэх /жишээ нь Франц/ бодлогын хүрээнд авч үздэг байхад бусад нь төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх асуудалтай холбоотой үздэг.Тухайлбал,

- ▶ **Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог хөхүүлэн дэмжих зорилгоор МХТ-ийн хэрэглээг дэлгэрүүлдэг:** Ниймгийн мэдээллийг бэлтгэх бодлого/ жишээ нь Дани, Ирланд, Швейцарь/ нь иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны тусын тулд засгийн газраас МХТ хэрэглэхийг шаарддаг буюу хэрэглээг нь дэмждэг.
- ▶ **Хэвлэн нийтлэх буюу онлайн зөвлөлдөх:** Зарим засгийн газар тодорхой хугацаанд багтаж холбогдох мэдээллийг онлайнд байрлуулна гэж амладаг /жишээ нь Австрали, Канад, Исланд/ бөгөөд иргэдтэй зөвлөлдөхдөө МХТ-ийг аль болох түлхүү хэрэглэх зорилт дэвшүүлж болно.
- ▶ **Гарын авлага, зааварчилга:** МХТ-ийн ашиглалт нь засгийн газар болон захиргааны байгууллагуудад нийтлэг хандлага бий болгоход тус дөхөм үзүүлдэг. Энэ нь техникийн ерөнхий болон формат, агуулгын шалгуур үзүүлэлт/ жишээ нь Английн Нэгдсэн Вант Улс, Нидерланд, Швейцарь/ болон э-шууданд хариу өгөх, вэб хуудастай танилцаж үнэлгээ өгөх зэрэг тодорхой асуудлыг хамарч болно /жишээ нь Франц, Дани/.



Зохион байгуулалтын элемент: Засгийн газар МХТ-ийг ашиглахад зохион байгуулалтын элементүүд нь улс бүрд ондоо байдаг. МХТ-ийн хэрэглээ нь төвлөрсөн эсвэл эрх мэдлийг харьяа байгууллагуудад шилжүүлсэн байдалтай байж болно. Салбарын яам, газар/ жишээ нь Итали/-т эсвэл тусгай агентлаг/жишээ нь Англид/-т хариуцуулж болно. Эрх

мэдлийг харьяа байгууллагуудад шилжүүлэх чиг шугамыг баримтлан Нидерланд улс Дотоод хэрэг, Вант Улсын дотоод асуудал эрхэлсэн яамны бүрэлдэхүүнд туршлагын төвийг саяхан байгуулсан байна. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд болон бусад зорилгоор МХТ-ийг хэрэглэхдээ техник, санхүүгийн болон боловсон хүчний хангалттай нөөц бүрдүүлсэн байхад засгийн газар анхаарах учиртай.


МХТ-ийн хэрэглээг дэмжих хүрээг тодруулахад анхаарах зүйлүүд:

- ▶ **Төр, иргэдийн харилцааг дэмжих тусгай заалт хэр шаардлагатай вэ?** Олонх үндэсний хүрээ нь ерөнхийдөө МХТ-ийн хэрэглээг дэмжихэд чиглэгддэг. Гэхдээ төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд бодлогын асуудлаарх мэдэгдэл, гарын авлага гэх мэт зарим тодорхой элемент тустай байж болно.

- ▶ **МХТ-ийн эрчимтэй хөгжилд хэрхэн зохицох вэ?** МХТ-ийн салбарт шинэ шинэ нээлт түргэн хурдацтай нэвтэрч байгаа болохоор төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд МХТ-ийн хэрэглээг хөхүүлэн дэмжих хүрээ ч дорхноо хоцрогдож болно. Тиймээс хүрээг хянах хийгээд шинэчилж байх ажиллагаа шаардагдана.

МХТ мэдээлэлд хэрхэн туслах вэ?

Төр, иргэдийн харилцаанд өнөөг хүртэл МХТ-ийг хамгийн өргөн хэрэглэдэг нь мэдээллийн салбар юм. МХТ бол асар их хэмжээний өгөгдөхүүнтэй ажиллахад нэн тохиромжтой хэрэгсэл болох нь тодорхой. Засгийн газар болон засаг захиргааны байгууллагууд их хэмжээний өгөгдөхүүн бий болгодог. МХТ нь тэдгээрийг түргэн шуурхай байдлаар боловсруулах, нийтэд хүртээмжтэй болгох, түгээн тараах бололцоог олгодог. Энэ бол бодлого боловсруулах явцад шаардагдах мэдээлэлд нэгэн адил хамаарна. Засгийн газар мэдээллийн зорилгоор ашигладаг **МХТ-ийн дараах үндсэн арга хэрэгсэл байдаг:**



- ▶ **Вэб хуудас:** 2000 оны байдлаар ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын засгийн газрын төв байгууллагуудын 80 орчим хувь нь Вэб хуудастай байсан бөгөөд тэдгээрийн тоо өсөн нэмэгдсээр байна. Бельги, Дани, Ирланд, Япон, Солонгос, Нидерланд, Швейцарь, Английн Нэгдсэн Вант Улс зэрэг олон оронд засгийн газрын төв байгууллага бүгд вэб хуудастай аж.
- ▶ **Портал:** Зарим засгийн газар өөрийн үзүүлдэг бүх төрлийн үйлчилгээний гол хаалга болсон портал-ыг интернэтэд нээдэг /жишээ нь Ирланд, Шинэ Зеланд, Франц, Бельги/. Энэ нь төв засгийн газрын төрөл бүрийн салбарт /жишээ нь Португал/ болон засаглалын төрөл бүрийн шатны байгууллагад нэг гарцаар хүрэх боломж олгодог /жишээ нь Норвеги/.
- ▶ **Хайгч систем, Вэб хуудасны тодорхой бүтэц, холболтууд:** Эдгээр хэрэгсэл нь эрж хайсан мэдээллээ түргэн шуурхай олоход нь хэрэглэгчдэд тусалдаг. Вэб хуудасны бүтэц болон холбогдох мэдээлэл бүхий бусад хуудсанд хялбар хүргэх холболтууд тодорхой байх нь ажиллагааг хөнгөвчилдэг. Хайгч систем нь эрж хайсан баримт бичгээ түлхүүр үгийн туслалцаатайгаар, хялбархан олоход хэрэглэгчдэд туслахаас гадна тухайн баримт бичигт хүргэх холболтуудын болон шууд гарцын жагсаалтыг өгдөг. Засгийн газрын вэб хуудас нь яамд, тусгай газруудаар гэхчлэн хайлт хийх хэд хэдэн түвшингийн хайгч системийг санал болгох бөгөөд хайлтыг хялбар болгоно /жишээ нь Канад/.
- ▶ **Цахим түц:** Засгийн газар нь иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулах зорилгоор олон нийтийн газруудад олон нийтийн мэдээллийн он лайн гарц байгуулж /жишээ нь Грек, Португал, Мехсик/ болно.

- ▶ **СД Ром, компьютерийн диск:** мэдээллийг сүлжээнээс тусад нь хадгалах боломж олгодог СД Ром өгөгдэхүүн ихтэй хэрэглээнд тохиромжтой. Жишээ нь Португал, Норвегийн засгийн газар өөрсдийн мэдээллийн ажиллагаанд тэдгээрийг ашигладаг. Компьютерийн диск нь бага хэмжээний өгөгдөхүүнийг цахим аргаар, сүлжээнээс гадна хэвлэхэд хэрэглэгддэг.

Засгийн газрууд “Мэдээлэлд ямар хэрэгсэл хэрэглэх вэ?” бүлэгт дурдсан ихэнх **мэдээллийн бүтээгдэхүүнийг** болон бусад баримт бичгийг хэвлэхэд эдгээр аргыг хэрэглэдэг. **Мэдээллийн дараах бүтээгдэхүүнийг ихэвчлэн МХТ-ийг ашиглан хэвлэж, түгээдэг.**

- ▶ **Бодлогын асуудлаарх саналын баримт бичиг, хууль тогтоомжийн төсөл, тайлангууд:** Жишээ нь Австри, Дани, Францын засгийн газар бодлогын санал буюу хууль тогтоомжийн төслийг интернэтэд байрлуулдаг. Парламентууд хэлэлцэж буй хуулиудынхаа төслийг интернэтэд тавьдаг / жишээ нь Шинэ Зеланд/. Засгийн газрууд үнэлгээ буюу үзлэг шалгалтын болон бусад тайланг мөн дээрх байдлаар нийтэлдэг.
- ▶ **Албан баримт бичиг, хүчинтэй хууль тогтоомж, төсвийн холбогдолтой мэдээлэл, каталогийн баримт:** Люксембург, Австрийн засгийн газар хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудтай он лайнаар чөлөөтэй танилцах боломж олгодог. АНУ-ын засгийн газар улс орныхоо төсвийн холбогдолтой тайлбар болон график зургууд зэрэг баримт материалыг интернэтэд тавьдаг.
- ▶ **Бодлого боловсруулах үйл явц, арга ажиллагаа:** Олон орны засгийн газар бодлого боловсруулахтай холбогдсон хэвлэлийн мэдээ, хэлсэн үгүүд, засгийн газрын бүтэц, хууль хэлэлцэх цагийн хуваарь гэх мэт өргөн хүрээтэй мэдээллийг вэб хуудсандаа тавьдаг.
- ▶ **Материалуудын хадгалалт, архив:** Засгийн газрууд албан баримт бичгүүд болон мэдээллийн бусад бүтээгдэхүүнийг вэб хуудсанд тавьсанаар тэдгээр материалын хадгаламж, архивыг бүрдүүлдэг. Энэ нь хэрэгтэй мэдээллээ өөрсдийн компьютер, сүлжээнд татаж авахыг хүссэн иргэдэд ихээхэн дөхөм үзүүлдэг.

Мэдээллийг хадгалах хийгээд түргэн шуурхай түгээн дамжуулахад МХТ ашиглах нь үлэмж тустай. МХТ-ийн давуу тал зөвхөн үүгээр үл шавхагдана. Шинэ мэдээлэл бий болгох, харилцан солилцох, хүртээмжтэй болгох, шинэлэг байдлаар дэлгэн үзүүлэхэд МХТ засгийн газруудад ихээхэн үр дүнтэй туслагч болдог. Нөгөөтэйгүүр, МХТ-ийн хэрэглээ нь мэдээллийн уламжлалт үйл ажиллагаатай хамт явагдаж байх ёстой.

Засгийн газрууд МХТ-ийг ашиглан шинэ буюу урд өмнө нийтлэгдэж байгаагүй мэдээллийг нийтийн хүртээл болгох дараах шинэлэг арга хэлбэрийг үүсгэж болно. Үүнд:

- ▶ **Засгийн газрын бүтэц, албан хаагчдын талаарх дэлгэрэнгүй албан**

мэдээ: Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт, олон нийттэй харьцдаг тодорхой албан хаагчдын нэр, албан тушаал, холбоо барих хаяг сэлт энд хамрагдана. Жишээ нь Швейцарь, Мехсик, Шинэ Зеландад засгийн газрын бүтэц, зохион байгуулалт, харилцах хаяг, тэр ч байтугай олон улсын байгууллагууд дахь төлөөлөгчдийн талаарх мэдээллийг он лайн байдлаар тавьдаг.

- ▶ **Он лайн-д нийцүүлсэн текст ба олонтаа давтагддаг асуултууд:** Канад зэрэг улс хэрэглэгчдэд зориулсан олонтаа давтагддаг асуултуудад хариу өгөх зорилготой он лайн-д нийцүүлсэн текстүүдийг тусгайлан бэлтгэж байрлуулдаг.
- ▶ **Хувийн мэдээлэл:** Ил тод байдлыг дэмжиж, мэдээллийн нууцыг сахихын тулд хувь хүний талаар засгийн газрын албан хаагчдын мэдэлд буй мэдээллийг тухайн хүн өөрөө үзэх, түүнийг ашиглаж байгаа байдлыг хянах боломжийг нэмэгдүүлэх арга замыг Нидерландад эрэлхийлдэг.

Дэлгэрэнгүй мэдээллийг нэгэнт уламжлал болсон хэвлэлд нийтлэгдсэн ч хаанаас хэрхэн олж үзэхийг мэддэггүй юмуу тодорхой хэмжээний бэрхшээл тулгардаг зэргээс үүдэн түүнийг авч ашиглахад жирийн иргэдэд төвөгтэй байж болно. Тиймээс **засгийн газар МХТ ашиглаж дараах байдлаар мэдээллийн хайлт болон ашиглалтыг хялбаршуулж болно.** Тухайлбал,

- ▶ **Каталог, бүртгэл, баримт бичгийн түүврийг шинэчлэн багцлах:** АНУ-ын засаг захиргаа гэх мэт засгийн газрууд хэдийн бэлэн болчихсон каталог, бүртгэл, баримт бичгийн түүвэр зэргийг МХТ-ийн мэдээллийг дамжуулах боломжид тулгуурлан шинэчлэн багцалдаг.
- ▶ **Интернэтэд нийцүүлсэн заавар, захиргааны журмуудыг дэлгэрэнгүй тайлбарлах:** Солонгос улс захиргааны байгууллагад мөрдөгдөж байгаа дүрэм журмууд дэлгэрэнгүй тайлбар, зааврыг интернэтэд тохируулсан байдлаар бэлтгэдэг нь иргэдтэй зөвлөлдөх явцыг ихээхэн нэмэгдүүлдэг. Дани улс эрүүл мэндийн тодорхой төрлийн үйлчилгээнд хамрагдахаар дугаар хүлээсэн хүмүүст дарааллын чухам хаана байгааг он лайн-аар мэдээлдэг.
- ▶ **Хэрэглэгчдэд хандсан чиглүүлэгч:** Засгийн газар түүний талаарх мэдээллийг цахим орон зайд эрж хайх хэрэглэгчиддээ дөхөм болгохын тулд мэдээллийг тодорхой гарчиг, хэсэг бүлэгт ангилан байрлуулдаг. Энэ маягаар хэрэглэгчдийг бизнес эрхлэгчид, мэргэжилтнүүд, иргэд гэх мэт олон нийтийн тодорхой хэсэгт зориулсан бүлэгт залж чиглүүлж болно. Данид “хүүхэдтэй болох”, “орон сууцаа солих” гэх мэт хүний амьдралд тохиолдож болох тодорхой үйл явдлуудын холбогдолтой мэдээллийг нэг дор байрлуулах замаар хэрэглэгчдийг чиглүүлдэг. Энэ нөхцөлд хэрэглэгчид эдгээр асуудлаар засаг захиргааны ямар байгууллагад очих вэ ? гэдгийг урьдаас мэдэх шаардлага үгүй болох юм.

Мэдээллийн уламжлалт бүтээгдэхүүнийг шинэлэг арга хэлбэрүүдтэй холбох арга замыг засгийн газрууд эрэлхийлж байна. Жишээлбэл:

- ▶ **Сонирхолтой элемент:** Мэдээлэл авах нь иргэдэд илүү таатай байхуйцаар зохион байгуулах боломжийг МХТ засгийн газруудад олгож байна. Үүнд кино, дуу бичлэг, дагалдах хөгжим, хүүхэлдэйн кино, тоглоом, асуулт-хариултын тэмцээн гэх мэт олон арга байж болно. Английн засгийн газар тухайн жилийн ажлын тайлан илтгэлдээ бодлогын арга хэмжээнүүдийг гүйцэтгэгч ажилтнууд нь хэрхэн хэрэгжүүлж байгааг тайлбарлаж үзүүлсэн арван кино дагалдуулсан байна.
- ▶ **Асуулт, хариулт:** Европын Холбоо нэгдсэн мөнгөн тэмдэгт (евро)-д шилжихээр бэлтгэх явцдаа “Халз асуулт” хэмээх мэдээллийн сан байгуулсан. Уг сан еврогийн талаарх, уншихад хялбар 150 гаруй товч асуулт болон тэдгээрийн хариултыг холбогдох 11 орны хэл дээр бэлтгэсэн бөгөөд асуулт, хариултууд нь бүтэц, индекс, хайгч систем, холбогдох ишлэлүүдээр өөр хоорондоо холбогдсон аж. Иргэдийн шинэ асуултуудаар мэдээллийн санг байнга шинэчилж байсны дээр Европын холбооны нэр хүндтэй хүмүүсийн хэлсэн үгэнд байнга дурдаж, еврогийн талаарх үзэсгэлэнд байрлуулж, хэвлэн нийтэлж байсан байна.
- ▶ **Вэб хуудас болон утасны үйлчилгээг хамтатгах:** Английн Нэгдсэн Вант Улс Үндэсний үйлчилгээ болон бодлогын асуудлаарх, хэрэглэгчдэд ойр, мэдээллийн бодит үйлчилгээг эрүүл мэндийн тогтолцооны тухай вэб хуудсанд холбож, 24 цагийн ажиллагаатай харилцуур утасны үйлчилгээнд хамруулсан байна.

МХТ-ийн хэрэгсэл ашиглан мэдээлэл хүлээн авахдаа анхаарах зүйл:


- ▶ **Мэдээллийг удирдах шаардлага:** Шинэ болон нэгэнт бэлэн байгаа текст, баримт бичгүүдийг вэб хуудсанд шуурхай байрлуулсанаар байнга ашиглах боломжтой их хэмжээний цахим мэдээлэл бүрдэнэ. Ямар текст, баримт бичгүүд он лайнаар нийтлэгдсэн болон үл нийтлэгдсэн, тэдгээр нь хүчин төгөлдөр эсвэл хуучирсан, шинэчлэх шаардлагатай эсэх, албан ёсоор баталгаажсан, ямар хэлээр нийтлэх шаардлагатай гэхчилэн мэдээлэлтэй танилцах, удирдан зохион байгуулах засгийн газрын чадавх мөн нэгэн адил байнга нэмэгдэж байх шаардлагатай. Тийм учраас мэдээллийг мэргэжлийн талаас удирдах, нийтэд үйлчилгээ үзүүлдэг байгууллага /вэб хуудас/-ыг арын алба/засгийн газрын авч хэрэгжүүлсэн үйл явц, арга ажиллагаа/-тай уялдуулан холбох чадвар туйлын чухал болно.
- ▶ **Мэдээллийг МХТ-ийн давуу болон сул талд тохируулж бэлтгэх:** Анхнаасаа хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэлд зориулж бэлтгэсэн баримт бичгүүд буюу хэвлэмэл товхимол, хэлсэн үгнүүд илүү том хэмжээний баримт бичгүүдийн цахим хувилбар гэх мэт өнөөгийн

компьютерийн болон холболтын дэлгэцэнд тохирдоггүй. Технологийн хөгжлийн өнөөгийн түвшинд цахим баримт материалыг унших нь ядаргаатай бөгөөд өртөг ихтэй ажил. Хэвлэмэл материалын цахим хувилбар нь компьютерээс татаж авахад тохиромжтой байж болох ч МХТ-оор дамжуулан шууд хэрэглэхэд улам бүр тохирохгүй болж байна. Товч бөгөөд оновчтой мэдээлэл бүхий текстийг МХТ-оор дамжуулж авах, уншихад дөхөм байдаг. Ерөнхийдөө, мэдээлэл хийгээд түүнийг дамжуулах арга тохирч байх тохиолдолд ихээхэн үр дүнтэй бөгөөд бүтээмж өндөр байдаг.

- ▶ **Хэрэглэгчдийн техникийн шийдлүүдийг хангах:** Хэрэглэгчид тухайн үеийн жишгээс ондоо техник болон программ хангамж хэрэглэж болох талтай.
- ▶ **Өсөн нэмэгдэж буй эрэлт шаардлагад нийцүүлэх:** МХТ-д өчигдөрийн ололт өнөөдрийн хувьд нийтлэг хэрэглээ, харин маргаашийн хувьд цаг үеэсээ хоцорсон хэрэглэгдэхүүн гэж тооцогдох болно. Түүний адил хурд, багтаамжийн талаарх иргэдийн эрэлт шаардлага өсөн нэмэгдэж байна. Үлэмж хурдтай өсөн нэмэгдэж байгаа иргэдийн эрэлт шаардлага, хөрөнгө хүчний хэрэгцээг хангахад засгийн газар зохих бэлтгэлтэй байх нь зүйтэй.
- ▶ **Туршлагаас суралцах:** Мэдээллийн уламжлалт хэрэгслийг хэрэглэх үед анхаарах олон зүйл/ “арга хэрэгслийг сонгох ба хэрэглэх нь” бүлгийг үзнэ үү/ нь МХТ-ийг мэдээллийн зорилгоор хэрэглэхэд мөн тохирдог.

Зөвлөлдөх болох идэвхтэй оролцоонд МХТ хэрхэн тус дөхөм үзүүлдэг вэ?

Засгийн газар иргэдийг мэдээллээр хангахдаа МХТ-ийг олон талаар хэрэглэхээс гадна тэдэнтэй зөвлөлдөх явцдаа ашигладаг болж байна. Норвеги, Нидерланд гэх зэрэг зарим улсын засгийн газар МХТ-ийн бодлогодоо үүнийг зорилгоо болгон дэвшүүлж байна. **Иргэдтэй зөвлөлдөх МХТ-ийн арга хэрэгсэлд дараах зүйлүүд багтана. Үүнд:**



- ▶ **Э-шуудангийн хайрцаг:** Э-шуудангийн хайрцаг нь засгийн газарт хариу мэдээлэл илгээх бололцоог иргэдэд олгодог. Энэ нь иргэд чөлөөтэй бичиж болох э-шуудангийн хаяг юм. Тодорхой асуудлуудаар тус тусад нь э-шуудангийн хайрцаг байж болно. Вэб хуудсан дахь э-шуудангийн хайрцаг нь Английн Нэгдсэн Вант Улсынх шиг хэрэглэгч өөрөө хариулаад бөглөх учиртай, урьдчилан бэлтгэсэн асуулт бүхий онлайн маягийн хэлбэртэй байж болно.
- ▶ **Э-шуудан түгээх жагсаалт:** Эдгээр жагсаалтын дагуу засгийн газар хууль болон бодлогын төслийг сонирхогч талуудад илгээх бөгөөд иргэд вэб хуудсаар дамжуулан тэдгээр жагсаалтад хаягаа оруулахаар

урьдчилан захиалж болно. Мэдээллийг хүлээн авмагц тэд өөрсдийн санал бодлыг засгийн газарт илгээдэг /жишээ нь Исланд/.

- ▶ **Вэб хэлэлцүүлэг болон мэдээллийн хэсэг:** Эдгээр нь э-шуудан түгээх жагсаалттай төстэй боловч нийт оролцогчийн санал бодолтой танилцах, өөрийн санал бодлыг илэрхийлэх, илгээх боломжийг тухайн иргэнд олгодог талаараа өвөрмөц онцлогтой. Бүгд Найрамдах Чех Улсын засгийн газар вэб хуудсандаа захиргааны шинэчлэлийн хөтөлбөрийн талаарх онлайн хэлэлцүүлэг нээсэн байна. Солонгос улс төсвийн төлөвлөлтийнхөө талаар харилцан ярианы систем нээж жилдээ 5 мянга орчим санал хүсэлт хүлээн авсан байна. Засгийн газар ийм солилцоог бүрэн чөлөөтэй орхихоос гадна бусдыг дайрч доромжилсон шинжтэй сэтгэгдэлүүдийг ялгаж салгах, устгах зорилгоор уг хэлэлцүүлэгт хөтөлгөч ажиллуулж болно. Финляндын засгийн газар бодлогын асуудлаар иргэд бүртгүүлэх албагүйгээр оролцдог вэб чуулганыг нээхэд хэлэлцүүлэгийн удирдагч арьсны өнгөөр ялгаварлан гадуурхсан шинжтэй санал бодлыг арилгах зэргээр хөндлөнгөөс оролцсон тохиолдол цөөн боловч гарсан байна.
- ▶ **Онлайнаар шууд ярилцах арга хэмжээ:** Э-шуудангийн хаягийн жагсаалт болон вэб хэлэлцүүлэг тодорхой цаг хугацаанд л явагддаг учраас хэрэглэгч нь түүнд оролцохдоо тодорхой хугацаагаар хожимддог. Гэтэл, шууд ярилцлагын явцад урьдчилан товлосон цагт уг ярилцлагад оролцогчид ихэвчлэн хоёр цагийн туршид санал бодлоо хоромхон зуурт шууд харилцан солилцдог. Данийн Боловсролын сайд долоо хоног тутам онлайн ярилцлага явуулдаг, Европын Холбоо нь өөрийн комиссаруудтай нээлттэй, олон хэлээр шууд харьцах боломж олгосон ярилцлагыг үе үе зохион байгуулдаг. Зарим үед засгийн газрууд групп хэлэлцүүлгийг нэлээд эрчимтэй өрнүүлэх үүднээс оролцогсдын тоог 10 эсвэл 12-оор хязгаарладаг.
- ▶ **Судалгаа:** Засгийн газрууд өөрсдийн үзүүлж буй үйлчилгээ болон бодлогын асуудлаарх судалгааг вэб хуудсаар болон э-шуудангаар явуулдаг. Эдгээр судалгаанаас сонирхолтой дүр зураг харагдах боловч нийт хүн амыг бүрэн төлөөлөх нь ховор байдаг.

Засгийн газрууд олон төрлийн асуудлаар зөвлөлдөхдөө МХТ-ийг саяхнаас ашигладаг болж байна. Энэхүү шинэ боломжийг судлах эхний шатанд тэд мэдээлэл холбооны шинэ технологитой холбоотой сэдвийг ихэвчлэн сонгож байна. Дани, Норвеги, Ирланд, Английн Нэгдсэн Вант Улсад цахим худалдааны талаарх хуулийн төслөөр онлайн зөвлөгөөн хийсэн байна. Эл асуудалд оролцогч засгийн газрын албан хаагчид, иргэд, сонирхолын бүлгүүдийн төлөөлөл өргөн хэмжээгээр МХТ хэрэглэдэг болохын хэрээр энэ сэдэв засгийн газрын шинийг эрэлхийлэх эрмэлзэлд болон иргэдтэй онлайн зөвлөлдөх анхны чармайлтад нааштай дэмжлэг үзүүлж байна. Нөгөөтэйгүүр, тэдгээр сэдэв болон МХТ-ийн ашиглалт нь олон нийтийн оролцоог бас

хязгаарладаг. Иргэдийн зарим нь тухайн үед онлайн-д байдаггүй эсвэл тэрхүү зөвлөгөөний тухай огт сонсоогүй байж болно. Онлайн зөвлөгөөний боломж бололцоог нийтэд таниулахын тулд Канад улс МХТ–д тулгуурласан зөвлөлдөх ажиллагааг төлөвлөхдөө иргэдийг болон иргэний нийгмийн байгууллагуудыг өргөн оролцуулдаг байна.

МХТ ашиглан төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх үйл ажиллагааны хамгийн сул хөгжсөн хэсэг нь бодлого боловсруулах явцад иргэдийн идэвхтэй оролцоог хангахдаа МХТ хэрэглэх явдал юм. Энэ бол бүхэлдээ судлагдаагүй салбар боловч засгийн газрууд иргэдийг идэвхтэй оролцуулах чиглэлээр МХТ-ийн дараах зарим арга хэрэгсэлийг ашиглаж байна.

- ▶ **Гадаад холбоо:** Засгийн газар өөрийн вэб хуудаснаас гадна талын бусад вэб хуудастай холбоо тогтоож болно. Тэдгээр холбоог иргэний нийгмийн байгууллагууд, сонирхолын бүлгүүд, хувь иргэд, Английн Нэгдсэн Вант Улсын Үндэсний Эрүүл мэндийн үйлчилгээний вэб хуудасны адил олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагууд ажиллуулж болно. Засгийн газар бодлогын асуудлаар заавал өөрийнх гэлтгүй тэр байтугай сөрөг санаа бодлыг ч нийтлэх замаар бодлого боловсруулах ажиллагаандаа нээлттэй хандлагыг баримталдаг. Ийм маягаар иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран нийтлэг асуудлуудыг тодорхойлж, нээлттэй харилцаа тогтоож болно.
- ▶ **Засгийн газрын вэб индэр ба онлайн шууд ярилцлага:** Иргэдтэй зөвлөлдөх эдгээр хэрэгсэлийг зарчмын хувьд бодлого боловсруулахдаа тэднийг идэвхтэй оролцуулах зорилгоор мөн ашиглах бололцоотой. Чингэхийн тулд засгийн газар өөрийн вэб индэр болон онлайн шууд ярилцлагаар дамжуулж иргэдтэй хамтран бодлогын асуудлаар санал боловсруулах шаардлагатай.
- ▶ **Иргэдийн вэб индэр болон онлайн ярилцлагыг ашиглах:** Засгийн газар өөрийн төдийгүй иргэдийн вэб хуудсыг ашиглан тэдэнтэй харилцан яриа өрнүүлж болно. Эдгээр боломжийг нээж олоход төдийлөн хялбар бус боловч иргэдэд хүрэх, бодлого боловсруулах явцад тэднийг оролцуулах чухал хэрэгсэл болдог.
- ▶ **Хамтарсан тоглоом, нөхцөл байдлыг зохиомжлох:** Хотын хөгжлийн төлөвлөгөөний талаар Финляндын Тампере хотод хийсэн шиг засгийн газар онлайн тоглоом, нөхцөл байдлын зохиомжоор дамжуулан бодлогын хувилбар, санал санаачилга дэвшүүлэхдээ иргэдийг татан оролцуулахын тулд МХТ хэрэглэх шинэлэг арга замыг эрэлхийлж болно.
- ▶ **Цахим ажлын орон зай:** Финлянд, Канадын засгийн газар бодлого боловсруулахад иргэдийг оролцуулахын тулд цахим номын сан, архив бүхий онлайн ажлын хэсгийн хэлбэртэй цахим ажлын орон зай бий болгодог. Энэ зорилгоор Канадын засгийн газар залуучууд гэх мэт

иргэдийн тодорхой хэсгийг төлөөлдөг түнш байгууллагуудтайгаа хамтран тусгай вэб хуудас нээсэн байна.

Зөвлөгөөн, идэвхтэй оролцоонд МХТ хэрэглэхдээ анхаарах зүйлүүд:

- ▶ **Өгөгдөхүүн цуглуулах болон дүн шинжилгээний хэрэглээ:** Эдгээр программ хангамжийг хэрэглэх нь олон нийтийн санал бодол болон дүгнэлтийг цуглуулах, эмхэтгэх, дүн шинжилгээ хийхэд тус дөхөм үзүүлж болох юм.
- ▶ **Төлөвлөх шатанд иргэдийг оролцуулах:** Зөвлөлдөх үйл ажиллагааг төлөвлөх шатанд иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудыг МХТ хэрэглэн хамран оролцуулах нь тэдний оролцоог үлэмжхэн нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- ▶ **Удирдах ба хэрэгжүүлэн гүйцэтгэхдээ болгоомжлох:** Цахим аргаар зөвлөлдөх үйл явцыг удирдах хийгээд хэрэгжүүлэх нь санал бодлоо илэрхийлэх боломжийг оролцогч нэг бүрд олгохоос гадна уг ажиллагаанд хууль бус, зүй бус санал бодол хүндрэл бэрхшээл учруулахгүй байлгахад анхаарах хэрэгтэй. Удирдах хийгээд хянахын хооронд ялгаа бага боловч хяналт нь олон нийтийн зөвлөгөөнийг чөлөөтэй, нээлттэй явуулах үндсэн үзэл санаатай зөрчилддөг. Засгийн газрууд онлайн зөвлөгөөнийг удирдаж хэрэгжүүлэхдээ эдгээр асуудалд нэн болгоомжтой хандвал зохино.
- ▶ **Туршлагаас суралцах:** Зөвлөгөөн, идэвхтэй оролцооны уламжлалт арга хэрэгслийг хэрэглэхэд /"Арга хэрэгслийг сонгох хийгээд хэрэглэх" бүлгийг үзнэ үү/ болон мэдээлэлд МХТ-ийн арга хэрэгслийг хэрэглэхэд /өмнөх хэсгийг үзнэ үү/ болгоомжтой хандвал зохих олонх асуудал энд нэгэн адил хамаарах болно.

МХТ-ийг үнэлгээнд хэрхэн хэрэглэх вэ ?

МХТ нь өгөгдөхүүнтэй ажиллах өргөн боломжтой учир МХТ-т тулгуурласан, эс тулгуурласан ч мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог үнэлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. МХТ нь өгөгдөхүүн цуглуулах, чанарын дүн шинжилгээ хийх, мэдээлэлтэй ажиллахад тус дөхөм үзүүлдэг. МХТ ашиглан төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр хийгдсэн ажилд үнэлгээ өгөх арга хэрэгсэл нь өөрөө МХТ-ээс гадна үнэлгээний илүү уламжлалт арга хэрэгслийн элементүүдийг хэрэглэдэг. **Үнэлгээнд тус дөхөм үзүүлэх арга хэрэгсэлд дараах зүйлийг дурдаж болно. Үүнд:**

- ▶ **Программ хангамж** жишээ нь өгөгдөхүүнийг компьютерт шивж оруулах, хадгалах, дүн шинжилгээ хийх, ажлын явцад хэрэглэгддэг.
- ▶ **Вэб статистик:** Засгийн газар жишээ нь МХТ-ийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаандаа үнэлэлт өгөх үүднээс дэлгэрэнгүй, иж бүрэн статистик бүртгэл хийж болно /жишээ нь Мехсик/. Программ хангамж

тэдгээр статистикийг байнгын байдлаар цуглуулж тогтмол мэдээлж байх боломж олгодог.

- ▶ **Хэрэглэгчийн хариу мэдээлэл:** Английн Нэгдсэн Вант Улс, Франц зэрэг улс өөрийн вэб хуудас хэрэглэгчдэд хандаж хариу мэдээлэхийг хүсдэг. Энэ чиглэлээр МХТ хэрэглэх нь түүнийг зөвлөлдөхөд хэрэглэхтэй нэгэн адил.
- ▶ **Вэб хуудастай танилцах:** Танилцах судалгаа МХТ-ийн хэрэглээнд чанарын гүн гүнзгий үнэлгээ хийх боломж олгодог. Францад засгийн газрын хүсэлтээр түүний вэб хуудасны ашиглалтанд бие даасан агентлагууд 120 гаруй шалгуур, чанарын үзүүлэлт бүхий өргөн хүрээтэй судалгаа явуулж үнэлгээ өгсөн байна.

МХТ хэрэглэн үнэлгээ өгөхдөө анхаарах зүйл:

- ▶ МХТ-т тулгуурласан үнэлгээ эхлэлийн шатанд байна. Одоогоор МХТ-ийн арга хэрэгсэл үнэлгээнд төдийлөн их туслалцаа үзүүлэхгүй байж болно. Гэвч МХТ-ийн өнөөгийн давшингуй хөгжлийн дүнд илүү хүчтэй, төр, иргэний харилцааг бэхжүүлэх хүчин чармайлтад үнэлгээ өгөх өвөрмөц эрэлт шаардлагад нийцсэн хэрэгслүүд бий болно.
- ▶ МХТ өөрөө үнэлгээ хийдэггүй: МХТ үнэлгээнд тус дөхөм үзүүлэх бөгөөд бусад тохиолдолд их хугацаа шаардах ажил /өгөгдөхүүн цуглуулах, дүн шинжилгээ хийх/-ыг хөнгөвчилдөг. МХТ-д тулгуурласан үнэлгээг бэлтгэх хийгээд эцсийн үр дүнг боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангах хүний төлөвлөлт, дүн шинжилгээ шаардагдана.

МХТ-ийн сул тал, тэдгээрийг даван туулах арга зам

Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоонд МХТ олон төрлийн давуу тал, боломж олгохоос гадна өөрийн дутагдал доголдолтой. Засгийн газар МХТ-ийн туслалцаатайгаар төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн ажиллагаа явуулах тохиолдолд дээрх дутагдал доголдлыг зайлшгүй мэдэж байх шаардлагатай. **Үндсэн доголдол дутагдлыг** тоочвол олныг дурдаж болно.

- ▶ **Цахим ялгаа:** Цахим ялгаа гэдэг бол МХТ/ялангуяа интернэт/ хэрэглэдэг, хэрэглэдэггүй хүмүүсийн хоорондох зааг ялгаа юм. Энэ ялгаа орлого, боловсрол, нас, хүйсийн хувьд харилцан ялгаатай хувь хүмүүсийн хооронд үүсэхээс гадна айл өрх, бизнесийн салбар чиглэл, газар зүйн бүсүүдийн хооронд болон бүхэл улс орны хэмжээнд ч оршиж болно. 2000 оны нэгдүгээр сарын байдлаар интернэтэд холбогддог иргэдийн нийт хүн амд эзлэх хувь Канад, Дани, Солонгос зэрэг улсад 20 орчим, Бүгд Найрамдах Чех, Грек, Унгар болон Мехсикт 2 орчим гэх мэтээр улс орнуудад ихээхэн зөрүүтэй байв. МХТ-ийн хувьд цахим зааг гэдэг бол мэдээлэлтэй болон мэдээлэлгүй хүмүүсийн хоорондох

ялгааг илэрхийлдэг. Энэ нь аль ч засгийн газрын гагцхүү МХТ хэрэглэн иргэддээ хүрэх төлөвлөгөөнд бэрхшээл учруулж иргэдэд хэрхэн тэнцүү хүргэх боломж олгох вэ гэдэг асуултыг дэвшүүлэн тавьдаг.

- ▶ **Тусгай бүлгийн хэрэглээ:** Нийгмийн доторх зарим бүлгийнхний хувьд компьютер эзэмших, хэрэглэхэд тодорхой бэрхшээл үүсдэг. Жишээ нь тахир дутуу хүмүүс, ахмад настан, хэлний бэрхшээл бүхий үндэсний цөөнхийг дурдаж болно.
- ▶ **Компьютер, МХТ-г ашиглах иргэдийн мэдлэг:** Компьютертай байна гэдэг түүнийг ашиглаж мэддэг гэсэн үг хараахан биш. Ирээдүйд теле-гүүр хэрэглэх замаар МХТ хэрэглэхэд илүү хялбар болохыг үгүйсгэхгүй боловч өнөөгийн шатанд түүнийг ашиглахын тулд зохих хэмжээний мэдлэг, дадлага туршлагатай, компьютер ашиглах зохих мэдлэгтэй байх шаардлагатай. Тэдгээр чадварыг ганц хоногт эзэмших боломжгүй хийгээд тийм ч түргэн хугацаанд нийтийн хүртээл болгоод дэлгэрүүлдэггүй.
- ▶ **Засгийн газар дахь хүний хүчин зүйл:** Компьютер эзэмших нь засгийн газрын хувьд ч бэрхшээлтэй асуудал байж болно. ЭЗХАХБ-ын гишүүн улсуудад төрийн албан хаагчдын 50 гаруй хувь ажлын байрандаа компьютер эзэмшдэг бөгөөд Австрали, Финлянд, Канад, Дани, Нидерланд, Швейцарь, Япон зэрэг оронд энэ үзүүлэлт хэдийн 100 хувьд хүрчээ. Эдгээр үзүүлэлт өргөн олон нийтийг бодвол төрийн байгууллагуудад илүү өндөр байдаг боловч төр, иргэдийн харилцаанд МХТ-ийг идэвхтэй хэрэглэхийн тулд нэлээд өндөр төвшний чадвар шаардагддаг. МХТ хэрэглэснээр иргэдийн хариу мэдээлэл нэмэгддэг боловч хүний болон техникийн ихээхэн чадавхи шаардагддаг.
- ▶ **Техникийн чадавхи:** Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоонд МХТ хэрэглэхэд засгийн газраас болон иргэдээс техник тоног төхөөрөмж шаарддаг. Энэ ажил амжилттай болохын хэрээр засгийн газрын хувьд техникийн эрэлт шаардлага огцом нэмэгддэг. Түүнчлэн, төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд шаардагдах МХТ нь засгийн газарт өмнө нь хэрэглэгдэж байсан МХТ-ийн системтэй заавал тохирч байх албагүй.
- ▶ **Үнэ өртөг, санхүүгийн бэрхшээл:** Бусад арга хэрэгсэлтэй харьцуулахад МХТ зардал мөнгө хэмнэдэг юм шиг харагддаг. Тийм ч байж болно. Гэвч эрэлт хэрэгцээ, тооны болон чанарын шаардлага, үйл ажиллагааны найдвартай байдал нь нэмэгдэхийн хэрээр зардал тэр бүр хэмнэгддэггүй.
- ▶ **Эрх зүйн статус ба хариуцлага:** МХТ–д суурилсан зарим үйл ажиллагааны эрх зүйн болон бодлогын хүрээ хараахан бүрэн бүрдээгүй байна. Энэ нь онлайн зөвлөгөөн болон оролцооны явц дахь

засгийн газрын албан хаагчдын гүйцэтгэх үүрэг, эрх зүйн статусаас хамаардаг бөгөөд тэдний хүлээх хариуцлагын хувьд ч санаа зовоодог.

- ▶ **Хувийн нууц ба аюулгүй байдал:** Хувийн нууц болон өгөгдөхүүний нууцын талаар иргэд багагүй санаа тавьдаг. Онлайн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоонд МХТ-ийг зохих ёсоор нь хэрэглэнэ гэвэл дээрх асуудалд зайлшгүй анхаарал хандуулах шаардлагатай.
- ▶ **Онцлог байдал:** МХТ бол цахим хэрэгсэл бөгөөд одоогоор цахим дэлгэцтэй хэрэглэгддэг. Тэдгээр нь хүмүүстэй амьд харилцаа тогтоодоггүй. МХТ нь эрчим хүчний хангалт, зүй ёсоор ажиллах теле холбооны холболтоос хамаардаг. Эдгээр болон бусад онцлог харьцангуй давуу тал бүхий цахим бус арга хэрэгслүүдийг бодвол төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх зорилгоор МХТ-ийг хэрэглэхэд зарим бэрхшээл үүсгэдэг.

Эдгээр бэрхшээл МХТ-ийг хэрэглэхэд засгийн газруудад саад тотгор учруулах ёсгүй. МХТ нь төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд чухал хэрэгслүүдийг бий болгодог боловч түүний дутагдалтай талуудыг шийдвэрлэх шаардлага зайлшгүй гарна. Тэрхүү дутагдалтай талуудыг дараах аргаар шийдвэрлэж болно. Үүнд:

- ▶ **Хүртээмжтэй болгох:** Засгийн газар компьютер болон цахим ТҮЦ-ийг Дани, Ирланд, Нидерландын адил нийтийн номын сангуудад, Канадын адил дунд сургуулиудад, Финляндын адил өндөр настны асрамжийн газруудад Мехсик, Грекийн адил олон нийтийн бусад газарт байрлуулж болно.
- ▶ **Өвөрмөц хэрэгцээг хангах:** Австрали, Данийн адил харах эрхтний гэмтэл согогтой хүмүүст зориулан сонсох төхөөрөмж суурилуулах буюу Норвегийн адил ахмад настнуудад зориулж тусгай туслалцаа бий болгох нь өвөрмөц бүлгийнхэнд МХТ-ийг хүргэх, түүнийг хэрэглүүлэхэд дэмжлэг болно. Португалийн засгийн газар вэб хуудсаа тахир дутуу хүмүүст хүртээмжтэй болгох бодлого явуулсан байна.
- ▶ **Туслалцааг танилцуулах:** Засгийн газар МХТ ашиглан орон нутгийн хэмжээнд зохиогддог арга хэмжээ, сургалтуудыг олон нийтийн төвүүдэд болон кибер-автобус ажиллуулах замаар /Жишээлбэл Нидерландад/ таниулдаг байна.
- ▶ **Засгийн газрын хүрээн дэх техникийн, сургалтын болон зохион байгуулалтын арга хэмжээ:** Сүүлийн үеийн зохих төвшний техник тоног төхөөрөмжөөр хангах, засгийн газрын нэгжүүд болон МХТ-ийн өнөөгийн системүүдийн харилцан уялдааг /жишээ нь Япон, Турк/ хангах болон МХТ-ийн найдвартай дэд бүтэц бий болгох /жишээ нь Канад/талаар хүчин чармайлт тавих зэргээр засгийн газрууд МХТ-

ийн дотоод бэрхшээлээ шийдвэрлэхийг хичээж байна. МХТ-ийн сургалт, ажилтан албан хаагчдыг сургах сургалтууд нь засгийн газрын дотоод чадавхийг нэмэгдүүлдэг. Байгууллагын хэмжээнд дээр өгүүлсэн хүчин зүйлүүдийг нийтэд нь хамарсан байдлаар зохицуулах нь дээрх хүчин чармайлтыг амжилтад хүргэх болно.

- ▶ **Стратегийн алсын хараа ба төлөвлөлт:** Бүтэлгүйтэл, МХТ-ийн салбарт хийсэн асар их хэмжээний хөрөнгө оруулалт зэрэг нь засгийн газарт санхүүгийн хохирол учруулах тул тэдгээрээс зайлсхийхэд стратегийн алсын хараа, төлөвлөлт чухал. Тэдгээр нь эрсдэлийг илрүүлж, үр дүнтэй стратеги боловсруулахад туслах бөгөөд эрсдэлийг даамжирч газар авахаас нь өмнө зайлсхийх, шийдвэрлэх боломж олгодог.
- ▶ **Хувийн нууц, аюулгүй байдлыг хангахын тулд эрх зүйн болон бодлогын өөрчлөлт хийх:** Хүний талаарх мэдээлэл, түүний үнэн байдлын талаар хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж болон бодлогод өөрчлөлт оруулах нь эдгээр салбарт шийдвэрлэгдээгүй асуудлыг тодруулахаас гадна иргэдэд томоохон баталгаа болж өгдөг.
- ▶ **МХТ-ийг уламжлалт арга хэрэгслүүдтэй хослох:** МХТ-ийн арга хэрэгслийг төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд ашигладаг уламжлалт хэрэгсэлтэй хослуулж хамтад / “Арга хэрэгсэл, үйл ажиллагааг хэрхэн сонгох вэ ?” хэсгийг үзнэ үү/ нь хэрэглэх явдал сонирхол татсан сэдэв юм. Засгийн газар уламжлалт үйл ажиллагаа явуулж, тэр ч байтугай МХТ хэрэглэж дэмжих явцдаа түүнийг туршиж МХТ-ийн шинэ боломжуудыг ашиглаж болно. Энэ байдлаар засгийн газрууд МХТ-ийн бэрхшээлд автагддаггүй. Энэхүү хоёрдмол, хос шинжтэй стратегийг хэрэглэхдээ засгийн газрууд хөрөнгө мөнгийг зохистой байдлаар зарцуулахад зориуд анхаарах шаардлагатай.

Бүхэлд нь аваад үзвэл МХТ-ийн дутагдалтай талыг засгийн газрууд сааруулж болно. Гэвч цахим ялгаа болон онцлог байдал гэх мэтээс үүдсэн дутагдал нэг хэсэгтээ бодитой оршсон хэвээр байх болно. Тийм учраас засгийн газрууд төр, иргэний харилцааг бэхжүүлэхэд МХТ хэрэглэж буй байдалдаа дутагдал бий гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм.

Зарчмуудыг амьдралд хэрэгжүүлэх нь

МХТ болон арга хэрэгслүүдийг хэрэглэх хүрээг тодорхойлж, стратегийн үүднээс төлөвлөх явцад үйл ажиллагааг нь чиглүүлэх зарчим засгийн газарт шаардлагатай. Гишүүн улсуудын туршлагад тулгуурлан ЭЗХАХБ-ын төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх асуудлаарх ажлын хэсэг бодлого боловсруулах явцдаа иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог амжилтанд хүргэхэд чиглэсэн арван зарчмыг дэвшүүлэн тавьсан юм. Тэдгээр нь ЭЗХАХБ-ын гишүүн улсуудын шилдэг сайн арга ажиллагааны элементүүдийг нэгтгэсэн бөгөөд бодлогын хураангуйд тусгагдсан /онлайнд байгаа, бүрэн эхээр нь уншихыг хүсвэл дөрөвдүгээр бүлгийг үзнэ үү/.

Амжилт олохын тулд тэдгээр зарчмын шийдвэрлэх үүргийг хүлээн зөвшөөрөх төдийгүй практикт хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ ажлыг хэрхэн хийх талаар эл бүлэгт дурдах болно. Зарчмуудын талаар гарын авлагад бүхэлдээ өгүүлдэг учир та бүхэн холбогдох хэсгийг бусад бүлэгт ч унших болно.



Нэг. Тууштай чанар

Бодлого боловсруулах явц дахь мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог улс төрийн зүтгэлтнээс эхлээд удирдах албан тушаалтан, төрийн албан хаагч зэрэг бүх төвшинд удирдан тэргүүлэхээс гадна түүнд тууштай хандах шаардлагатай.

Энэ зарчмыг практикт нэвтрүүлэхэд:

- ▶ Бусад улс орны шилдэг үйл ажиллагааг жишээ татах, тусгай арга хэмжээ зохиох, амжилтанд хүрсэн санал санаачилгыг сурталчлах гэх мэтээр нээлттэй, ил тод, хариуцлагаа бүрэн ухамсарласан бодлого боловсруулах үйл явцыг дэмжихийн тулд **улс төрийн зүтгэлтний гүйцэтгэх үүргийг тэдэнд таниулах**,
- ▶ Байнгын уулзалт, анд нөхдийн хүрэн дэх ярилцлага, үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, мэдлэгийг жолоодох зэргээр **Удирдах ажилтнуудад мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх** хэрэгслүүдийг хэрэглэх,
- ▶ Сургалт зохиох, ёс зүйн хэм хэмжээ, жишиг тогтоох, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зэргээр **чиглэсэн туслалцааг төрийн албан хаагчдад үзүүлэх**. Шагнал олгох хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэт өвөрмөц санал санаачилга мөн тустай байж болно.

Хоёр. Эрх

Иргэний мэдээлэл авах, харуу мэдээлэх, бодлого боловсруулах ажиллагаанд зөвлөлдөх, идэвхтэй оролцох эрхийг хууль тогтоомжид болон бодлогод тусгах шаардлагатай. Иргэдийн эрхээ хэрэгжүүлэхэд засгийн газрын хүлээх үүргийг мөн тодорхой дурдах ёстой. Эдгээр эрхийг сахиулахад бие даасан байгууллага, тэдэнтэй төстэй субъектийн хяналт чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ зарчмыг практикт хэрэгжүүлэхэд:

- ▶ Сургалт зохиох, шилдэг сайн арга ажиллагааны тухай интернэт хуудас ажиллуулах зэргээр дэмжих буюу зөвлөгөө өгөх /төвтэй шууд харилцах утасны үйлчилгээ нээх/ зэргээр туслалцаа үзүүлж дэмжих нь **Төрийн албан хаагчид хуулийг мэдэж, хэрэгжүүлдэг байхад** чухал зүйл юм.
- ▶ Парламентын үзлэг шалгалт гэх мэт нэгэнт хэвшсэн арга ажиллагаагаар эсвэл /омбудсмэн/ мэргэшсэн байгууллагаар хяналт явуулах зэргээр **Хяналтын бие даасан байгууллагуудыг бэхжүүлэх** болно.
- ▶ Телевизийн зар сурталчилгаа, товхимол, шоу-үзвэр г.м мэдээллийн хэрэгсэл ашиглах, дунд сургууль г.м боловсролын болон иргэний нийгмийн байгууллагатай түншлэх замаар **олон нийтийн ойлголтыг дээшлүүлж** болно. /Эхний бүлгээс “Ямар өртөгтэй байх вэ ? болон “Хүрээг тодорхойлох нь” хэмээх удаах бүлгээс “Ямар ерөнхий чадавхийг бий болгох вэ ? хэсгийг үзнэ үү/

Гурав. Тодорхой байдал

Бодлого боловсруулах явц дахь мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны зорилго, тохиолдох бэрхшээлийг бүр эхнээс нь тодорхой дурдах шаардлагатай. Оролцоогоор хангах гэх мэт иргэдийн болон гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээх гэх мэт засгийн газрын үүрэг хариуцлагыг нийтэд тодорхой байх нь чухал. Энэ зарчмыг практикт хэрэгжүүлэхэд:

- ▶ Бодлогын асуудлаарх иргэдийн тэргүүлэх зорилтыг мэдрэх, бодлогын өөр хувилбаруудыг хамтран боловсруулах зэргээр зорилгоо анхнаас нь боломжийнхоо хэрээр тодорхойлж, түгээн дамжуулах, олон нийтийн судалгааны дүнг хэвлэн нийтлэх гэх мэтээр хүлээх үүрэг, олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэй харьцуулбал олон нийтийн оролцоонд харьцангуй ямар ач холбогдол өгөх зэргийг тодорхой болгох замаар **эндүү ташаа төсөөлөл төрүүлэхээс зайлсхийнэ.**
- ▶ Шаардлагатай үндсэн мэдээллийг хаанаас /засгийн газрын болон засгийн газрын бус эх сурвалж г.м/ олох, санал гомдол хэрхэн тавих/ олон нийтийн хэлэлцүүлгийн үед амаар болон бичгээр эсвэл э-шуудан илгээх г.м/, ямар журам баримталдаг/ эцсийн хугацаа, холбоо барих гол хүн г.м/, шийдвэр гаргахад дараачийн ямар алхам хийгдэх талаар **бүрэн гүйцэд мэдээллээр хангана.**

Хоёрдугаар бүлгийн “Стратегийн үүднээс төлөвлөж, гүйцэтгэ” хэсгийг болон Гуравдугаар бүлгийн “Гуравдугаар зөвлөгөө”-г мөн үзнэ үү

Дөрөв. Хугацаа

Олон нийттэй зөвлөлдөх, тэднийг идэвхтэй оролцуулах явдлыг бодлого боловсруулах явцад аль болох эртхэн хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ нь бодлогын шийдлийг олон хувилбартай байлгах бөгөөд хэрэгжилтийг амжилттай болгоно. Зөвлөгөөн, идэвхтэй оролцоог амжилттай явуулахын тулд хангалттай хугацаа олгох хэрэгтэй. Бодлогын бүх шатанд мэдээлэл шаардлагатай.

Энэ зарчмыг практикт хэрэгжүүлэхэд:

- ▶ Бодлого боловсруулах үйл явцын бүх шатанд иргэдийг оролцуулахад шаардлагатай мэдээллийг үнэлэх, зохистой хэрэгслийг тодорхойлох, бодлогын үйл явцад олон нийтийн мэдээлэл, оролцоог аль болох **эрт эхлэнэ.**
- ▶ Шийдвэр гаргах явцад олон нийтийн мэдээлэл, зөвлөгөөнд хангалттай хугацаа зориулах, тэрхүү зөвлөлдөх хугацааг засгийн газрын шийдвэр гаргах хуанли /хууль тогтоомж боловсруулах, батлах буюу олон улсын хэлэлцээнд оролцох хугацаа/-тай уялдуулахад **бодитой хандах ёстой.** Гуравдугаар бүлгийн “Дөрөвдүгээр зөвлөгөөг үзнэ үү.

Тав.Бодит байдал

Бодлого боловсруулах явцад засгийн газраас өгч буй мэдээлэл бодитой, бүрэн гүйцэд бөгөөд хүртээмжтэй байх ёстой. Мэдээлэл авах, оролцох эрхээ эдлэхэд нь нийт иргэдэд жигд хандах учиртай. Энэ зарчмыг практикт хэрэгжүүлэхэд:

- ▶ Олон нийтийн мэдээлэл /төрийн мэргэжлийн албан хаагчийн өгч буй/ болон бүтээгдэхүүн /жишээ нь заавар журмыг төлөвлөх/-д, аппаратын дотоодын хяналт шалтгалтаар жишгийг мөрдөн сахиулах, олон нийтийн зөвлөгөөн зохион байгуулах, заавар чиглэл гаргах, төрийн албан хаагчдыг сургаж боловсруулах/ёс зүйн хэм хэмжээ/ болон бусад хувилбарыг авч үзэх арга ажиллагааг тодорхой болгох /биеэ даасан ахлагч томилох/ **жишиг тогтоох шаардлагатай.**
- ▶ Мэдээлэл авах /товхимол, телевизийн зар сурталчилгаа, интернэт гэх мэт/ болон зөвлөлдөхөд/ бичгээр болон амаар/ олон суваг ашиглах, мэдээлэл өгөх, зөвлөлдөх, оролцох арга ажиллагааг иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх /ажлын бус цагаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах г.м/ **нөхцөлийг хангах хэрэгтэй.**
- ▶ Иргэдийн мэдээлэл авах, зөвлөлдөх, оролцох эрхээ баталгаажуулах боломжтой хувилбаруудыг сурталчлан таниулж, танилцуулах замаар **давж заалдах эрхийг тогтоож, баталгаажуулна.** Үүнд жишээ нь санал гомдол гаргах журам, шүүхийн шалгалт, омбудсмэний оролцоо гэх мэт хамрагдана.

“Хүрээг тодорхойлох хэмээх хоёрдугаар бүлгээс “Мэдээллийн ямар элементүүд хэрэглэх вэ ?” хэсгийг болон хоёр, гуравдугаар зөвлөгөөг үзнэ үү.

Зургаа. Хөрөнгө мөнгө

Бодлого боловсруулах явц дахь иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоог үр дүнтэй болгохын тулд тэргүүлэх зорилтуудыг тодорхойлж, хангалттай хөрөнгө мөнгийг хуваарилах ёстой. Засгийн газрын албан хаагчид зохих дадлага туршлага эзэмшсэн, шаардлагатай заавар чиглэлээр хангагдаж, сургалтад хамрагдсан байх хэрэгтэй. Тэдний хүч чармайлтыг хөхүүлэн дэмжих байгууллагын соёл үлэмж чухал. Энэ зарчмыг практикт хэрэгжүүлэхэд:

- ▶ **Тэргүүлэх зорилтыг дэвшүүлж,** арга хэмжээг, түүний дотор хүн /дотоодын ажилтнуудад зориулсан цаг, гадаад мэргэжилтнүүд/-ий болон санхүү /ном хэвлэлийн өртөг зардал/, техник /теле-конференц/-ийн бололцоо боломжийг хуваарилах хэрэгтэй.
- ▶ Чиглэсэн зорилго бүхий сургалтын хөтөлбөр /товхимол бэлтгэх, олон нийтийн дугуй ширээний уулзалтыг хөтлөн явуулах г.м/-үүд болон практик ач холбогдолтой гарын авлага гаргах, харилцан мэдээлэл солилцох арга хэмжээ зохион байгуулах зэргээр **чадваржуулах хэрэгтэй.**
- ▶ Захиргааны зүгээс хэвлэн нийтлэх замаар /хүснэгт хэлбэрээр/ буюу /ахлах тушаалын ажилтан, улс төрчид шууд оролцох/ үлгэрлэн дуурайлгах зэргээр **төр, иргэдийн харилцааны үнэт зүйлийг хөгжүүлэх хэрэгтэй.**

“Хүрээг тодорхойлох” бүлгийн “Ерөнхий ямар чадавхийг хөгжүүлэх вэ ?” хэсгийг болон “ Стратегийн үүднээс төлөвлөж, ажилла” бүлгийн “ Боломж бололцоо”-ны тухай хэсгүүдийг үзнэ үү.

Долоо. Зохицуулалт

Иргэдэд мэдээлэх санаачилга, тэднээс хариу мэдээлэл авах, зөвлөлдөх эрэлт хэрэгцээ засгийн газраас эхэлж гардаг байх ёстой. Энэ нь мэдлэгийг удирдан жолоодох явдлыг дээшлүүлж, нэгдмэл бодлого явуулж, давхардал үүсгэхээс зайлсхийх боломж олгоно. Тэрчлэн хэт их давхардал, иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын хоорондох тааруухан зөвлөгөөний сөрөг үр дагавар болох “зөвлөгөөнөөс залхах” эрсдэлийг багасгадаг. Зохицуулалт нь засгийн газрын байгууллагуудын шинийг эрэлхийлэгч, бүтээлч хандлагыг бууруулах ёсгүй. Энэ зарчмыг практикт хэрэгжүүлэхэд:

- ▶ Тухайн үед засгийн газрын хүрээнд мэдээлэл, зөвлөгөөн, оролцооны талаар ямар үйл ажиллагаа явагдаж байгааг иргэд болон төрийн албан хаагчдад төрөлжсөн интернэт-хуудас зэрэг хэрэгсэлээр танилцуулах, иргэдэд ижил төвшинд харилцах боломжийг зааварчилга гаргах, сургалт зохион байгуулах зэргээр засгийн газрын байгууллагууд хангаж **зохицуулах чадварийг бэхжүүлэх** хэрэгтэй.
- ▶ Захиргааны хүрээнд мэдээлэл, зөвлөгөөн, оролцоог хариуцсан ажилтнуудын **сүлжээ үүсгэх хэрэгтэй**. Чингэхийн үндэс нь тэдний уулзалтыг тогтмол хугацаанд зохиоход оршино. Сүлжээ нь /салбарын мэргэжилтнүүдийн нэр, туршлагыг өгүүлсэн онлайн сан байгуулах/, туршлагаа хуваалцах/ орон нутгийн засаг захиргааны болон бусад орны/ ажилтнуудын дадлага чадварыг нэмэгдүүлнэ.
- ▶ Шилдэг практик ажиллагааны үлгэр жишээг тодруулан түгээх /бодлогын асуудлаарх төв засгийн газрын байгууллага, тогтмол хэвлэлийн мэдээ, вэб хуудас зэргээр дамжуулан/-ийн сацуу шинийг эрэлхийлсэн практик ажиллагааг урамшуулах /жишээ нь жил тутмын шагнал олгох/ замаар **шинэлэг байдлыг хөхүүлэн дэмжиж** болно.

“Хүрээг тодорхойлох нь” хэмээх хоёрдугаар бүлгийн “Мэдээллийн ямар элемент хэрэглэх вэ?” хэсгийг үзнэ үү.

Найм. Хариуцлага

Хариу мэдээлэл, олон нийтийн зөвлөгөөн болон идэвхтэй оролцооны аль нэг хэлбэрээр иргэдээс хүлээн авсан тэдний оролцоог хэрхэн ашигласан тухайгаа засгийн газар эргэж тайлагнах үүрэгтэй. Энэхүү үүрэг хариуцлагыг дээшлүүлэхийн тулд засгийн газар нээлттэй, ил тод бодлого боловсруулах явцдаа гаднын хяналт, шалгалтад уриалгахан хандах шаардлагатай. Энэ зарчмыг практикт хэрэгжүүлэхэд:

- ▶ Шийдвэр гаргах, иргэд өөрсдийн санал бодлыг хэдийд хэрхэн тусгах /мэдээллийн товхимол, олон нийтийн хэлэлцүүлэг зэргээр/-ыг болон тэдний оролцоог хэрхэн үнэлж, эцсийн шийдвэрт тусгах /нэгдсэн тайлан буюу төгсгөлийн хуралдаан хийх зэргээр/ цаг хугацааг **тодорхой дурдах хэрэгтэй**.
- ▶ **Тодорхой үүрэг даалгаврыг** холбогдох нэгжид буюу төрийн албан хаагчдад /мэдээлэл бэлтгэх буюу тайлан тавих/ ногдуулах бөгөөд энэ тухайгаа нийтэд тодорхой мэдээлэх /харилцах э-шуудангийн хаягийг интернэт –хуудсанд дурдах/ хэрэгтэй.

“Арга хэрэгслийг сонгох, хэрэглэх тухай” хэмээх хоёрдугаар бүлгийн “ Хүрээг тодорхойлох нь”, “Үнэлгээнд ямар арга хэрэгсэл хэрэглэх вэ ?” гэдэг хэсгүүдийг болон гуравдугаар бүлгийн 9 дүгээр зөвлөгөөг үзнэ үү.

Ес. Үнэлгээ

Бодлого боловсруулах үйл явцыг шинэ эрэлт шаардлага, нөхцөл байдлын өөрчлөлтөд тохируулахад үнэлгээ чухал ач холбогдолтой. Иргэдтэй харилцаагаа бэхжүүлэх талаар хэрхэн ажиллаж байгаа байдалдаа үнэлгээ өгөхийн тулд засгийн газарт арга хэрэгсэл, мэдээлэл, чадавхи хэрэгтэй. Энэ зарчмыг практикт хэрэгжүүлэхэд:

- ▶ Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны талаарх санал санаачилгуудын үндсэн хэсгийн талаарх **мэдээллийг цуглуулах** /хүлээн авсан санал гомдол г.м/ мэдээллийг хэрхэн цуглуулах талаар бүр анхнаас нь төлөвлөх/нийтийн санал асуулгыг тогтмол явуулах буюу олон нийтийн хэлэлцүүлэгт оролцогчдын тоог бүртгэх/ хэрэгтэй.
- ▶ Үнэлгээний **тохиромжтой арга хэрэгслийг бий болгох**, жишээлбэл үүнийг зөвлөгөөн, үнэлгээ, аудитын мэргэжилтнүүдээс бүрдсэн салбар дундын ажлын хэсэг байгуулах замаар хийж болно. Энэ арга хэрэгслийг хөхүүлэн дэмжих хэрэгтэй.
- ▶ Онцлог арга хэмжээний болон төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр засгийн газраас тавьж буй хүчин чармайлтыг үнэлэх **үнэлгээ** /асуулгын хуудас тараах зэргээр/-нд **иргэдийг оролцуулах** /шалгалтын хэсэг гэх мэтээр/ **хэрэгтэй**.

“Хүрээг тодорхойлох нь” бүлгийн “Үнэлгээний ямар элемент хэрэглэх вэ?” хэсэг, “Стратегийн үүднээс төлөвлөж, ажилла” бүлгийн “Үнэлэх, өөрчлөн төлөвлөх ажлыг хэрхэн төлөвлөх вэ?” хэсэг, “Арга хэрэгслийг сонгож хэрэглэ” бүлгийн “Үнэлгээнд ямар арга хэрэгсэл ашиглах вэ?” хэсэг, МХТ-ийн давуу тал” хэмээх гуравдугаар бүлгийн “МХТ хэрэглэн хэрхэн үнэлэх вэ?” хэсгийг үзнэ үү.

Арав. Идэвхтэй иргэн

Идэвхтэй иргэд, эрч хүчтэй иргэний нийгэм засгийн газарт ашигтай. Учир нь тэд иргэдийн мэдээлэл, оролцоог хэрэгжүүлэх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, иргэний боловсрол, дадлагыг бэхжүүлэх тодорхой үйл ажиллагаа явуулдаг. Энэ зарчмыг практикт хэрэгжүүлэхэд:

- ▶ Насанд хүрэгчид болон залуучуудын **иргэний боловсролд хөрөнгө оруулах** /жишээ нь сургуулиар дамжуулах буюу, тусгай арга хэмжээ зохиох, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх кампани өрнүүлэх/, эдгээр чиглэлээр бусдын дэвшүүлсэн санал санаачилгыг дэмжих /иргэний нийгмийн байгууллагуудын арга хэмжээнүүдийг ивээн тэтгэх/ хэрэгтэй.
- ▶ Эрх зүйн зохистой орчин бүрдүүлэх/ хүний эрхийн холбоо, татварын урамшил г.м/ тусламж үзүүлэх /тэтгэлэг олгох, сургалт зохиох/, түншлэл тогтоох/ хамтарсан төсөл хэрэгжүүлэх, үйлчилгээ үзүүлэх үүргийг бусдад шилжүүлэх/, жишээ нь засгийн газар болон иргэний нийгмийн хамтран тодорхойлсон хүрээнд харилцан яриа хийх боломжийг байнга бүрдүүлэх зэргээр **иргэний нийгмийг бэхжүүлэх хэрэгтэй**.

Эхний бүлгийн “Төр, иргэний харилцааг яагаад бэхжүүлэх хэрэгтэй вэ?” хэсгийг болон удаах бүлгийн “Арга хэрэгслийг сонгож хэрэглэ” хэсгийг үзнэ үү.

III БҮЛЭГ

Ямар зөвлөгөөг дагаж мөрдөх вэ?

- ✓ Ажилд тань тустай арван зөвлөгөө

Ажилд тань тустай арван зөвлөгөө

Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны чиглэлээр ажиллахад та бэлэн байна уу? Түр хүлээгээрэй. Энэ бүлэгт төр, иргэний харилцааг бэхжүүлэхэд санаж явууштай арван зөвлөгөөтэй та танилцах болно. Энэ чиглэлд хуримтлагдсан практик туршлагад тулгуурласан эдгээр зөвлөгөө бодлого боловсруулах явцад иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог дэмжиж ажиллахад танд тус дөхөм үзүүлэх болно.



Нэгдүгээр зөвлөгөө - Нухацтай ханд

Олон тооны товхимол гаргах нь төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд хангалтгүй. Засгийн газраас хэвлүүлсэн баримт бичиг, бичүүлсэн дүрс бичлэгийн хуурцагны тоогоор төр, иргэдийн харилцаа ямар төвшинд байгааг харуулах боломжгүй. Эдгээр тоо нь чухал үзүүлэлт мөн боловч дурдсан баримт бичиг, бусад материал ямар мэдээлэл агуулсан, тэдгээрийг хэрхэн ашигласан бэ? олон нийтэд хүрсэн үү? эсвэл хэн нэгний ширээний шургуулганд дарагдсан уу? Олон нийт уг мэдээллийг ашиглаж байна уу? Эсвэл хэрэглэхээс зайлсхийж байна уу? Иргэдийн оролцоог засгийн газар хүлээн зөвшөөрч, үнэлсэн үү? эсвэл чихгүй толгой шиг өнгөрүүлсэн үү? Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ иргэдтэй тогтоосон харилцааг нь бэхжүүлсэн үү?, ямар ч үр дүнгүй болсон уу? Эсвэл бүр доройтуулсан уу? гэх мэт нь хамгийн чухал юм.

Амжилттай ажиллахын тулд засгийн газар мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны чиглэлээр явуулах өөрийн үйл ажиллагааг урьдаас төлөвлөх ёстой. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх гэдэг бол сонирхолтой бөгөөд, үр ашигтайгаас гадна ихээхэн хянуур хандах шаардлагатай зорилт юм. Энэ бол зорилгоо тодорхойлохоос гадна түүнд хүрэхийн тулд хэрхэн ажиллах талаар төлөвлөх, улмаар хэрэгжүүлэх төдийгүй тавьсан зорилгодоо хүрч чадсан эсэхэд үнэлгээ өгөх асуудал. Түүнээс гадна энэ бол засгийн газрын үйл ажиллагааг нээлттэй болгох, иргэдэд хүрч ажиллах, ардчиллыг хөхүүлэн дэмжихийн төлөө тэдэнтэй харилцаагаа бататгаж бэхжүүлэх явдал юм. Олон нийтэд хүрч ажиллах үндсэн зорилгод нь нийцсэн тохиолдолд олон тооны товхимол ашиглахыг ч үнэхээр бас түүнд хамруулж болох юм.

Хоёрдугаар зөвлөгөө - Иргэдийн санаа бодлоос эхэл

Иргэдийн санаа бодлыг юуны түрүүнд анхаарч, түүнд хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Чухамдаа яагаад иргэд мэдээлэл авах, өөрсдийн оролцоог нэмэрлэхийг тэд хичээх ёстой юм бэ? Үнэн хэрэг дээрээ нэлээд тооны хүмүүс засгийн газраас явуулж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авах, зөвлөлдөх, түүнд оролцох хүсэлгүй, тэр ч байтугай цааргалдаг. Цаг заваа дэмий үрэх шаардлагагүй гэж боддог эсвэл засгийн газар, парламент, бусад хүнд найддаг ч байж магадгүй. Нөгөө талаар, засгийн газраас тараасан мэдээлэлд үнэмшдэггүй, яагаад өөрсөдтэй нь ойртож ажиллахыг хүсч байгаа учрыг ойлгодоггүй байж болзошгүй.

Засгийн газар, түүний албан хаагчид иргэдийн санаа бодлыг хайхрахгүй бол тэдний хандлагын талаар бодит бус төсөөлөлд хялбархан автагдаж мэднэ. Чингэснээр урам хугарахаар уршигт хүрсэн тохиолдол цөөнгүй. Төрийн албан хаагч улмаар иргэдийг үл тоомсорлох байдал гаргахад хүрнэ. Иймэрхүү үл тоомсорлох хандлага тэдний харилцааг огт сайжруулдаггүй харин ч хурцатгана.

Иргэдийн санаа бодолд анхааралтай ханддаг засгийн газар юуны өмнө тэдний цагийг үнэлж үздэг. Засгийн газар иргэдийн анхаарлыг татаж, хамтын ажиллагаанд иргэдийг уриалахын тулд өөрийн үйл ажиллагааг тэдний эрэлт шаардлагад нийцүүлэх хэрэгтэй болдог. Энэ нь олон нийтэд нийцтэй үг хэллэг, хэлбэр маягийг сонгох төдийгүй, хамтын ажиллагааг сэтгэл татам сонирхолтой, нөхөрсөг, шударга болгож үл тоомсорлосон байдлаас ангижруулна гэсэн үг юм. Засгийн газар бодлого боловсруулахдаа иргэдийг оролцуулсанаараа тэдэнд найдвар төрүүлдэг бөгөөд иргэдийн оролцоо бол үнэ цэнэтэй зүйл, бодлого боловсруулахдаа түүнийг харгалзана гэдгээ тэдэнд харуулах ёстой. Тэгэж эс чадвал иргэд засгийн газрын хүсэлтээр өөрсдийн үнэтэй цаг завьг үрэх гэж цаашдаа хүсэхгүй болно.

Гуравдугаар зөвлөгөө - Амласнаа биелүүл

Дүр эсгэж, мэхлэх нь аюулд хүргэнэ. Амласнаа биелүүлж, итгэлийг бэхжүүлэх нь чухал. Төр иргэдтэй харилцаагаа бэхжүүлэхийг хэрэв хүсвэл амласнаа биелүүлэх хэрэгтэй. Бодлого боловсруулахад иргэдийг мэдээллээр бүрэн хангаж, тэднийг идэвхтэй оролцуулахыг хүсч байгаа дүр үзүүлээд хэрэг дээрээ тэгэж эс ажиллавал иргэдийг төөрөгдөлд хүргэх төдийгүй хожим тэдэнд дахин хандахад бүр ч их бэрхшээл үүсгэнэ. Дүр эсгэх гэдэг нь аливаа ажлыг урсгалд нь орших буюу иргэдтэй зөвлөлдсөн гэж хоосон ярих, иргэдийн нээлттэй, төлөөллийн журмаар оролцуулна гэх боловч хэрэг дээрээ гагцхүү өөрийн санаа бодлыг хуваалцдаг цөөн тооны хүнийг урих, үнэн бодитой мэдээллийг жигд тэнцүү хүлээн авах иргэний эрхийг хүндэтгэж буй харагдавч ганц талыг барьсан, дутуу хагас мэдээллийг цөөн хэдэн хүнд хүргэхийн нэр юм.

Засгийн газар энд дурдагдсан арга хэрэгслүүдийг төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхээс ондоо зорилгод жишээлбэл эсэргүүцлийг намжаах, шүүмжлэлээс зайлсхийх, байдлыг аргацааж цаг хожих, олон нийтэд таагүй санагдсан шийдвэрийнхээ төлөө хүлээх зэмлэлийг бусдад тохох, олон улсын даралт шахалтад өнгөц засал төдийгөөр хариу барихад ч ашиглаж болно. Гэвч тэр болгон нь өөрийн нэр хүнд болон ардчилалд уршиг тарих байдлаар төр, иргэдийн харилцааг доройтуулдаг. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх нь ямар нэгэн зүйлийг зарж борлуулах бодлого төдий биш. Төр, иргэдийн харилцаанд засгийн газар худалдах, иргэд худалдан авах зүйл гэж огт байхгүй. Бодлого боловсруулах үйл явцад иргэдийг хамран оролцуулсаны үр дүнд засгийн газар энэхүү гарын авлагын хоёрдугаар бүлэгт дурдсан зааварчилга болон зарчмуудыг хэлбэрийн талаас нь бус харин агуулгын хувьд нь баримталж ажиллах шаардлага гарна.

Хэдий сайныг хүсч эрмэлзсэн ч засгийн газар биелүүлээгүй амлалтандаа ороогдож иргэдийнхээ урмыг хугалж болзошгүй. Энэ нь хөрөнгө мөнгө дутагдах, тавьсан зорилго түүний ач холбогдолыг нь удирдлага бүрэн гүйцэд ойлгож үнэлэхгүй байх мэтээс үүдэж болох бөгөөд иргэдийн оролцоог бодлого боловсруулахдаа тусгах учиртай төрийн албан хаагчид эл тохиолдолд төвөгтэй байдалд ордог. Тийм учраас аливаа арга хэмжээг төлөвлөх, шаардлагатай хөрөнгө мөнгийг төсөвлөх болон хэрэгжүүлэхэд удирдлагын тууштай оролцоо амжилтын нэг гол нөхцөл юм.

Дөрөвдүгээр зөвлөгөө - Хугацааг баримтал

Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэн бататгаж, улмаар үр дүнг нь үзэхэд цаг хугацаа шаардлагатай. Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог бүрдүүлэхэд тодорхой хугацаа хэрэгтэй учир энэ бол агшин зуур бүтэх ажил биш. Шуудхан хэлэхэд ганц нэг бодлогын асуудлаар иргэдэд хандаж эхлэнгүүт тэд төр, засгийн газарт дорхноо асар их итгэл үзүүлнэ гэж байхгүй. Тухайн асуудалтай танилцаж, санал бодлоо илэрхийлэхэд ч зохих хугацаа шаардагддаг учир агшин зуурын дотор л дорвитой хувь нэмэр оруулах боломж иргэдэд ч байдаггүй. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хийгээд үр дүнд хүргэхэд цаг хугацаа хэрэгтэй.

Иргэдтэй ажилласны дүнд гарах шууд ач холбогдол нь тэднийг чухам хэдийд, ямар шатанд оролцуулахаас мөн хамаарна. Бодлого боловсруулах үйл явцын төгсгөлд, өөрөөр хэлбэл шийдвэр гарсаны дараагаар иргэдийг оролцуулбал бодлого боловсруулах үйл явцад тэдний үзүүлэх нөлөө бага байх болно. Иргэдийг хэт хожуу оролцуулбал сөрөг үр дагаварт хүргэж болно. Бодлого боловсруулах үйл явцын эхний шатанд тухайлбал бэлтгэх, тандаж судлах үед иргэдийг татаж оролцуулах нь ихээхэн үр дүнтэй байдаг.

Тавдугаар зөвлөгөө - Бүтээлчээр ханд

Таны өмнө тулгарсан сорилт бэрхшээлд бэлэн шийдэл гэж байдаггүй. Төр, иргэдийн харилцаа нь улс орон бүрд харилцан адилгүй. Тийм учраас засгийн газрууд өөрсдийн орны болон тулгарч буй сорилт бэрхшээлүүдийн өвөрмөц онцлогод тохирсон үйл ажиллагаа явуулах хэрэгтэй. Энэхүү гарын авлагад дурдсан зүйлүүд болон зарим тодорхой жишээ танд гүн гүнзгий ойлголт, урам зоригтойгоор өөрийн байр суурь, хандлагыг зөв зүйтэй тодорхойлоход тус дөхөм үзүүлэх болно. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэхэд хамгийн гол сургамж нь бусдаас суралцах, шинэ шинэ боломжийг хайж олох, чиг хандлагыг зөв тооцох, өөрийн бүтээлч хандлага, шинийг эрэлхийлэх эрмэлзэлд тулгуурлах явдал юм.

Зорилгоо, хэнд хандах, ямар арга хэрэгсэл хэрэглэхээ тодорхойл гэж хэлэхэд хялбар. Азтай ч бай, харамсалтай ч бай үүнд гол учир байгаа юм биш. Төр, иргэдийн харилцаа гэдэг бол өөрийн динамик бүхий амьд үйл явц учир цаг хугацааны явцад уг харилцааны нөхцөл байдал, газар орон, асуудал, бодлого боловсруулах хувилбарууд, түүнд өртөх олон нийт, хувь хүмүүс ч гэсэн өөрчлөгдөн хувирч байдаг. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ түүний үндсэн бодлогынхоо чиг шугамаас хазайсан, олон нийтийн шинэ бүлэг давхаргыг хамралгүй орхигдуулсон, үеэ өнгөрүүлсэн хуучин арга хэрэгсэл хэрэглэсэн гэх мэтээр иргэдэд хүрч чадахгүй бол ихээхэн сэтгэл түгшээж гайхашруулах болно.

МХТ гэх зэрэг шинэлэг арга хэрэгслүүд нь түүхэнд сонин хэвлэл, радио телевизийн гүйцэтгэсний нэгэн адил шинэ бөгөөд содон боломжуудыг нээж байна. Хэвлэлийн хөгжлийн урьд өмнөх шат бүрийн нэг адил технологийн шинэ дэвшил нь хэвлэл мэдээллийн нэгэнт тогтсон хэрэгслийг халах бус харин түүнийг баяжуулдаг байна. Түүхийн энэхүү сургамжийг үл тоомсорлон бүх хүч чармайлтаа гагцхүү МХТ-д чиглүүлэхийг засгийн газруудад зөвлөвөл буруу болно. Үр дүнтэй ажиллахын тулд МХТ-ийг уламжлалт хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх хэрэгтэй. Тэрчлэн МХТ-ийг нийтэд хүртээмжтэй болгох зэргээр түүнийг дагалдсан бэрхшээлийг шийдвэрлэх шаардлагатай.

Зорилго, хамрах хүрэх, арга хэрэгслүүдийг зэрэг нэг мөр тодорхойлох боломжгүй. Тэдгээр нь харилцааны хөгжилд тулгуурладаг бөгөөд засгийн газар, иргэн, улс оронд тулгарсан сорилт бэрхшээлээс хамаарч байдаг. Тийм болохоор засгийн газрууд нь төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх зорилт, хэрэгсэл, хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн нөхцөл байдалдаа нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэх хэрэгтэй.

Харилцаа бол амьд үйл явц учир түүнийг бэхжүүлэх үйл ажиллагаа ч нэгэн адил байх учиртай.

Зургадугаар зөвлөгөө - Ашиг сонирхолуудыг тэнцүүл

Ашиг сонирхолуудыг тэнцвэржүүлэх, улс төрийн сорилтыг даван туулах хэрэгтэй. Иргэдийн зөвлөгөөн, идэвхтэй оролцооны дүнд төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх явцдаа засгийн газар олон хүний оролцоог хүлээн авдаг бөгөөд тэдгээрийг бодлого боловсруулах ажиллагааг сайжруулахад ашиглах бололцоотой. Гэтэл засгийн газар сөргөлдөгч талуудаас өөр хоорондоо зөрчилдсөн оролцоог хүлээн авбал хэрхэх вэ? Сонирхолын бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагууд бодлогын тодорхой хувилбарыг таашааж, хүн амын олонх тэдний эсрэг байгаа нь нийтийн санал асуулгаар харагдаж болох юм. Засгийн газар зохион байгуулалт бүхий сонирхолын бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжилтэнүүдийн оролцоонд хэрэв тулгуурлавал тодорхой хэсгийн ашиг сонирхолд л үйлчлэх болно. Гэтэл олон нийтийн санаа бодолд түшиглэвэл хүн амын чухал хэсгийн саналыг эс хайрах буюу бусад салбарын бодлоготой зөрчилдөж болно. Олон нийтийн аль хэсгийг дагавал зохих вэ? Төр, засгийн газрыг бодлого боловсруулж шийдвэр гаргуулахын тулд сонгодог. Бодлого боловсруулахдаа иргэдийн оролцоог нээлттэй байлгах замаар иргэд болон хүн амын аль хэсгийн санаа бодлыг дагах уу эсвэл өөрийн сонгосон хувилбарыг тууштай баримталж олон нийтийг манлайлах уу? гэдгийг засгийн газар шийдвэрлэх болно. Эдгээрийн алийг сонгох вэ? Эл сонголтыг хэрхэн хийх вэ?

Засгийн газар шийдвэр гаргах, манлайлах, нийтийн оролцоонд нээлттэй байхын аль алиныг нэгэн зэрэг хийх шаардлагатай тулгарч болно. Мөн аль нэгэн сонирхолд авталгүй, зохион байгуулалттай бүлгүүдийн сонирхолыг харгалзсан ерөнхий байр суурь баримтлах, сонирхолуудыг тэнцвэржүүлэхээр бодлогын уламжлал, шинэчлэлийг хослуулах хэрэгтэй байж болно. Энэ нь ямар боловч засгийн газрын эрхлэх ажил. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх нь эдгээр сонголтыг хийх боломжийг бүрдүүлдэг. Харин засгийн газар ямар шийдвэр гаргах, түүний үр дүн ямар байхыг шийддэггүй. Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоо нь олон төрлийн ашиг сонирхолыг аль өргөнөөр харгалзан үзэхэд болон нийтийн зөвшилд хүргэдэг боловч олон төрлийн санал бодлыг илрүүлэн, тал бүрээс нээлттэй асуулт гаргуулдаг. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх нь бодлогын асуудлыг тодруулж, тэр талаарх ойлголтыг гүнзгийрүүлэхээс гадна санал бодлоо илэрхийлэх, өөрсдийн хувь оролцоог нэмэргэх, хамтран оролцох боломжийг иргэд, сонирхогч талуудад олгодог. Энэ утгаараа нийтийн зөвшилд хүргэдэг бөгөөд олон төрлийн санал бодол, ашиг сонирхолыг сонсч тэдгээрийг тэнцвэржүүлэх, улмаар шийдвэр гаргах илүү сайн нөхцөл бүрдүүлэх арга замыг засгийн газарт олгодог.

Долдугаар зөвлөгөө -Шүүмжлэлд бэлэн бай

Шүүмжлэл болон хэлэлцүүлэг бол ардчиллын салшгүй хэсэг юм. Бодлого боловсруулах явцад иргэдтэй зөвлөлдөх хийгээд тэднийг татан оролцуулсанаар засгийн газар магтаал хүлээх нь тун ховор. Ялангуяа санаа бодлоо бусдад сонсох боломж алдаг оног олддог бол иргэд анхны боломжийг уур бухимдал, сэтгэл зовнилоо илэрхийлэхэд зориулж эсвэл засгийн газрын санал болгосон хувилбарыг дэмжихгүй байж болох юм. Засгийн газарт ажилладаг идеалист хүмүүс үүнд ихээхэн урам хугарч болно. Засгийн газрын бодлогыг хамгийн зөв зүйтэй, иргэдийн эрх ашигт сайн нийцдэг гэж боддог хүмүүс олон нийтийн зүгээс илэрхий эсэргүүцэлтэй тулгарахаараа гутарч ч магадгүй. Хэрэв иргэдээс санал бодлоо илэрхийлэхийг хүссэн бол тэднийг чингэхэд нь гайхах хэрэггүй гэдэг нь мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны алтан дүрэм билээ. Тэгэхээр тэдний санал бодол таныхтай тохирохгүй байж магадгүй гэдгийг санаж байх хэрэгтэй. Иргэдээр магтуулахад биш харин тэднийг оролцуулахад гол зорилго оршдог.

Засгийн газрын албан хаагчид хэвлэл мэдээллийн байгууллагууд, ашиг сонирхолын бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагуудын өөнтөглөгч төлөөлөгчидтэй харьцахад иргэдийн шүүмжлэлийн нэгэн адил амаргүй байдаг. Засгийн газраас олгож буй зөвлөгөөн, идэвхтэй оролцооны боломжийг сөрөг хүчний шүүмжлэгчид ашиглаж байр сууриа илэрхийлэхийг оролдож болно. Энэ нь ерөнхийдөө хувь иргэний шүүмжлэлтэй төстэй боловч хариулахад илүү төвөгтэй байдаг. Хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагуудын дуу хоолой иргэн хүнийхийг бодвол өргөн олонд хүрдэг бөгөөд тэдний шүүмжлэл санал зөрөлдөөн, илэрхий зөрчилд хүргэдэг. Засгийн газар үндэслэл муутай шүүмжлэлд ч хариу өгөлгүй орхих ёсгүй, санал бодлоо тодруулах эрхтэй. Гэвч засгийн газар иргэд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад нээлттэй, нийтэч байдлаар хандсан ч шүүмжлэл, зөрчлийн чадавхийг харгалзах шаардлагатай. Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоо нь бүтээлч хэлэлцүүлэг өрнүүлж, илүү сайн бодлого явуулах, засгийн газарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх боломж олгодог. Харин нэгэнт л ардчиллын салшгүй хэсэг юм болохоор шүүмжлэл, зөрчлөөс ангид байлгах ямар ч баталгаа өгдөггүй юм.

Наймдугаар зөвлөгөө - Ажилтнуудаа хамруул

Нээлттэй байж өөрийнхөнтэйгөө болон бусадтай ч ажиллах хэрэгтэй. Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоог Засгийн газар өөрийгөө толинд харах мэт шинжиж, бодлого боловсруулах хийгээд хэрэгжүүлэх ажлыг дотроо хэрхэн зохион байгуулж, бодлогын асуудлаарх шинэ санал санаачилгыг ажилтнууддаа мэдээлж, тэднийг оролцуулж, зохих ёсоор харгалздаг билүү? Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх хүрээг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэхдээ тэднийг оролцуулдаг билүү? гэж өөрсдөөсөө асууж байх хэрэгтэй.

Засгийн газар илүү сайн бодлого боловсруулахын тулд иргэдийг оролцуулдаг шигээ дотоод нөөц бололцоогоо бүрэн дайчлах шаардлагатай. Засгийн газарт иргэдийн нэгэн адил ажилтнуудаа оролцуулсан ч шийдвэр гаргах эрхийг өөрөө эдлэх болно. Энэ бол шийдвэр гаргахын тулд төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглана гэсэн үг. Ажилтнуудыг өргөн хүрээтэй мэдээллээр хангаж, оролцуулах нь нэмэгдэл төвөг учирна гэж зарим удирдах ажилтан болгоомжилдог. Чингэх нь эхний үед үнэхээр ажил нэмэх боловч эцсийн бүлэгт ихээхэн хөнгөвчилдөг. Засгийн газар мэдээллийг ажилтнуудтайгаа хамтран ашиглаж, тэднийг хамран оролцуулсанаар зорилгоо илүү сайн, үр бүтээлч байдлаар ханган биелүүлдэг. Засгийн газар гадна талдаа тавьсаны нэгэн адил зорилгыг дотооддоо хэрэгжүүлсэнээр нэгдмэл байдлаар ажиллах бөгөөд ил тод нээлттэй байдал, олон нийтийн оролцооны соёлыг аажмаар хэвшүүлж, төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх зорилгоо амжилттай биелүүлнэ.

Есдүгээр зөвлөгөө - Нэгдмэл бодлого явуул

Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх нь бодлого гэдгийг санах хэрэгтэй. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх нь өөрөө бодлого болохоос өөр юу ч биш бөгөөд засгийн газрын шийдвэр гаргахад болон ардчиллын үйл явцад дэмжлэг туслалцаа үзүүлдэг. Энэ нь засгийн газрын шийдвэр гаргах эрхийг юмуу парламентын хэлэлцүүлэг санал хураалт гэх мэт нэгэнт тогтсон зохион байгуулалтыг болон төлөөллийн ардчиллыг орлож буй хэрэг биш. Харин тэдгээрийг баяжуулж хэрэглэгдэх хүрээг нь өргөжүүлдэг.

Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоо бол бодлого гэдгийг ойлгох нь өөрийн учир холбогдолтой. Энэ бодлогыг ёсчлох нь хэр зүйтэйг засгийн газар мэдэхийг сонирхож болно. Харилцааг цаашид хөгжүүлэх хүрээг бий болгоход албан ёсны хууль, дүрэм, бүтцийн үндсэн бүтэц хангалттай юм шиг санагдана. Заавал зөвлөлддөг болох нь хэдийгээр түргэн шуурхай ажиллах шаардлагатай байсан ч нэлээд хэмжээгээр саатахад хүргэнэ. Мэдээлэх, зөвлөлдөх, иргэдийг оролцуулах үүргийг бууруулалгүйгээр тухайн үед ямар үйл ажиллагаа явуулах шаардлагатайг сонгох эрхийг засгийн газарт үлдээх замаар төлөвлөх болон дүрэм баримтлах, үйл ажиллагаа явуулахад илүү уян хатан арга хэрэглэж болно.

Ямар арга барил хэрэглэсэн ч тухайн бодлогыг хэрэгжүүлж буй арга нь чухал гэдгийг засгийн газар ойлгох хэрэгтэй. Учир нь засгийн газар хэнийг мэдээллээр хангаж, хэрхэн зөвлөлдсөн болон ямар байдлаар оролцуулсан гэхчлэн гаргасан шийдвэрийнхээ учир шалтгааныг тайлбарлах шаардлагатай болно. Бодлогын бусад салбарын нэгэн адил ил тод, нээлттэй байдал, хариуцлага болон хяналт энд ч бас хэрэгтэй байх болно.

Аравдугаар зөвлөгөө - Одоо гүйцэтгэ

Урьдчилан сэргийлэх нь эмчилгээнээс илүү сайн гэдгийг санах хэрэгтэй. Засгийн газарт бэрхшээл тулгарч, хариу үйлдэл хийхээс аргагүй байдал үүсэхийг хүлээлгүй нэгэнт байгаа боломж бүрийг ашиглаж идэвхтэй ажиллах хэрэгтэй. Иргэдтэй харилцаа муу байснаас үүдэн гарч болох бэрхшээлээс урьдчилан сэргийлэх нь зүйтэй. Хямралын нөхцөлд ажиллах хүртэл нь хойш тавих хэрэггүй. Засгийн газарт нэгэнт алдарсан итгэлийг буцааж сэргээх нь түүнийг тогтоон барихаас хэцүү.

Энэ гарын авлагад дурдсан арга хэрэгслүүдийг хэрэглэх туршлага багатай засгийн газрын хувьд бүх зүйлийг нэгэн зэрэг эхлэхийн оронд бага зүйлээс эхлэх нь чухал. Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоонд дасахын тулд улс төрийн шийдвэр гаргагчид, засаг захиргааны удирдагчид болон иргэдэд тодорхой хугацаа хэрэгтэй. Үүнийг аажмаар алгуур хийх хэрэгтэй. Засгийн газар эрх зүйн, бодлогын болон зохион байгуулалтын ерөнхий хүрээ бий болгож, туршлага хуримтлуулахын тулд тодорхой туршилтын үйл ажиллагаа явуулах хэрэгтэй. Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцоонд чиглэсэн ажиллагаанаас эхлэх нь хялбар байх талтай. Туршлага бүхий улс орнуудын хувьд идэвхтэй оролцоо нь шинэ эхлэл тавих, сайн ажиллагааг хэвшүүлэх талбар байж болно. Төр, иргэдийн харилцааг бэхжүүлэх бүх шатанд засгийн газар энэхүү гарын авлагад болон түүний эх үндэс болсон ЭЗХАХБ-ын тайланд дурдсан гэх мэт бусдын туршлагаас суралцах боломжтой.

Хүлээж харзнах шаардлагагүй харин эхлэх хэрэгтэй.

Хамтдаа урагшлая.

IV БҮЛЭГ

Нэмэлт мэдээллийг хаанаас авч болох вэ?

- ✓ ЭЗХАХБ-ын эх сурвалжууд
- ✓ Ерөнхий байдал ба нийтлэг мэдээлэл
- ✓ Эрх зүйн хүрээ
- ✓ Бодлогын хүрээ
- ✓ Зохион байгуулалтын хүрээ
- ✓ Үнэлгээ
- ✓ Мэдээллийн арга хэрэгслүүд
- ✓ Зөвлөгөөний арга хэрэгслүүд
- ✓ Идэвхтэй оролцооны арга хэрэгслүүд
- ✓ Үнэлгээний арга хэрэгслүүд
- ✓ МХТ-ийн арга хэрэгслүүд
- ✓ Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны МХТ-ийн арга хэрэгслүүд



Гарын авлагын энэ бүлэг цаашид **нэмэлт мэдээллийг** хаанаас авч болохыг танилцуулна. Тэдгээрийг олж харахад хялбар байлгахын тулд хэд хэдэн хэсэгт хувааж, дор бүр нь гарчиг өгсөн байгаа. Эх сурвалжууд нь ерөнхий байдлын болон дүн шинжилгээний баримт материалууд, төр иргэний харилцааг бэхжүүлэх практик ажиллагааны тодорхойлолт болон жишээнүүдээс бүрдэх болно.



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>Citizens as Partners Information, Consultation and Public Participation in Policy-making (2001)</i>	Энэ салбарт ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын явуулсан үйл ажиллагааны тодорхойлолт болон дүн шинжилгээг үзэж болох эл ном бол Гарын авлагын үндсэн материал гол тулгуур юм.	ЭЗХАХБ-ын онлайн номын худалдааны http://www.oecd.org/bookshop хаягт бий
<i>Engaging Citizens in Policy-making (2001)</i>	Улс төрчид засгийн газрын удирдах тушаалын албан хаагчдад зориулсан Puma Policy brief no.10	ЭЗХАХБ-ын олон нийтийн удирдлагын вэб хуудсанд онлайн номын худалдааны http://www.oecd.org/puma хаягт бий
<i>Citizens as Partners Information, Consultation and Public Participation in Policy-making (2001)</i>	Бодлогын сургамжийг практикт хэрэглэх болон ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын туршлагын зарим тодорхой жишээг энэ номоос үзэж болно	ЭЗХАХБ-ын онлайн номын худалдааны http://www.oecd.org/bookshop болон ЭЗХАХБ-ын олон нийтийн удирдлагын вэб хуудсанд http://www.oecd.org/puma хаягт бий
<i>Trust in Government: Ethics Measures in OECD countries (2000)</i>	ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын ёс зүйн удирдлага, зарим хандлага нааштай арга ажиллагааны тухай энэ номноос үзэж болно	ЭЗХАХБ-ын онлайн номын худалдааны http://www.oecd.org/bookshop хаягт бий
<i>Building Public Trust: Ethics measures in OECD Countries (2000)</i>	Улс төрчид засгийн газрын удирдах тушаалын албан хаагчдад зориулсан Puma Policy brief no.7	ЭЗХАХБ-ын олон нийтийн удирдлагын вэб хуудасны http://www.oecd.org/puma хаягт бий
<i>Regulatory Impact Analysis: Best Practices in OECD Countries (1997)</i>	ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын зохицуулалтын үр нөлөөний дүн шинжилгээ, түүний дотор олон нийтийн зөвлөгөөний тоймыг үзэж болно	ЭЗХАХБ-ын онлайн номын худалдааны http://www.oecd.org/bookshop хаягт бий

Ерөнхий байдал нийтлэг мэдээлэл



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>White Paper on Governance in the EU, European Commission (2001)</i>	Европт ардчиллыг хэрхэн хөгжүүлэх тухай зөвлөмжүүдийг энэ илтгэлээс үзэж болно	www.europa.eu.int/com/governance/areas/group3/index_en.htm
<i>Report by the Working Group on Consultation and Participation of civil Society, European Commission (2001)</i>	Шийдвэр гаргах явцад оролцох нөхцлийг бүрдүүлэх арга замуудыг энэ илтгэлд авч үзэх болно	www.europa.eu.int/comm/governance/areas/group3/index_en.htm
<i>The Open Sweden Campaign, Ministry of Justice of Sweden (2001)</i>	Улсын хэвшилд ил тод байдлыг нэмэгдүүлэх санаачилга	http://www.oppnasverige.gov.se/se/?24335
<i>High-Quality Services, Good Governance and a Responsible Civic Society: Guidelines of the Policy of Governance, Ministry of Finance of Finland (1998)</i>	Сайн засаглал, иргэдтэй ажиллах үндэсний бодлогын хүрээний жишээ	http://www.vn.fi/vm/english/public_management/govern.htm

Эрх зүйн хүрээ



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>Convention on Access to Information, Public Participation in Decision Making and Access to Justice in Environmental Matters, UNECE Committee on Environmental Policy(1998)</i>	Архусын гэгддэг энэ конвенц байгаль орчны салбарт иргэний эрхийн хүрээг тодорхойлж, шийдвэр гаргах шатанд хариуцлага, нээлттэй байдал бий болгоход чиглэдэг	http://www.mem.dk/aarhus-conference/issues/public-participation/ppartiker.htm
<i>Act on Openness of Government Activities-Finland,(1999)</i>	Мэдээлэл хүлээн авах үндэсний хууль тогтоомжийн жишээ	http://www.om.fi.1184.htm#alku
<i>The Freedom of Information Act-US.(1966,amended 1996)</i>	Мэдээллийн эрх чөлөөний тухай үндэсний хуульд цахим хэлбэрт баримт бичгүүдийг хамруулж шинэчилсэн жишээ	http://www.usdoj.gov/oip/foia_updates/Vol_XVII_4/page2.htm



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<p><i>Canadian Government Communications Policy(1996)</i></p>	<p>Мэдээллийн “идэвхтэй” байдлаарх үндэсний засгийн газрын бодлогын жишээ</p>	<p>http://www.tbs-sct.gc/pubs_pol/sibpubs/comm/comm1e.html</p>
<p><i>Code of Practice on Written Consultation-UK cabinet Office(2000);On line register of government consultations</i></p>	<p>Төрийн албан хаагчдад зориулсан практик гарын авлага, иргэдтэй зөвлөлдөх боломжийн талаарх тухай мэдээлэл</p>	<p>http://www.cabinet-office.gov.uk/servicefirst/index/consultation.htm</p>
<p><i>Consulting Ethnic Minority Communities:An introduction for Public Services-UK cabinet Office(2001)</i></p>	<p>Хүн амын төрөл бүрийн хэсгүүдтэй зөвлөгөөнийг амжилттай явуулах үндсэн асуудлуудын товч тойм</p>	<p>http://www.cabinet-office.gov.uk/servicefirst/index/consultation/htm</p>
<p><i>Community consultation Register; Community Consultation Protocol;A Guide to Consultation Processes for the ACT Government; Community Consultation Manual; Hands on Help for Planning Effective Consultation Strategies-Australian capital Territory(2001)</i></p>	<p>Зөвлөгөөн болон практик арга хэрэгслүүдийн талаар иргэд,төрийн албан хаагчдад зориулсан бодлогын гарын авлага</p>	<p>http://www.act.gov.au/cmdr/documents.cfm</p>
<p><i>Improving Policy Instruments through Impact Assessment-SIGMA Paper no.31,OECD(2001)</i></p>	<p>Нөлөөллийн үнэлгээ хийх явцад зөвлөлдөх тухай мэдээллийг багтаасан</p>	<p>http://www1.oecd.org/puma/sigmaweb/</p>

Зохион байгуулалтын хүрээ



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>La Commission d'Acces aux Documents Administratifs (Commission on Access to Administrative Documents)-France</i>	Мэдээлэл авах эрхээ эдлэхэд нь иргэдэд туслах, мэдээллээр хангах байгууллага	http://www.cada.fr/
<i>Acess to Information Review Task Force-Canada</i>	Зөвлөгөөнд оролцогч нийт иргэдэд засгийн газрын мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх ажлын хэсэг Иргэдийн мэдээлэл авах, хувийн нууцаа хамгаалах эрх хэрхэн хэрэгжиж буйг хянах “омбудсмэн”-ын байгууллагын жишээ	http://www.atirtf-geai.gc.ca/home-e.html
<i>Parliamentary Commissioner for Data Protection and Freedom Of Information-Hungary</i>	Дэд бүтцийн томхон төслүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх хэлэлцүүлэг, ярилцлага	http://www.obh.hu/
<i>Commission Nationale du Debate Public (National Commission on Public Debates)</i>	Зохион байгуулах үүрэгтэй засгийн газрын албан хаагчид, парламентын гишүүд, ТББ-уудын оролцоотой байнгын комисс	http://www.environnement.gouv.fr/ministere/comitesconseils/cndp-fiche-descriptive.htm

Үнэлгээ



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>An Evaluation of the Cabinet Office Guide:How to Conduct Written Consultation Exercises-UK cabinet Office(2000)</i>	Зөвлөгөөн хийгээд түүний үр нөлөөний талаар төв засгийн газрын зааврыг хэрэгжүүлсэн үнэлгээ	http://www.cabinet-office.gov.uk/servicefirst/2000/consult/code/evaluate.htm
<i>Citizens' Control of Evaluations: The Question of Formulating Alternatives-Swedish Agency for Public Management(2000)</i>	Үнэлгээний үйл явцад олон нийтийн оролцооны тойм	http://www.statskontoret.se/engelsk/index.htm

Мэдээллийн арга хэрэгслүүд



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>Global Environment Information Centre-Japan</i>	Байгаль орчны асуудлаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, засгийн газар, бизнес, ТББ-уудын хооронд хамтын ажиллагааны суурь бий болгоход чиглэсэн Мэдээллийн төв	www.geic.or.jp
<i>Citizens'Guide-Greece(annual)</i>	Засаг захиргааны дүрэм журмууд, төрийн үйлчилгээний холбогдолтой мэдээллийг хаанаас хэрхэн авах тухай 1300 гаруй хуудас бүхий заавар.Онлайн-д бас бий.	www.gspa.gr

Зөвлөгөөний арга хэрэгслүүд



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>The Citizens and the Public sector-Danish Ministry of Finance(1998)</i>	Улсын хэвшилд иргэд сэтгэл хэр хангалуун бөгөөд итгэж байгааг үнэлэхэд тандалтыг ашигласан жишээ	www.fm.dk.udgivelser/publikationer/citizens_sector_1998
<i>Public Opinion Surveys as Input to Administrative Reform-SIGMA Paper No.25,OECD(1998)</i>	Нийтийн санал сэтгэгдлийн мэдээллийг цуглуулах, нэгтгэх ажиллагааны байдал	http://www1.oecd.org/puma/sigmaweb/
<i>Guide des bonnes Pratiques pour l'ecoute des beneficiares (Guide on Good Practicein Listening to Users)-Ministry of Equipment,Transport and Housing (2001)</i>	Иргэдийн хариу мэдээллийг цуглуулах, ашиглах тухай баримтууд бүхий зааварчилга	http://www.minefi.gouv.fr/minefie/index.htm
<i>Youth Forum for Democracy-Norway</i>	Бодлого боловсруулахад залуучуудыг оролцуулах боломжийг Иргэдийн чуулган хангадаг	Odin.dep.no.bfd/engelsk/

Идэвхтэй оролцооны арга хэрэгслүүд



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>Policy Toolkit for Public Involvement in Decision-Making-Health Canada(2000)</i>	Бодлого боловсруулахад иргэдийг идэвхтэй оролцуулах талаар засгийн газрын албан хаагчдад зориулсан иж бүрэн зааварчилга	http://www.hc-sc.gc.ca/english/index.htm

Үнэлгээний арга хэрэгслүүд



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>Who the question-Makers? A Participatory Evaluation Handbook-OESP/ UNDP(1997)</i>	Үнэлгээ өгөхөд иргэдийг оролцуулах асуудлаарх практик зааварчилга болон сургалтын загвар	http://www.undp.org/eo/documents/who.htm
<i>Assessment of Metropolitan Transportation Commission Public Involvement Procedures-MTC, San Francisco,US(2000)</i>	Нийтийн оролцооны хөтөлбөрт саявтар үнэлгээ хийсэн тайлангийн жишээ	http://www.mtc.ca.gov/whats_happening/outreach_eval.htm

МХТ-ийн арга хэрэгслүүд



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>Government Online Strategy-Australia(2000)</i>	Мэдээлэл үйлчилгээг онлайн түгээхэд шинэ технологи ашиглах талаар засгийн газарт зориулсан стратегийн хүрээ	http://govonlain.gov.au/projects/startegy/StrategicPriorities.htm
<i>Guida alle norme(Guide to Legislation)-Italian Council of Ministers</i>	Хууль тогтоомж болон хууль боловсруулах ажиллагааны эх сурвалжийн талаарх онлайн зааварчилга	http://www.governo.it/sez_guida/ricera_sito.html
<i>Questions and Answers On the Euro-European Commission</i>	Европын Холбооны шинэ мөнгөн тэмдэгтийн тухай албан ёсны 11 хэлээр хэвлэгдсэн харилцан оролцоот мэдээллийн сан	europea.eu.int/euro/quest

Мэдээлэл, зөвлөгөөн, идэвхтэй оролцооны МХТ-ийн арга хэрэгслүүд



Гарчиг	Тодорхойлолт	Эх сурвалжийн тухай
<i>Share Your Views with US! -Public Management Department, Finnish Ministry of Finance</i>	Тодорхой сэдвүүдийг хэлэлцэхээр иргэдийг урьсан онлайн нээлттэй хэлэлцүүлэг, суурь материал, холбоонууд	www.otakantaa.fi
<i>Guide du courrier Electronique (guide to Electronic Mail)- Interministerial Delegation On Stage Reform (DIRE), France</i>	Иргэдээс э-шуудан хүлээн авах, тэдэнд хариулах талаар төрийн албанд зориулсан зааварчилга	www.fonction-publique.gouv.fr/lactualite/lesgrandsdossiers/guidecourrielectronique2/dire/intro.htm